



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Лувсангийн ЭРДЭНЭЧИМЭГ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-05-55, Факс: 32-70-16
E-mail: erdenechimeg@parliament.mn
<http://www.parliament.mn>

2015.07.02 № 4/60199
танай _____-ны № _____-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын даргын 2015 оны 101 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн гаргасан дүгнэлтийг Танд хүргүүлж байна.

Дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүдэд тараах зөвшөөрөл олгоно уу.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Л.ЭРДЭНЭЧИМЭГ

Ажлын хэсгийн дүгнэлт

2015 оны 6 дугаар сарын 22

Улсын Их Хурлын Даргын 2015 оны 101 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг удирдамжийн дагуу Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах Консорциумтай байгуулахаар төлөвлөж буй Засгийн газраас 4 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Хамтын ажиллагааны гэрээ", "Хөрөнгө оруулалтын гэрээ", "Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлд төмөр замын суурь бүтэц барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх гэрээ" болон бусад шаардлагатай асуудлыг судалж, дараах дүгнэлт, шийдвэрийн төслийг бэлтгэн танилцуулж байна.

Дүгнэлтийг бэлтгэх явцдаа шаардлагатай асуудлаар холбогдох төрийн байгууллага болон холбогдох компаниас лавлагаа, мэдээлэл авсан болно. (Холбогдох лавлагаа, мэдээллийн хуулбарыг хавсаргаав)

Мөн Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах Консорциумтай байгуулах Хөрөнгө оруулалтын болон дагалдах бусад гэрээний тухай Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс болон Л. Эрдэнэчимэг тэргүүтэй Улсын Их Хурлын нэр бүхий 16 гишүүдээс Монгол Улсын сайд М. Энхсайханд асуулга тавьж хариулт авсан байна. Эдгээр асуулгад хариулсан М. Энхсайхан сайдын хариулт нь албан ёсны нотлох баримт болох тул энэхүү санал, дүгнэлтэд эх сурвалж болгож авсан болно. (Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн асуулга, УИХ-ын гишүүн Л. Эрдэнэчимэг тэргүүтэй нэр бүхий гишүүдийн асуулга болон М. Энхсайхан сайдын хариултыг хавсаргаав)

Консорциумтай байгуулахаар төлөвлөж буй Хамтын ажиллагааны Гэрээний "Талууд" гэсний 2 дахь хэсэгт болон Хөрөнгө оруулалтын гэрээний Талууд гэсний 5 дахь хэсэгт "Энержи Ресурс" ХХК-ийг "Төслийн компани" гэж заахаар томьёолжээ. Иймд цаашид энэхүү дүгнэлтэнд "Төслийн компани" гэдгийг "Энержи Ресурс" ХХК (товчилж ЭР) гэж тодорхой нэрээр нь бичнэ.

Оршил

"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Уурхайн үйл ажиллагааны тухай товч танилцуулга

"Эрдэнэс Таван толгой" ХК нь 2010 онд байгуулагдаж, Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрлийг "Эрдэнэс" МГЛ ХХК-иас шилжүүлэн авч уурхайн үйл ажиллагааг явуулж байна. Цанхийн зүүн хэсэгт 2010 оны 8 дугаар сарын 27-нд, Цанхийн баруун хэсэгт 2013 оны 2 дугаар сарын 16-нд уурхайн үйл ажиллагааг эхлүүлсэн.

Тавантолгойн нүүрсний орд нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг Улаан нуурын хөндийд Улаанбаатар хотоос өмнө зүгт 540 км, аймгийн төв Даланзадгадаас зүүн зүгт 90 км, Цогтцэций сумын төвөөс баруун өмнө зүгт 16км зайд орших ба нийт 220 хавтгай дөрвөлжин километр талбайг хамарна.

"Эрдэнэс Таван толгой" ХК нь MV-011943 (2,046.4 га), MV-016883 (700.39 га), MV-016881 (556.72 га), MV-016882 (2,447.13 га), MV-011953 (12,864.47 га), MV-011954 (22,901.37 га), MV-011955 (23,813.1 га), MV-011956 (3,151.92 га) тоот нийт 68481.5 га талбай бүхий 8 ширхэг ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг.

Тавантолгойн ордод Цанхи, Ухаахудаг, Бортээг, Ончхараат, Оорцог, Бортолгой гэсэн нүүрсний нөөцийн талбайнууд хамрагддаг. Эдгээрээс нарийвчилсан судалгааны ажил бүрэн хийгдэж, ашиглалтанд бэлтгэгдсэн нүүрсний нөөцийн талбай нь Цанхийн хэсэг юм.

Ордын нөөц:

Тус нүүрсний орд газар "Норвест" компанийн ЖОРК стандартанд дүйцүүлэн үнэлсэн үнэлгээ 7.4 тэрбум тн нүүрсний нөөцтэйгөөс 985.5 сая тн нь баттай, 2,986 сая тн нь бодитой ба үлдсэн 3,410.6 сая тн нь боломжит нөөц болно. Үүнээс 5.4 тэрбум тн нь коксжих нүүрс бөгөөд 1.9 тэрбум тн нь эрчим хүчний нүүрс болно.

- Тавантолгойн ордын "тавантолгой" формацийн нүүрс агуулагч хурдаст нүүрсний 0-XV хүртэл дугаартай, 1м-ээс 84 м хүрэх зузаантай нийт 16 давхарга агуулагдана.
- Цанхийн талбайн хэмжээнд нүүрсний 0-ээс IX хүртэлх 10 үе давхарга тархсан байдаг.
- Үйлдвэрийн ач холбогдолтой коксжих болон хагас коксжих нүүрсний давхраас нь 0, III, IV^{АЕ}, V, VIII^{АБВ}, IX^{АБВГ} гэсэн 6 давхарга юм.

Ордыг ашиглах Техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ):

Америкийн "Норвест" компани 2009 онд Цанхийн зүүн хэсгийг ашиглах ТЭЗҮ, 2011 онд Цанхийн баруун хэсгийг ашиглах урьдчилсан ТЭЗҮ-ийг тус тус боловсруулсан.

Цанхийн зүүн хэсгийг ашиглах ТЭЗҮ-ийг 2011 оны 4 дүгээр сард "Абсолют майнинг" ХХК, Цанхийн баруун хэсгийг ашиглах ТЭЗҮ-ийг 2012 оны 6 дугаар сард "Уул уурхайн хүрээлэн" тус тус боловсруулж "Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөл"-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан.

Цанхийн Зүүн хэсгийг ашиглах ил уурхайн Техник эдийн засгийн үзүүлэлтүүд:

- Ордын геологийн нөөц /A+B+C/ - 750.47 сая тн
- Жилийн хүчин чадал – 15.0 сая тн/жил
- Жилийн дундаж хөрс хуулалт – 43.5 сая м³
- Баяжуулах үйлдвэр (15 сая тн/жил)

Уурхай нь 5 дахь жилээс төслийн хүчин чадлаа эзэмшиж эхлэнэ. Ашиглалтын эхний 3 жилд нүүрсний IV давхаргад 4 дэх жилээс нүүрсний 0, III давхаргуудыг олборлож эхлэхээр тусгасан байна.

Цанхийн Баруун хэсгийг ашиглах ил уурхайн Техник эдийн засгийн үзүүлэлтүүд:

- Ордын геологийн нөөц /A+B+C/ - 814.1 сая тн
- Жилийн хүчин чадал – 20 сая тн/жил
- Жилийн дундаж хөрс хуулалт – 55 сая м³

Ашиглалтын эхний 3 жилд нүүрсний IV давхаргад, 4 дэх жилээс нүүрсний 0, III давхаргуудыг олборлож эхлэнэ.

Цанхийн зүүн уурхай

2010 оны 8 дугаар сард хөрс хуулалтын ажлыг эхлүүлэн, 2011 оноос Автсралийн "Макмахон" компани гэрээт олборлогчоор ажиллаж байна. Ашиглалтын үеийн дэд доголын өндөр 4м, үндсэн доголын өндөр 12м, доголын хажуугийн налуууг 55°. 2014 оны эцсийн байдлаар А, Б уурхайн талбай 130 га, хамгийн их гүн 1466 м-ийн түвшинд буюу 85м байна. Үндсэн гарах 3 траншейтай бөгөөд амнаас хойш хөрсийг 2-2.5 км, нүүрсийг 0.5-1.5км зайд тээвэрлэдэг.

2010 онд 545мян.м³ хөрс, 2011 онд 0.9 сая тн нүүрс, 3.8 сая м³ хөрс, 2012 онд 2.5 сая тн нүүрс, 8.5 сая м³ хөрс, 2013 онд 2.7 сая тн нүүрс, 9.2 сая м³ хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажил хийж гүйцэтгэсэн. 2014 оны байдлаар нийт 0.9 сая тн нүүрс олборлож, 4.6 сая м³ уулын цулын ажил хийж гүйцэтгээд байна. Цанхийн зүүн уурхайн олборлогчоор "ТТJVCO" ХХК ажилладаг бөгөөд 2014 оны 8-р сарын 14-нөөс гэрээний нөхцлийг сайжруулахаар олборлолтын үйл ажиллагааг түр зогсоосон.

Хэлэлцээрийн үр дүнд олборлолтын өртгийг 2 дахин бууруулж, ажлын гүйцэтгэлээр төлбөр тооцоог хийх гол зөвшилцөлд хүрсэн ба талууд олборлолтын үйл ажиллагааг дахин эхлүүлэхээр ажиллаж байна.

Уурхайд Liebherr, Catterpillar, Terex зэрэг үйлдвэрийн 5-36м³-ийн шанаганы багтаамж бүхий 8ш экскаватор, 55-240 тн-ын даацтай 20ш автосамосвалтай. Нүүрсний зах зээлийн сэргэх үед одоогийн хүчин чадлыг нэмэгдүүлж, жилд 15 сая тн нүүрс олборлох боломжтой юм.

Хүснэгт №1. Цанхийн зүүн уурхайн уулын ажлын гүйцэтгэл

Үзүүлэлт	2010		2011 он		2012 он		2013 он		2014 он		2015 он	
	Гүйцэтгэл	ТЭЗҮ	Гүйцэтгэл	ТЭЗҮ	Гүйцэтгэл	ТЭЗҮ	Гүйцэтгэл	ТЭЗҮ	Гүйцэтгэл	ТЭЗҮ	Гүйцэтгэл	ТЭЗҮ
Нүүрс олборлолт, сая тн	-	1	0.9	3	2.5	6	2.7	10	0.9	15	-	-

Хөрс хуулалт, сая м ³	0.5	3.3	3.8	10.3	8.5	20.6	9.2	43	4.0	48	-
Уулын цул, сая м ³	0.5	4	4.4	12.4	10.3	24.9	11.2	50.1	4.6	59.5	-
Кхх, м ³ /тн		3.3	4.2	3.4	3.4	3.4	3.4	4.3	4.4	3.2	-

Цанхийн баруун уурхай

Олборлолтын үйл ажиллагааг 2013 оны 2 дугаар сард эхлүүлсэн ба "Монгол уурхайчид" Түншлэл гэрээт олборлогчоор ажиллаж байна. Тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр ажилладаг. Хөрсний 2, нүүрсний 1 үндсэн траншейтай бөгөөд уурхайн амнаас баруун хойд зүгт нүүрсийг 1 км, хөрсийг 1.2 км зайд тус тус тээвэрлэдэг.

Ашиглалтын үеийн дэд доголын өндөр 4м, үндсэн доголын өндөр 12м, доголын хажуугийн налуу 55°. 2014 оны эцсийн байдлаар 90 га талбайг хамарч, хамгийн гүн нь 1466 м-ийн түвшинд буюу 60м гүнтэй байна.

Уурхайд Caterpillar, Liebherr, Komatsu, Hyundai зэрэг үйлдвэрийн 5-17м³-ийн шанаганы багтаамжтай 13ш экскаватор, 55-130тн-ын даацтай 57шавтосамосвал ажиллаж, сард 2-3 сая м³ уулын цулын ажил гүйцэтгэж байна.

Хүснэгт №2. Цанхийн Баруун уурхайн уулын ажлын гүйцэтгэл

Үзүүлэлт	2013 он		2014 он		2015 он	
	ТЭЗҮ	Гүйцэтгэл	ТЭЗҮ	Гүйцэтгэл	ТЭЗҮ	Гүйцэтгэл
Нүүрс олборлолт, сая тн	2	2.6	3.2	3.6	6	2.28
Хөрс хуулалт, сая м ³	3.2	10.4	4.7	10.2	11.2	9.17
Уулын цул, сая м ³	4.7	12.3	7.0	12.8	15.7	10.806
Кхх, м ³ /тн	1.6	4.1	1.5	2.8	1.8	4.01

Цанхийн Баруун ба Зүүн уурхайгаас 2014 оны I улиралд 139.8 мян.тн нүүрс олборлож, 774.2 мян.тн нүүрсийг борлуулсан бол 2015 оны I улирлын байдлаар 1,439.6 мян.тн нүүрс олборлож, 1,819.4 мян.тн нүүрсийг экспортлоод байна.

Нэг. Тавантолгойн ордыг ашиглах тухай асуудлаар Засгийн газраас өргөн барьсан Хамтын ажиллагааны гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээ, Төмөр замын концессийн гэрээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэх,

1.1 Хамтын ажиллагааны гэрээний тухай

Энэхүү "Хамтын ажиллагааны гэрээ"-г (цаашид Гэрээ гэнэ) Монгол Улсын төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" ХК (цаашид ЭТТ гэнэ) болон Люксембургийн "Монголиан Коал Корпораци"-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай, охин компани болох "Энержи Ресурс Корпораци" болон "Энержи Ресурс Корпораци"-ийн 100 хувийн охин компани болох "Энержи Ресурс" ХХК (цаашид ЭР гэнэ) болон Хятад улсын төрийн өмчит "Чайна Шенхуа Энержи компани лимитед" (цаашид Шенхуа гэнэ) компаниуд Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах зорилгоор байгуулахаар төсөл бэлтгэсэн байна.

Хамтын ажиллагааны гэрээний Талууд гэсний 4 дэх хэсэгт зааснаар "Энержи Ресурс Корпораци" болон "Чайна Шенхуа Энержи компани лимитед" нь ЭР-ийн хөрөнгө оруулагчид болж байна.

1.1.1 Гэрээний Угтвар нөхцлийн D хэсэг, гэрээний 1.1 (a), (b), 1.2 (a) заалт болон 6.1 (d) заалтуудаар ЭТТ нь Цанхийн ашиглалтын тусгай зөвшөөрөлөөр олгогдсон уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой бүх эрх болон зарим тодорхой үүрэг, уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой бүх эрхээ болон газар эзэмших эрхээ ЭР-д энэ гэрээний нийт хугацаагаар (Хамтын ажиллагааны гэрээний болон Хөрөнгө оруулалтын гэрээний үндсэн хугацаа 30 жил, сунгалт 30 жил) шилжүүлж байна.

ЭТТ-ийн ашиглалтын тусгай зөвшөөрөл ЭР-д шилжихгүй тул тусгай зөвшөөрөл эзэмшигч ЭТТ нь Ашигт малтмалын тухай хуулийн дагуу эрх, үүргээ хадгалах ёстой.

Иймд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой бүх эрхийг шилжүүлж авах дээр дурдсан заалтууд нь Ашигт малтмалын тухай хуулинд заасан ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэгтэй холбоотой заалтуудыг бүхэлд нь зөрчиж байна.

1.1.2 Хамтын ажиллагааны гэрээний 1.2 (a) заалтаар гэрээний хугацаанд ЭТТ нь Тавантолгойн газар эзэмших эрхээ ЭР-д үнэ төлбөргүй шилжүүлж байна. Мөн Хамтын ажиллагааны гэрээний 5.1 (j) заалт, Хөрөнгө оруулалтын Гэрээний 5.7 (a) заалтаар "төслийн бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах газар эзэмших, ашиглах эрхийг ЭР олж авах эрхтэй. Засгийн газар холбогдох байгууллагуудаараа дамжуулан газар эзэмших, ашиглах эрхийг ЭР болон түүний Хамааралтай этгээдэд олгоно" гэжээ.

ЭР нь Тавантолгойн газрыг эзэмших эрхийг авч байгаа нь Газрын тухай хуулийн 6.3 дахь хэсэг "Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харьяалалгүй хүн тодорхой зориулалт, хугацаа, болзол, гэрээний үндсэн

дээр хууль тогтоомжийн дагуу газар ашиглагч байж болно" гэсэн заалтыг зөрчиж байна.

Учир нь Хөрөнгө оруулалтын Гэрээний "Угтвар нөхцөл" (H)-д зааснаар "Чайна Шенхуа Оверсийс Девелопмент энд Инвестмент лимитед" болон дотоодын хөрөнгө оруулагч нар хамтарсан компани байгуулж одоо Ухаа худаг ордод үйл ажиллагаа явуулж байгаа "Энержи Ресурс" ХХК-ийг (ЭР) шууд ба шууд бусаар өмчлөхөөр заажээ.

Иймд ЭР нь Люксембургийн хөрөнгө оруулалттай ЭРК болон БНХАУ-ын хөрөнгө оруулалттай "Шенхуа" компанийн хөрөнгө оруулалттай гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болж зохион байгуулагдах учир Газрын тухай хуулийн 6.3 дахь заалтын дагуу газар эзэмших эрхгүй.

Тэгээд ч Хөрөнгө оруулалтын гэрээний 5.7 (a)-д заасан үйл ажиллагаа эрхлэх ЭР-н хамааралтай этгээдүүд нь гадаадын хөрөнгө оруулалттай этгээдүүд байвал мөн газар эзэмших эрхгүй.

1.1.3 Хамтын ажиллагааны Гэрээний "Угтвар нөхцөл" хэсгийн (E) болон 5.1 (q)-д зааснаар ЭТТ нь өөрийн Цанхийн уурхайд ажиллаж байгаа ажилчид, Цанхийн талбайтай холбоотой нүүрс борлуулах гэрээ, уул уурхайн үйлчилгээ үзүүлэх гэрээ болон бусад гэрээг хамааруулсан ЭТТ-н тодорхой үүрэг, эд хөрөнгийг ЭР-д шилжүүлж, "Эрх үүрэг шилжүүлэх гэрээ"-г тусад нь байгуулахаар тохирчээ.

Төрийн өмчит ЭТТ-ийн эд хөрөнгийг ЭР-т шилжүүлэх асуудал нь хувьчлалын асуудал үүсгэх болно. Иймд энэ заалт нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх заалт "Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдахад Засгийн газрын, төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг Төрийн өмчийн хорооны, бусад эд хөрөнгийг тухайн хуулийн этгээдийн шийдвэрээр гагцхүү дуудлага худалдаагаар худалдаж болно" гэснийг зөрчиж байна.

Мөн ЭТТ компанийн эд хөрөнгө, тодорхой үүрэг, ажилчдыг өөр компанид шилжүүлэх тухай асуудал Компанийн тухай хуулийн "Их хэмжээний хэлцэл" гэсэн 87 дугаар зүйлийн дагуу шийдвэрлэгдэх ёстой.

Компанийн хуулийн энэ заалтын дагуу ЭТТ компанийн шийдвэр гараагүй байхад Хамтын ажиллагааны болон Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хэлэлцээрийг хийсэн байна. Энэ шийдвэр гараагүй байхад "Эрх, үүрэг шилжүүлэх гэрээ" байгуулах нь Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийг бүхэлд нь зөрчинө.

1.1.4 Гэрээний 6.1 (i) заалтаар ЭР нь Цанхийн талбайгаас олборлосон нүүрсийг өмчлөх эрхтэй байхаар заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь заалтанд "газрын хэвлий, түүний баялаг төрийн өмч мөн" гэж заасан. Ашигт малтмалын тухай хуулийн 5.1-д "Монгол улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн

байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч мөн" гэж Үндсэн хуулийн заалтыг илүү тодруулан заасан байна.

Мөн Ашигт малтмалын тухай хуулийн 5.2 дахь заалтаар төр өмчлөгчийн хувьд энэ хуулинд заасан нөхцөл, шаардлага журмын дагуу ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрхийг бусад этгээдэд олгох эрхтэй гэж заасны дагуу Тавантолгойн Цанхийн ордын нүүрсийг ашиглах эрх ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчит ЭТТ компанид хадгалагдана. Ашигт малтмалын тухай хуулийн заалтаас харахад төр байгалийн баялагыг өмчлөх эрхийг шилжүүлэх эрхгүй бөгөөд зөвхөн ашиглах эрхийг тусгай зөвшөөрлөөр дамжуулан олгож байна.

Иймд Цанхийн талбайгаасолборлосон нүүрсийгЭР өмчлөх эрхгүй. Тэгээд ч Хөрөнгө оруулалтын гэрээний 29.6-д зааснаар "ЭР нь энэхүү Гэрээний дагуу бие даасан гэрээт гүйцэтгэгч байх" гэж заасан байна.

1.1.5 Гэрээний 5.1 (к) ЭР нь Ашигт малтмалын тухай хуулийн 35.3-т заасан бүх бичиг баримтыг ЭТТ-с өөртөө авахаар заасан нь Ашигт малтмалын тухай хуулийн 35.3 дахь заалттай зөрчилдөж байна. Тус заалтаар энэ бүх бичиг баримт нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид буюу ЭТТ-д өөрт нь хадгалагдах ёстой.

1.1.6 Гэрээний 5.1 (о)-д зааснаар Цанхийн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх зорилгоор ЭР нь ЭТТ-с олгосон итгэмжлэлгүйгээр аливаа санал, гомдол, нэхэмжлэлийг холбогдох төрийн болон эрх бүхий байгууллага, шүүх, албан тушаалтанд гаргах эрхтэй гэжээ.

Энэ нь Иргэний хуулийн "Төлөөлөл" гэсэн 7 дугаар бүлэгт заасан хуулийн дагуу итгэмжлэлийн үндсэн дээр үүсэх харилцааг бүхэлд нь зөрчиж байна.

Мөн ЭР нь ЭТТ-ээс олгосон итгэмжлэлгүйгээр шүүхэд санал гомдол гаргах эрхтэй гэсэн нь заалт болон ИХШХШТХ-ийн "Хэрэг шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлөх" гэсэн 35 дугаар зүйлийн 35.2 дахь заалт "Хуулийн этгээдийг төлөөлж байгаа этгээд өөрийн албан тушаал, эсхүл төлөөлөх эрх олгогдсоныг гэрчилсэн баримт бичгийг шүүхэд үзүүлнэ", мөн хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 заалт "Төлөөлөгчийн бүрэн эрхийг төлөөлүүлэгчээс бичгээр олгосон итгэмжлэл, бусад бичиг баримтаар тодорхойлно. Итгэмжлэлд зохигчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эдлэх эрхийн заримыг төлөөлөгчид эдлүүлэхгүй байхаар зааж болно.Итгэмжлэл нь Иргэний хуулийн 64.2-т заасан шаардлагыг хангасан байна" гэснийг тус тус зөрчиж байна.

1.1.7 Гэрээний 13 дугаар зүйлд зааснаар ЭТТ-ийн нэрийн өмнөөс, түүний орлож болон бусад байдлаар бичиг үйлдэх, зохих байгуулагад хүргүүлэх, уул уурхайн үйл ажиллагаа явуулах зорилгоор шаардлагатай бүх арга хэмжээ авах эрхийг ЭР итгэмжлэн өөртөө авч байна.

Энэ заалт ЭТТ компанийн бусад байгууллагатай харилцах хууль ёсны эрхийг хязгаарлаж байна. ЭТТ нь ашиглалтын тусгай зөвшөөрлөө ЭР-д шилжүүлээгүй тул Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашиглалтын тусгай

зөвшөөрөлтэй холбоотой эрх, үүргээ өөрөө хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагын өмнө хариуцлага хүлээнэ.

ЭР энэ эрхийг өөртөө шилжүүлж авч байгаа нь шууд бусаар ЭТТ-н ашиглалтын тусгай зөвшөөрлийг өөрийн нэр дээр шилжүүлж авсантай адил юм.

Энэ Гэрээг байгуулснаар ЭТТ нь татан буугдахгүй бөгөөд хууль ёсны эрх зүйн чадамжаа хадгална.Тиймээс өөрийн нэрийн өмнөөс түүнийг орлож, түүний нэрийн өмнөөс шаардлагатай бүх арга хэмжээ авах эрх олгох шаардлагагүй.

1.1.8 Гэрээний 6.1 (j)-д зааснаар ЭТТ нь аливаа зөвшөөрөл, гарын үсэг, тамга тэмдэг, эрх хэмжээ, итгэмжлэл, баримт бичиг, мэдээлэл өгөх, бусад байдлаар хамтран ажиллах зэргээр шаардлагатай бүхий л захиргааны болон техникийн дэмжлэг хамтын ажиллагааг нэн даруй аливаа болзол, нөхцөлгүйгээр ЭР-т үзүүлэх үүрэг хүлээжээ.

Энэ заалтаар ЭР нь ЭТТ компанийг удирдлага, менежментийн хувьд чадамжгүй болгож байна. Мөн энэ заалт нь Компанийн тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулиар ЭТТ-д олгогдсон хууль ёсны эрх хэмжээнд халдсан хүлээн зөвшөөрч болохгүй заалтууд байна. Тэр тусмаа аливаа болзол, нөхцөлгүй гэсэн шаардлагыг нь хэт нэг талын хүсэл зоргийг тулгасан бизнесийн эрх тэгш хамтын ажиллагааны зарчимд харшилж байна.

1.1.9 Гэрээний 8.1 (b)-д "ЭР болон Хөрөнгө оруулагчид нь хөрөнгө босгох зорилгоор энэ гэрээний дагуу олгогдсонэрх, ашиг сонирхол, үр ашгаа Хөрөнгө оруулагчид эсхүл Санхүүжүүлэгчид барьцаалах замаар шилжүүлэх эрхтэй" гэсэн байна.


Энэ Гэрээний хамгийн ноцтой бөгөөд Засгийн газар болон ЭТТ хүлээн зөвшөөрч болохгүй заалт болно.

Гэрээний Угтвар нөхцлийн D хэсэг, гэрээний 1.1 (a) , (b), 1.2 (a) заалт болон 6.1 (d) заалтуудаар ЭТТ нь Цанхийн ашиглалтын тусгай зөвшөөрөлөөр олгогдсон уул уурхайн үйл ажиллагаатайхолбоотой бүх эрх болон зарим тодорхой үүрэг, уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой бүх эрхээ болон газар эзэмших эрхээ ЭР-д энэ гэрээний нийт хугацаагаар (Хамтын ажиллагааны гэрээний болон Хөрөнгө оруулалтын гэрээний үндсэн хугацаа 30 жил, сунгалт 30 жил) шилжүүлж байна.

Мөн Гэрээний 5.1 (e) болон 6.1 (i) заалтуудад ЭР нь Цанхийн талбайгаас олборлосон, боловсруулсан (угаасан нүүрс) нүүрсийг өмчлөх эрхтэй байхаар заажээ. Энэ бүх эрх, ашиг сонирхлоо Нэгд, Хөрөнгө оруулагч нар, Хоёрт, Санхүүжүүлэгч нарт барьцаалан шилжүүлэх эрхтэй болж байна.

Энэ гэрээгээр бол Хөрөнгө оруулагч нь Люксембургийн "Монголиан Коал корпораци"-ийн 100 хувийн охин компани "Энержи Ресурс Корпораци" болон Хятадын төрийн өмчит "Чайна Шенхуа Энержи лимитед" компаниуд юм.

Хөрөнгө оруулалтын Гэрээний 30.1 (g)-д зааснаар Санхүүжүүлэгч гэдэг нь ЭР-т зээл олгож байгаа БНХАУ болон Япон улсын эскпортын зээлийн агентлагууд, хөгжлийн банкууд, арилжааны банкууд болон олон талт санхүүгийн



байгууллага зэрэг олон улсын хөрөнгө оруулагч эсвэл банк, санхүүгийн байгууллагыг ойлгоно гэж тодорхойлсон байна.

Эхнээсээ Гэрээнд ингэж барьцаалан шилжүүлэх эрх олгосон заалт хийж байгаа нь ЭР нь цаашдаа ийм үйл ажиллагаа хийх зорилготой, ийм аргаар Тавантолгойн ордыг бусдад шилжүүлэхээр урьдчилан төлөвлөсөн байна гэж дүгнэж байна.

Өөрөөр хэлбэл, ЭР нь өрийн барьцаанд гэрээний дагуу олж авч байгаа эрх, ашиг сонирхол, үр ашгаа бусдад шилжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд ийнхүү шилжүүлэн авахаар төлөвлөсөн байна гэж дүгнэж байна. Учир нь ЭР нь Хонконг, Люксембург, Монгол зэрэг улсад байдаг охин компаниар нь дамжуулаад Кайманы аралд бүртгэлтэй MMC компанийн өмчлөлд байдаг бөгөөд 2015 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн байдлаар MMC нь олон улсынбанк, санхүүгийн байгууллагад 570 сая ам.долларын өртэй, бонд гаргасан 600 сая ам.долларын өртэй байна. Энэ компанийн нийт өр 1 тэрбум 170 сая ам.доллар байна. Энэ ерөндөө Монгол улсад байгаа ЭР-ийн нүүрс угаах үйлдвэр, цахилгаан станц, эд хөрөнгө, бэлэн мөнгө болон ЭР-ийг өмчилдөг Хонконг дахь охин компани "Mongolian Coal Corporation", Люксембург дахь "Mongolina Coal Corporation" S.A.R.L компанийн хувьцааг барьцаалсан байна. (Энэ тухай дүгнэлтийн Барьцаалах эрхийн тухай гэсэн 14.7 дахь хэсэгт тодорхой тайлбарласан болно)

Гэтэл Гэрээний 8.2 (b) заалтаар Тавантолгойн ордыг хууль ёсны эзэмшигч болох төрийн өмчит ЭТТ компанид аливаа барьцааны эрх үүсгэхийг хориглосон нь заалт нь Ашигт малтмалын тухай хуулийн 51.1 дэх заалттай зөрчилдөж байна. Хуулийн энэ заалтын дагуу ЭТТ нь тусгай зөвшөөрлөө энэ хуульд заасан шаардлагын дагуу буюу байгууллагад тухайн ордын үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор банк, банк бус санхүүгийн байгууллагад барьцаалах эрхтэй.

1.1.10 Гэрээний 8.2 (c) заалтаар хэрэв ЭТТ нь Цанхийн ашиглалтын тусгай зөвшөөрлөө Гуравдагч этгээдэд худалдах, шилжүүлэх, аливаа байдлаар захиран зарцуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд ЭР нь өөртөө шилжүүлэн авах санал гаргах давуу эрхтэй байна.

Гэрээний энэ заалт нь Ашигт малтмалын тухай хуулийн 49.1 болон 49.3 дахь заалтуудтай зөрчилдөж байна. Хуулийн эдгээр заалтаар тусгай зөвшөөрөл эзэмшигч буюу ЭТТ нь зөвхөн нэгдэж, нийлэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан тохиолдолд шинээр бий болсон эрх, үүрэг хүлээн авагчид, түүний хараат, охин компани нь толгой компанидаа тусгай зөвшөөрлийг шилжүүлэх эсвэл уурхайгаа худалдсан тохиолдолд тусгай зөвшөөрлөө шилжүүлэх эрхтэй байна.

Тэгээд ч "Тавантолгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын 1-ийн а/-д "Төрийн өмчит "Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн эзэмшилд байгаа Таван толгойн ордын ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг хөрөнгө оруулагчийн мэдэлд шилжүүлэхгүйгээр "Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээ"-ний хүрээнд бүрэн ашиглуулах" гэж заасантай зөрчилдөх болно.

Тавантолгойн ордын ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг шилжүүлэхгүй байх нь Хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах гол нөхцөл юм. Тиймээс Гэрээнд ийм заалт тусгах шаардлагагүй бөгөөд тусгай зөвшөөрөл ЭР-д ямар нэгэн байдлаар шилжсэн тохиролдолд уралдаант шалгаруулалтын гол нөхцөл зөрчигдөх болно.

1.1.11 Гэрээний 8.2 (d)-ийн (v)-д ЭТТ нь Цанхийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг зөвхөн бүхэлд нь шилжүүлэх бөгөөд хэсэглэн шилжүүлэхгүй гэсэн заалтаар ЭТТ-н хууль ёсны эрхийг хязгаарласан байна.

Цанхи нь баруун, зүүн хоёр хэсэгтэй бөгөөд ЭТТ нь зах, зээлийн нөхцөлтэй уялдуулан өөрийн эрх хэмжээнд зохицуулалт хийх эрхийг хориглосон байна. Энэ заалт нь Ашигт малтмалын тухай хуулийн Тусгай зөвшөөрөл шилжүүлэх гэсэн 49 дүгээр зүйлийн 49.1 болон Тусгай зөвшөөрлөөр олгогдсон газрын тодорхой хэсгийг шилжүүлэх гэсэн 50 дугаар зүйлийн 50.1 дэх заалтыг зөрчиж байна.

1.2 Хөрөнгө оруулалтын гэрээний тухай

Энэхүү "Хөрөнгө оруулалтын гэрээ"-г (цаашид Гэрээ гэнэ) Монгол Улсын Засгийн газар, төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" ХК (цаашид ЭТТ гэнэ) болон Люксембургийн "Монголиан Коал корпораци"-ийн 100 хувийн охин компани "Энержи Ресурс Корпораци" болон "Энержи Ресурс Корпораци"-ийн 100 хувийн охин компани болох "Энержи Ресурс" ХХК (цаашид ЭР гэнэ) Хятад улсын төрийн өмчит "Чайна Шенхуа Энержи компани" лимитед (цаашид Шенхуа гэнэ) компаниуд Тавантолгойн ордыг ашиглах зорилгоор байгуулахаар төсөл бэлтгэсэн байна.

1.2.1 Хөрөнгө оруулалтын Гэрээний 2.1 (c) болон (d)-д зааснаар ЭР нь уулын ажлын нарийвчилсан төлөвлөгөө, барилгын болон уул уурхайн үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалтын нөхцлийг тодорхойлж, уул уурхайн үйл ажиллагааны хүрээг тодорхойлох болон тооцоолол, уурхай хөгжүүлэх, хайгуул хийх төлөвлөгөө гаргах, тайланг бие даан өөрийн үзэмжээр гаргах, төслийн бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг гаргах, шаардлагатай бүх арга хэмжээг авах бүрэн эрхтэй байхаар заажээ.

Мөн ЭР нь Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах ТЭЗҮ боловсруулах, түүнд өөрчлөлт, нэмэлт хийх, уурхайн нарийвчилсан төлөвлөгөө, бүтээн байгуулалтын хөтөлбөр, уул уурхайн үйл ажиллагааны болон барилга угсралтын зардлыг тодорхойлох, хөрөнгө оруулалтын болзол нөхцлийг тогтоох, Тавантолгойн ордоос боловсруулсан бүтээгдэхүүн болон олборлосон нүүрсээ экспортлох, худалдах, тээвэрлэх, худалдах маркетинг хийх бүх ажиллагааг бие даан зохион байгуулах эрхтэй гэжээ. (Хөрөнгө оруулалтын гэрээний 5.1 (b), Хамтын ажиллагааны гэрээний 5.1 (d), (n) заалт)

Мөн ЭР нь Цанхийн талбайгаас аль ч жилд олборлох, боловсруулах бүтээгдэхүүний тоо хэмжээ болон бүтээгдэхүүн нийлүүлэх зах зээлийг сонгох, нүүрс боловсруулах зардал, үнэлгээг тодорхойлох, борлуулах, бүтээгдэхүүний тоо хэмжээ, худалдах үнийг тогтоох, тээврийн давтамж, тээвэрлэлтийн хэлцэл болон арилжааны бусад нөхцлийг тодорхойлох зэрэг

бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой шийдвэрийг дангаараа бие даан тодорхойлох, бие даан ажиллах эрхтэй байна. (Хөрөнгө оруулалтын гэрээ 2.4 (b) болон 2.5 (b) заалт)

Эдгээр заалт нь Ашигт малтмалын тухай хуулийн 48.6 дахь заалтыг зөрчиж байна. Учир нь 48.6-д зааснаар ТЭЗҮ хийх болон уулын ажлын төлөвлөгөө хийх, нөөцийн зэрэглэлийг ахиулах ашиглалтын хайгуул хийх, тайлан гаргах эрх нь тусгай зөвшөөрөл эзэмшигч буюу ЭТТ эрх хэмжээнд байхаар хуульчлагдсан байна.

Эдгээр заалтуудаас харахад ЭР нь гэрээний хугацаанд төслийн зардлыг нэмж тооцох, ТЭЗҮ-д нэмэлт, өөрчлөлт хийснээр хөрөнгө оруулалтаа өсгөх, бууруулах зэргийг дангаараа шийдвэрлэх эрх эдэлж байна. Ялангуяа хайгуулийн ажлын зардлаа хэт өндөр гаргаж, хөрөнгө оруулалтаа нөхөх боломжгүй гэдэг байдлаар ямар ч хугацаагаар төслийн ЭР нь өөрийн хяналтад байлгах боломж олгож байна. Гэрээний заалтуудаас харахад ЭР-ийн энэхүү үйл ажиллагаанд Засгийн газар болон ЭТТ зүгээр ямар ч хяналт тавих боломжгүй байна.

1.2.2 Хөрөнгө оруулалтын Гэрээний төмөр замын суурь бүтэц байгуулах гэсэн 2.6 дугаар зүйлд зааснаар Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх болон төмөр замын тээврийн үйл ажиллагаа эрхлэх онцгой эрхийг ЭР нь 30 жил 100% өмчилнө.

Төмөр замын өмчлөлийн 51%-ийг 30 жилийн дараа төрд үнэгүй шилжүүлж, 49% хувийг төрд худалдаж болно гэсэн нь Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2 дахь заалттай нийцэхгүй байна.

Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2-т "Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтцийг төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байхаар, эсхүл түүний өмчлөлд ашиглалтын тодорхой хугацааны дараа шилжүүлэх нөхцөлөөр шинээр байгуулж болох бөгөөд эдгээр суурь бүтэц, төмөр замын шугамын чигийг Засгийн газар тогтооно" гэж заасан.

Хуулийн энэ заалтаар шинээр барьсан төмөр замын суурь бүтцийг ашиглалтын тодорхой хугацааны дараа төрд шилжүүлэхээр заасан нь **бүрэн шилжүүлэх** агуулгатай байна. Иймд ЭР нь Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг төрд 100% шилжүүлэх ёстой. Өөрөөр хэлбэл, Концесс эзэмших эрх авч байгаа "Энержи Ресурс Рэйл" ХХК (ЭРР) нь төмөр замын 49 хувийг авч үлдээд, төрд худалдах эрхгүй.

Учир нь Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 121 дүгээр тогтоолын 1 дүгээр заалтаар улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтэц гэж тогтоосон байна.

Иймд Хөрөнгө оруулалтын Гэрээний төмөр замын суурь бүтэц байгуулах гэсэн 2.6 дугаар зүйлд зааснаар Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх болон төмөр замын тээврийн үйл ажиллагаа эрхлэх онцгой эрхийг ЭРР нь

30 жил 100% өмчлөх заалт нь Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын баримт бичгийг баталсан 2010 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн 32 дугаар тогтоолын 2-ын 2/эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой шинээр барих төмөр замын суурь бүтцийг Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2-т заасны дагуу төрийн өмчид байлгах" гэж заасныг зөрчиж байна.

1.2.3 Хөрөнгө оруулалтын Гэрээний 2.7 (a) болон (b) заалтаар ЭР нь төслийн хүрээнд байгуулах эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах байгууламж болон ус хангамжийн дэд бүтэц, байгууламжийг барьж, өмчилж, ажиллуулахаар заасан байна.

Эдгээр заалтаар ЭР нь концесс эзэмших эрх авч байх бөгөөд энэ асуудал гэрээгээр шийдэгдэхгүй. Концессийн хуулийн дагуу Засгийн газрын шийдвэр гарах ёстой.

Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлээгүй концессийн зүйлийг энэ гэрээгээр олгох нь Концессийн тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг зөрчиж, Засгийн газрын бүрэн эрхэд халдаж байна.

1.2.4 Хөрөнгө оруулалтын Гэрээний 5.3 (b) болон Хамтын ажиллагааны Гэрээний 8.2 (c) заалтаар хэрэв ЭТТ нь Цанхийн ашиглалтын тусгай зөвшөөрлөө Гуравдагч этгээдэд шилжүүлэх, аливаа хэлбэрээр захиран зарцуулах бол ЭР нь өөртөө шилжүүлэн авах санал гаргах давуу эрхтэй байна.

Гэрээний эдгээр заалт нь Ашигт малтмалын тухай хуулийн 49.1 болон 49.3 дахь заалтуудтай зөрчилдөж байна.

Хуулийн эдгээр заалтаар тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвхөн нэгдэж нийлэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан тохиолдолд шинээр бий болсон эрх, үүрэг хүлээн авагчид, түүний хараат, охин компани нь толгой компанидаа тусгай зөвшөөрлийг шилжүүлэх эсвэл уурхайгаа худалдсан тохиолдолд тусгай зөвшөөрлөө шилжүүлэх эрхтэй байхаар зохицуулсан байна.

Тэгээд ч "Тавантолгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын 1-ийн а/-д "Төрийн өмчит "Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн эзэмшилд байгаа Таван толгойн ордын ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг хөрөнгө оруулагчийн мэдэлд шилжүүлэхгүйгээр "Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээ"-ний хүрээнд бүрэн ашиглуулах" гэж заасантай зөрчилдөх болно.

Тавантолгойн ордын ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг шилжүүлэхгүй байх нь Хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах гол нөхцөл юм. Тиймээс Гэрээнд ийм заалт тусгах шаардлагагүй бөгөөд тусгай зөвшөөрөл ЭР-д ямар нэгэн байдлаар шилжсэн тохиолдолд уралдаант шалгаруулалтын гол нөхцөл зөрчигдөх болно.

Мөн Хамтын ажиллагааны Гэрээний 8.2 (c)-д зааснаар худалдах үнийг талууд зөвшилцөнө, үнэ тохиролгүй бол Олон улсын эрх бүхий мэргэжлийн байгууллагаар үнэлүүлнэ, Тэгээд тэр үнээр ЭР худалдан авах эрхтэй болно гэжээ. Энэ заалтаас харахад Олон улсын мэргэжлийн байгууллагын үнэлгээ

тогтоож байгаа хэлбэр нь зөв боловч далд утгаараа тухайн тогтоосон үнээр ЭТТ заавал, зөвхөн ЭР-д тусгай зөвшөөрлөө зарах үүрэг хүлээлгэсэн байна. Энэ нь Хамтын ажиллагааны Гэрээний 8.2 (b) болон 8.2 (c) хэсэгт зааснаар "Төслийн компанийн тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг хангахгүйгээр аливаа Гуравдагч этгээдэд Цанхийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг худалдах, шилжүүлэх, аливаа байдлаар захиран зарцуулахгүй" гэснээс тодорхой харагдаж байна"

Тэгээд ч Хамтын ажиллагааны гэрээний 8.2 (d)-ийн (i) болон (ii) дах заалтуудын нөхцлөөс харахад ЭТТ нь ашиглалтын тусгай зөвшөөрлөө Гуравдагч этгээд зарах, шилжүүлэх боломжгүй байхаар зохицуулжээ. Тухайлбал, уг заалтуудад ЭТТ болон тусгай зөвшөөрөл шилжүүлэн авагч этгээдийн хооронд бичгээр байгуулсан гэрээний хуулбарыг ЭР-д хүргүүлнэ. Эрх шилжүүлэн авагч нь ЭТТ-ын энэ гэрээ болон Хөрөнгө оруулалтын гэрээгээр хүлээсэн үүргийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсан баримт бичгийг ЭР-н санал болгосон агуулга, хэлбэрээр ЭР-тай байгуулна гэжээ. ЭР нь нөгөө талдаа хүлээн зөвшөөрөх аргагүй нөхцөл, болзол бүхий баримт бичгийг зориуд санал болгоход л энэ хэлцэл биелэгдэхгүй.

1.2.5 Хөрөнгө оруулалтын Гэрээний 10.1 (b) болон Хамтын ажиллагааны Гэрээний 5.1 (e) болон 6.1 (i) заалтуудад ЭР нь Цанхийн талбайгаас олборлосон, боловсруулсан нүүрсийг өмчлөх эрхтэй байхаар заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь заалтанд "газрын хэвлий, түүний баялаг төрийн өмч мөн" гэж заасан. Ашигт малтмалын тухай хуулийн 5.1-д "Монгол улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч мөн" гэж Үндсэн хуулийн заалтыг илүү тодруулан заасан байна.

Мөн Ашигт малтмалын тухай хуулийн 5.2 дахь заалтаар төр өмчлөгчийн хувьд энэ хуулинд заасан нөхцөл, шаардлага журмын дагуу ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрхийг бусад этгээдэд олгох эрхтэй гэж заасны дагуу Тавантолгойн Цанхийн ордын нүүрсийг ашиглах эрх ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчит ЭТТ компанид хадгалагдана.

Ашигт малтмалын тухай хуулийн заалтаас харахад төр байгалийн баялагыг өмчлөх эрхийг шилжүүлэх эрхгүй бөгөөд зөвхөн ашиглах эрхийг тусгай зөвшөөрлөөр дамжуулан олгож байна.

Иймд Цанхийн талбайгаас олборлосон нүүрсийг ЭР өмчлөх эрхгүй. Тэгээд ч Хөрөнгө оруулалтын гэрээний 29.6-д зааснаар "ЭР нь энэхүү Гэрээний дагуу бие даасан гэрээт гүйцэтгэгч байх" гэж заасан байна.

1.3 Төмөр замын суурь бүтэц "барих-ашиглах-өмчлөх-шилжүүлэх" концессийн гэрээний тухай

Энэхүү "Төмөр замын суурь бүтэц барих-ашиглах-өмчлөх-шилжүүлэх концессийн гэрээ"-г (цаашид Концессийн гэрээ гэнэ)(1) Монгол Улсын Засгийн газар болон Люксембургийн "Монголиан Коал корпораци"-ийн 100 хувийн охин компани (2) "Энержи Ресурс Корпораци" (цаашид ЭРК гэнэ) болон "Энержи

Ресурс Корпораци"-ийн 100 хувийн охин компани болох "Энержи Ресурс" ХХК-ийн охин компани (3) "Энержи Ресурс Рэйл" ХХК (цаашид ЭРР гэнэ) болон Хятад улсын төрийн өмчит (4) "Чайна Шенхуа Энержи компани" лимитед (цаашид Шенхуа гэнэ) гэсэн 4 субъектийн хооронд байгуулахаар төсөл бэлтгэсэн байна.

Мөн Хөрөнгө оруулалтын гэрээний Гэрээний 10.4-т зааснаар Концесс эзэмшигч (Концесс эзэмшигч нь ЭРР) нь Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг өмчлөх бөгөөд тус Гэрээний Хавсралт 4-т газартай холбоотой эрхийг тусгайлан зохицуулсан байна. Энд зааснаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын концессийн газрыг 60 жилийн хугацаатай, сунгах нөхцөлтэйгээр олгож байна.

Гэтэл энэ чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрөл болон концессийн эрхийг Монгол Улсын төрийн өмчит "МТЗ" ХК эзэмшиж байна.

Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2-т "Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтцийг төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байхаар эсхүлтүүний өмчлөлд ашиглалтын тодорхой хугацааны дараа шилжүүлэх нөхцөлөөр шинээр байгуулж болох бөгөөд эдгээр суурь бүтэц, төмөр замын шугамын чигийг Засгийн газар тогтооно" гэж заасан.

Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын бичиг баримтыг баталсан Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн 32 дугаар тогтоолын 2-ын 2/-т "эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой шинээр барих төмөр замын суурь бүтцийг Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2-т заасны дагуу төрийн өмчид байлгах" гэж заасан байна.

Хуулийн энэ заалтаар улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын суурь бүтцийн өмчлөл нь төрийн өмчит буюу төрийн өмч давамгайлсан компанид байхаар, бусад этгээд шинээр бариад, тодорхой хугацааны дараа шилжүүлэх нөхцөлтэй ашиглах гэсэн 2 хувилбартай байна.

Төмөр замын тээврийн тухай хуулийн энэ заалтанд нийцүүлэн Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 2011 онд 35/32 дугаар Зөвлөмж, 2012 онд 07/04 дүгээр зөвлөмж тус тус гаргажээ. (Зөвлөмжийн хуулбарыг хавсаргае)

2011 оны 35/32 дугаар зөвлөмжийн 1-д "Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д шинээр барихаар заасан төмөр замын суурь бүтцийн концессыг төрийн өмчит, эсхүл төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдэд Концессийн хуулийн 17.1.1-д¹ заасны журмын дагуу олгох" гэжээ.

¹Концессийн тухай хуулийн 17.1 "Дор дурдсан тохиолдолд шууд гэрээ байгуулах аргаар концессыг олгож болно": 17.1.1 "уралдаант шалгаруулалт явуулах нь үндэсний аюулгүй байдалд харшилна гэж үзсэн" гэжээ.

Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2 дахь заалт болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Зөвлөмжийн дагуу Засгийн газар 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 121 дүгээр тогтоол гаргаж 1 болон 2 дахь үе шатанд баригдах /Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам ороод/ төмөр замын суурь бүтцийг улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтэц гэж тогтоож, төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг 100 хувийн төрийн өмчит "МТЗ" ХК-д олгожээ. (Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоолыг хавсаргае)

Мөн Засгийн газрын 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 28 дугаар тогтоолоор Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод заасан 1.2 дугаар үе шатанд барих (Ухаа худаг-Гашуунсухайтын чиглэл ороод) төмөр замын суурь бүтцийг "барих-ашиглах-шилжүүлэх" концессийг "Монголын төмөр зам"ХК-д олгосон байна.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсад шинээр баригдах төмөр замын суурь бүтэц барих зөвшөөрөл болон концессийг уралдаант шалгаруулалтаар олгох нь үндэсний аюулгүй байдалд харшилна гэж үзэж Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл үзэж зөвлөмж гаргасан бөгөөд түүнийг үндэслэн Засгийн газар шинээр төмөр зам барих тусгай зөвшөөрөл болон төмөр замын суурь бүтцийн концессийг төрийн өмчит "МТЗ" ХК-д олгосон байна.


Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж, Улсын Их Хурлын дарга Д. Дэмбэрэл, Ерөнхий сайд С. Батболд нарын санал нэгтгэйгээр батлан гаргасан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 35/32 болон 2012 оны 07/04 дүгээр Зөвлөмжүүд өнөөдөр хүчин төгөлдөр байна. Мөн энэ чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл болон концессийг "МТЗ" ХК-д олгосон Засгийн газрын 2012 оны 121 болон 2013 оны 28 дугаар дүгээр тогтоолууд өнөөдөр хүчин төгөлдөр хэвээр байна.

Мөн 2015 оны 2 дугаар сарын 16-ны өдөр Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөл Тавантолгойн асуудлаар хуралдаж, Тавантолгойн гэрээг Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Монгол Улсын холбогдох бусад хууль, тогтоомжинд нийцүүлэн байгуулах, Тавантолгойн ордыг ашиглах асуудлаар өмнө нь гарсан Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн уялдааг сайжруулах үүрэг өгсөн.

Засгийн газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Засгийн газар... Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх арга хэмжээ авч, энэ тухай Ерөнхийлөгчид мэдээлж байна" гэснийг дагуу Засгийн газар нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийг биелүүлэх үүрэгтэй.

Иймд Засгийн газар Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих эрх болон концессийн эрхийг төрийн өмчит "МТЗ" ХК-аас шилжүүлэн авч бусад хуулийн этгээдэд шилжүүлсэн шийдвэр гаргах хуулийн үндэслэлгүй байна.

"МТЗ" ХК-ийн Гүйцэтгэх захирал Д. Ганбат 2015 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 01/281 албан тоотоор энэ тухай Монгол Улсын Сайд М. Энхсайхан болон



УИХ, Засгийн газрын холбогдох албан тушаалтанд мэдэгдсэн байна. ("МТЗ" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2015 оны 01/281 дугаар албан тоотыг хавсаргае)

Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг Тавантолгойн уралдаант шалгаруулалтын нэг хэсэг болгон гадаадын хөрөнгө оруулалттай, хувийн компанид шилжүүлэх нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 35/32 дугаар болон 2015 оны 04/03 дугаар зөвлөмжүүд, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогыг баталсан УИХ-ын 2010 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн 32 дугаар тогтоолын 2-ын 2 дахь заалт, Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 121, 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 28 дугаар тогтоолыг тус тус зөрчиж байна.

Хоёр. Гэрээ нь тухайн асуудлаар гарсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Улсын Их Хурлын болон холбогдох Байнгын хороодын тогтоолтой нийцэж байгаа эсэх,

2.1 "Энержи Ресурс" ХХК (ЭР), "Энержи Ресурс корпораци" (ЭРК), "Чайна Шенхуа Энержи компани" лимитед (Шенхуа) компаниуд хамтран байгуулж байгаа Төслийн компани нь одоо Ухаа худаг ордод үйл ажиллагаа явуулж байгаа "Энержи Ресурс" ХХК байна. Өөрөөр хэлбэл, ЭРК нь өөрийн охин компани болох "Энержи Ресурс" компанийг төслийн компани болгон хувиргаж байна.

Төслийн болон хувирч байгаа "Энержи Ресурс" компанийн 51%-ийг "Энержи Ресурс корпораци"(ЭРК), 49%-ийг "Чайна Шенхуа Оверсийс Девелопмент & Инвестмент компани" лимитед (Шенхуа) гэсэн харьцаатай эзэмшинэ. (Хөрөнгө оруулалтын Гэрээний Угтвар нөхцлийн (Н) заалт)

ЭР-н Хөрөнгө оруулагч болох "Энержи Ресурс Корпораци" нь 100 хувь Люксембургийн хөрөнгө оруулагчийн мэдэлд байх тул Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.5 дахь заалт "гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуйн нэгжийг хэлнэ гэсний дагуу ЭР нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байна.

"Энержи Ресурс Корпораци" нь 100 хувь гадаадын хөрөнгө оруулагчийн мэдэлд, "Шенхуа" нь гадаадын хуулийн этгээд байх тул эдгээрийн хамтран өмчлөх Тавантолгойн ордыг ашиглах Төслийн компани гэх ЭР нь шууд болон шууд бусаар гадаадын хуулийн этгээдүүдийн 100 хувь хяналтанд орж байна.

Энэ нь Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн 40 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт "Тавантолгойн нүүрсний ордыг хамтарч ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үндсэн зарчим, удирдамж"-ийн 2-ийн 1 дэх заалт "Ордыг түшиглэн байгуулагдах хувьцаат компанийн Монголын талын оролцоог 51 хувиас доошгүй байх хувилбар"-ыг судалж үзэх" гэснийг зөрчиж байна.

Мөн УИХ-ын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 39 дүгээр тогтоолын 1-ийн 1/ "Тавантолгойн нүүрсний ордод төрийн өмчит компани ашиглалтын үйл ажиллагаа явуулах, ..." гэснийг шууд зөрчиж байна.

Улсын Их хурлын 2008 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн 40 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Тавантолгойн нүүрсний ордыг хамтарч ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үндсэн зарчим, удирдамжийн хэрэгжилтийг доор харуулав.

**ТАВАН ТОЛГОЙН НҮҮРСНИЙ ОРДЫГ ХАМТАРЧ
АШИГЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ
БАЙГУУЛАХ ҮНДСЭН ЗАРЧИМ, УДИРДАМЖ
ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ**

No	Тавантолгойн нүүрсний ордыг хамтарч ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үндсэн зарчим, удирдамжийн заалтууд	Засгийн газрын 268 дугаар тогтоолоор зарласан уралдаант шалгаруулалтанд тэнцсэн Консорциумтай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл
1	Гэрээг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудад нийцүүлж хийх.	Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжуудыг зөрсөн.
2	Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулахдаа дараахь хувилбаруудыг судлан үзэх: 1/Ордыг түшиглэн байгуулагдах хувьцаат компанийн Монголын талын оролцоог 51 хувиас доошгүй байх хувилбар; 2/Бүтээгдэхүүн хуваах зарчимд тулгуурласан хувилбар.	Люксембургийн 100 хувийн хөрөнгө оруулалттай "Энержи РесурсКорпораци" Тавантолгойн ордыг ашиглах төслийн компанийн 51 хувийг эзэмшиж байгаа нь монголын талын оролцоо 51 хувиас доошгүй байх шаардлагыг хангахгүй байна. Бүтээгдэхүүн хуваах зарчим тохироогүй
3	Гэрээнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, албан татварын тодорхой хэсгийг урьдчилан авахаар тохиролцох.	Урьдчилгаа төлбөр 200 сая ам.долларыг жилийн 4.5 хувийн хүүтэй авахаар тохирсон. Энэ төлбөрийг хамтын ажиллагааны төлбөр болон ирээдүйд төлөх татвараас суутган тооцно.
	Монголын төрийн хөрөнгө оруулалтыг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, албан татвар, хураамж,	Монголын төрөөс хөрөнгө оруулалт хийхгүй байх нөхцлөөр тохирсон. Учир нь Тавантолгойн ордыг ашиглах

	ногдол ашиг, зээл зэрэг хэлбэрээр тооцож болохоор тохиролцох.	Төслийн компанийн 51 хувийг гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай "Энержи Ресурс Корпораци" ХХК, 49 хувийг БНХАУ-ын төрийн өмчит "Шенхуа" компани эзэмшинэ.
5	Ордыг ашиглахтай холбогдуулан шинээр барих эрчим хүч, авто зам, төмөр зам, усан хангамж зэрэг дэд бүтцийн холбогдолтой барилга байгууламжуудын болон хот тосгон, нийгэм, соёлын асуудлыг хэрхэн шийдэх талаар гэрээнд тусгах.	Хөрөнгө оруулалтын гэрээний 2.6-д төмөр зам барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх талаар, 2.7-д эрчим хүч үйлдвэрлэх, ус хангамжийн дэд бүтэц барих-өмчлөх-ашиглах талаар тусгасан. Мөн гэрээний 16.2-т бүс нутгийн хөгжлийн талаар нутгийн захиргааны байгууллагатай Хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллана гэж заасан. Хот тосгон, нийгэм, соёлын асуудлаар тодорхой заалт байхгүй.
6	Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зарчим баримталж, үйлдвэрлэлийн шат дамжлага, гаргах бүтээгдэхүүний нэр төрлийг тохиролцох.	Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар тохиролцоо хийгдээгүй.
7	Үйлдвэрлэлд ажиллах үндэсний боловсон хүчнийг бэлтгэх хөтөлбөр, төлөвлөгөөг тохиролцох.	Хөрөнгө оруулалтын гэрээний 5.9-д "...өөрийн ажилтануудыг бие даан чөлөөтэй сонгож, хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллуулах эрхтэй", "...ажлын байранд тавигдах зохих шаардлага хангасан Монгол улсын иргэдийг ажлын байраар хангана", "...Говийн бүсийн, ялангуяа Өмнөговь аймгийн иргэдийг тэргүүн ээлжинд ажлын байраар хангах, ажиллуулахад анхаарна" гэж заасан
8	Байгаль орчин, хүн, амьтанд хор хөнөөлгүй, орчин үеийн шилдэг техник, технологи ашиглах талаар болон байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлыг ордын хайгуул, ашиглалтын бүхий л үе шатанд хэрэгжүүлэх талаар гэрээнд тусгах.	Хөрөнгө оруулалтын гэрээний 16.3-т Байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа ба нийгмийн харилцааны үүргээ биелүүлэх талаар заасан. Байгаль орчин, хүн амьтанд хор хөнөөлгүй шилдэг техник, технологи ашиглах талаар заалт гэрээнд байхгүй.
9	Гэрээ байгуулахдаа гадаад, дотоодын нэр хүнд бүхий компаниудын уул уурхайн салбарын туршлага, санхүүгийн чадамж болон ирүүлсэн санал зэргийг харгалзан үзэх.	Уралдаант шалгаруулалтанд оролцсон гадаадын хөрөнгө оруулагч БНХАУ-ын Шенхуа, АНУ-ын Пибоди, Японы Иточу, Марубени, Сожицу зэрэг компани нь уул уурхайн салбарын туршлагатай, санхүүгийн чадамжтай байна. Харин Төслийн компанийн 51 хувийг эзэмших "Энержи Ресурс Корпораци"-ийн хувьцаа нь толгой компани болон Кайманы арлын ММС компанийн эзэлийн барьцаанд байна. Тавантолгойн ордыг ашиглах Төслийн компанийн 51 хувийг санхүүгийн чадамжгүй компани эзэмшихээр байгаа нь УИХ-ын тогтоолоор баталсан удирдамжийг зөрчиж байна.

10 Гэрээний төсөл боловсруулахдаа олон улсад нэр хүнд бүхий зөвлөгөө үзүүлэгч байгууллагын туслалцааг авах.	Засгийн газар Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулахдаа олон улсын нэр хүнд бүхий зөвлөгөө үзүүлэгч байгууллагын туслалцаа аваагүй байна. Энэ тухай асуулга тавьсан Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдийн асуулгад М. Энхсайхан сайд хариулахдаа "Хөрөнгө оруулагчид хууль, эрх зүй, гэрээний чиглэлээр "Devis Polk", King & Woods Mallesons"-ийг авч ажиллуулж байгаа бол санхүүгийн чиглэлээр "Deloitte", "KPMG" компаниасүйлчилгээ авч байна. Монголын талын хувьд гадаад компаниуд, гадаад зөвлөхийг ажиллуулахгүй, ажлын хэсэг төрийн байгууллагын хүч бололцоо чадлыг хүрэлцээтэй гэж үзэж байгаа " гэжээ.
---	---


2.2 Хамтын ажиллагааны Гэрээний 2.1 (b)-д зааснаар ЭР нь зөвхөн олборлолт хийх төдийгүй нүүс баяжуулах, боловсруулах үйлдвэр, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, ус хангамжийн дэд бүтэц, байгууламж барьж байгуулах, өмчлөх, ажиллуулах, төмөр замын суурь бүтэц болон төмөр замын тээврийн үйлчилгээ, эрчим хүч, ус хангамж тээвэр, худалдаа борлуулалтын бүх үйл ажиллагааг, үүл уурхайн үйл ажиллагаатай холбоотой бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилготой гэж заасан байна.

Мөн Хөрөнгө оруулалтын Гэрээний 2.1 (b) , 2.2 (a, c) заалтаар ЭР нь Тавантолгойн ордод нүүрс олборлох, боловсруулах, түүнийг захиран зарцуулах, тээвэрлэх, экспортод гаргах, нүүрс худалдах, борлуулах болон маркетинг хийх, борлуулалтын орлогыг цуглуулах, ашиглах болон захиран зарцуулах, уурхайн төлөвлөлт хийх, эрх бүхий байгууллагад тайлан мэдээ гаргах, санхүүжилт босгох, хөрөнгө оруулалт хийх, барьцааны сонирхол үүсгэх, төмөр зам барих, төмөр замын тээврийн болон менежментийн үйл ажиллагаа хийх, нүүрс боловсруулах үйлдвэр, ус, эрчим хүчээр хангах байгууламж барих, нэмэлт хайгуул хийж тогтоосон нөөцийг ашиглах, олборлох болон дагалдах дэд бүтэц барих үйл ажиллагаа явуулахаар заажээ.

Эдгээр заалтууд нь 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн Улсын Их Хурлын 37 дугаар тогтоолоор баталсан Монгол улсын Засгийн газрын 2012-1016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт заасан Тавантолгойн орд газрыг ашиглах зорилгоор олборлох үйл ажиллагаа явуулах гэсэнтэй зөрчилдөж байна.

Олборлох үйл ажиллагаа нь нүүрсийг газрын хэвлийгээс ухаж газрын гадаргуу дээр гаргах гэрээт гүйцэтгэгчийн үйл ажиллагаа болохоос дээр дурьсан шиг өргөн хүрээтэй үйл ажиллагаа биш болно.

Тийм учраас 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 39 дүгээр тогтоолын 1-ийн 1/-д "Тавантолгойн нүүрсний ордод төрийн өмчит компани ашиглалтын үйл ажиллагаа явуулах, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, ордын ашиглалтын

1. 

тусгай зөвшөөрлийг хуваахгүй шилжүүлэх, түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, оператор аж ахуйн нэгжээр олборлолтын үйл ажиллагааг тодорхой хугацаанд гүйцэтгүүлэх" гэж заасан байна.

2.3 Улсын Их Хурлын Өргөдлийн Байнгын хорооны 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн 2-т заасан "Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 1072 хувьцааг эзэмшиж буй иргэдийн эрх ашгийг хамгаалах, хувьцааны эдийн засгийн үр өгөөжийг хүртэх боломжийг бүрдүүлсэн зохицуулалтыг Тавантолгойн ордын хөрөнгө оруулагчидтай хийх гэрээ, хэлэлцээрт тусгайлсан бүлэг болгон тусгах" гэсэн заалтыг Засгийн газар хэрэгжүүлээгүй байна.

2.4 Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2-т "Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтцийг төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байхаар, эсхүл түүний өмчлөлд ашиглалтын тодорхой хугацааны дараа шилжүүлэх нөхцөлөөр шинээр байгуулж болох бөгөөд эдгээр суурь бүтэц, төмөр замын шугамын чигийг Засгийн газар тогтооно" гэж заасан.

Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 121 дүгээр тогтоолын 1 дүгээр заалтаар улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтэц гэж тогтоосон байна.

Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх концессийг 30 жилийн хугацаагаар хувийн хэвшлийн, гадаадын хөрөнгө оруулалттай компанийн охин компани "Энержи Ресурс Рэйл" ХХК-д өгч байгаа нь Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын бичиг баримтыг баталсан Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын 2-ын 2 /"эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой шинээр барих төмөр замын суурь бүтцийг Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2-т заасны дагуу төрийн өмчид байлгах" гэж заасныг зөрчиж байна. (Дэлгэрэнгүй тайлбарыг дүгнэлтийн Төмөр замын суурь бүтэц "барих-ашиглах-өмчлөх-шилжүүлэх" концессийн гэрээний тухайгээсн 1.3-т тодорхой бичсэн болно)

Гурав. Гэрээ Үндэсний аюулгүй байдлын Үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн Зөвлөмж болон Засгийн газрын холбогдох шийдвэр болон төрийн эрх бүхий байгууллагын бусад шийдвэртэй нийцэж байгаа эсэх,

3.1 Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.2.2.2-т "Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална" гэж заасан байна.

Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын Гэрээний 2.8 (a)-д зааснаар Төсөлд оруулах Хөрөнгө оруулалтыг ойролцоогоор 4 тэрбум гэжээ.

Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 11 орчим тэрбум доллар бөгөөд Монгол улсын стратегийн ордыг ашиглах зорилгоор дотоодын нийт бүтээгдэхүүний бараг 40 хувьтай тэнцэх хөрөнгө оруулалт БНХАУ-ын төрийн өмчит компанитай хамтарсан хөрөнгө оруулалттай, нэг компаниас орж байгаа нь "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.2.2.2-т заасан хөрш орон, өндөр хөгжилтэй орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтлана гэсэнтэй нийцэхгүй байна.

3.2 Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих-ашиглах-өмчлөх-шилжүүлэх концессийн асуудал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолтой салшгүй холбоотой гэж үзэж байна.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д хил дамнасан дэд бүтцийг хөгжүүлэх, эрдэс баялгын салбарыг хөгжүүлэхэд баримтлах ёстой дараах заалтууд байна.

"Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.1.2.5 Хил орчмын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхдээ үндэсний нэгдмэл ашиг сонирхлыг дээдэлж, Монгол Улсын бүрэн эрхт байдал, хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бататгах зарчмыг үндэс болгоно, 3.1.2.7-д "Хилийн дагуух орон нутгийн хөгжлийн бодлого, гадаад харилцаа нь төрийн нэгдсэн бодлогод захирагдана", 3.2.1.4 Дэд бүтцийн салбарын хөгжлийг үндэсний аюулгүй байдлын шаардлагад нийцүүлж, хөрөнгө оруулалтад эдийн засгийн үр ашгийг шалгуур болгоно. Төмөр замын сүлжээг байгуулахдаа Монгол Улсын үндэсний ашиг сонирхлыг эрхэмлэнэ, 3.2.4.1-д "Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлын баталгааг хангахыг чухалчилж, түүхий эдийн хавсарга, гадаад дотоодын улс төр, бизнесийн ашиг сонирхлын сөргөлдөөний талбар болох байгаль орчныг доройтуулахаас сэргийлнэ. Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, орлогод тавих хяналтыг сайжруулна" гэж тус тус заажээ.

Үндэсний аюулгүй байдлын Үзэл баримтлал болон Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод тусгагдсан эдгээр заалт нь улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын суурь бүтэц улс орны үндэсний ашиг сонирхолтой салшгүй холбоотой болохыг харуулж байна.

Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх нөхцлөөр 30 жилийн хугацаагаар гадаадын хөрөнгө оруулалттай компанийн охин компани, хувийн "Энержи Ресурс Рэйл" ХХК-д шилжүүлж "барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх" гэрээ байгуулах нь Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн 32 дугаар тогтоолын 2-ын 2 дахь заалт, 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.1.2.5, 3.1.2.7, 3.2.1.4, 3.2.4.1 заалтууд болон Үндэсний аюулгүй байдлын 2011 оны 35/32 дугаар зөвлөмж, Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 121, 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 28 дугаар тогтоолыг тус тус зөрчиж байна. (Холбогдох тайлбарыг дүгнэлтийн Төмөр замын суурь бүтэц "барих-ашиглах-өмчлөх-шилжүүлэх" концессийн гэрээний тухайгэсэн 1.3-т тодорхой бичсэн болно)

2015 оны 2 дугаар сарын 16-ны өдөр Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөл Тавантолгойн асуудлаар хуралдаж Тавантолгойн гэрээг Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Монгол Улсын холбогдох бусад хууль, тогтоомжинд нийцүүлэн байгуулах, Тавантолгойн ордыг ашиглах асуудлаар өмнө нь гарсан Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн уялдааг сайжруулах, Монгол Улсын иргэдэд олгосон "Эрдэнэ Тавантолгой" ХК-ийн хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулж, хувьцааны ногдол ашиг хүртэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах үүрэг өгсөн боловч Засгийн газар хэрэгжилтийг хангаагүй байна.

Засгийн газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Засгийн газар... Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх арга хэмжээ авч, энэ тухай Ерөнхийлөгчид мэдээлж байна" гэснийг дагуу Засгийн газар нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийг биелүүлэх үүрэгтэй. (Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2015 оны 04/03 дугаар зөвлөмжийг хавсаргае)

3.3 Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн 40 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Тавантолгойн нүүрсний ордыг хамтарч ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үндсэн зарчим, удирдамж"-ийн 10-т заасан "гэрээний төсөл боловсруулахдаа олон улсад нэр хүнд бүхий зөвлөгөө үзүүлэгч байгууллагын туслалцааг авах" гэснийг М. Энхсайхан сайд зөрчиж гэрээний төсөл боловсруулахдаа зөвлөх үйлчилгээ аваагүй байна.

Ингэснээр Улсын Их Хурлын 2008 оны 40 дүгээр тогтоолоор баталсан удирдамжийн 10 дахь заалт хэрэгжээгүй байна. (Улсын Их Хурлын 2008 оны 40 дүгээр тогтоолыг хавсаргае)

Энэ тухай асуулга тавьсан Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдийн асуулгад М. Энхсайхан сайд хариулахдаа "Хөрөнгө оруулагчид хууль, эрх зүй, гэрээний чиглэлээр "Devis Polk", King & Woods Mallesons"-ийг авч ажиллуулж байгаа бол санхүүгийн чиглэлээр "Deloitte", "KPMG" компаниас үйлчилгээ авч байна. Монголын талын хувьд гадаад компаниуд, гадаад зөвлөхийг ажиллуулахгүй ажлын хэсэг төрийн байгууллагын хүч бололцоо чадлыг хүрэлцээтэй гэж үзэж байгаа" гэжээ.

Монголын Засгийн газар олон улсын нэр хүнд бүхий хуулийн болон санхүүгийн мэргэжлийн зөвлөх аваагүйгээс гэрээгээр өөрийн эрх ашгийг хуулийн хүрээнд хамгаалах боломжийг алдсан байна.

3.4 Гэрээ байгуулах хэлэлцээрийг Монгол улсын сайд М. Энхсайхан удирдан явуулж байгаа нь 2010 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн 4 дэх заалт "...хэлэлцээ явуулахдаа мэргэжлийн зохих төвшинд хадгалж, улс төрийн албан тушаалтанг хэлэлцээрийн аль нэг талд оролцуулахгүй байх зарчмыг баримтлах" гэснийг зөрчиж байна. (2010 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг хавсаргае)

3.5 Хөрөнгө оруулалтын Гэрээний 27-д зааснаар Гэрээг англи, монгол хэл дээр байгуулж байгаа бөгөөд зөрүү гарвал англи хэл дээрхи хувийг давуу

хүчинтэйд тооцож баримтлана гэжээ. Гэрээний монгол хувилбар нь англи хувилбарын орчуулга байна. Үүнээс харахад гэрээний эх хувилбар англи хэл дээр боловсруулагдаж, монгол хэл рүү оруулагдаж байна.

Маргаан үүсвэл Лондон хотод Арбитрийн шүүхэд англи хэл дээр маргаан явагдах учир 2010 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн Үндэсний аюулгүй байдлын хуралдааны 24/11 дүгээр тэмдэглэлд "Тавантолгойн стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах баримт бичиг, гэрээний төсөл болон холбогдох бусад баримт бичгийг монгол, англи хоёр хэлээр алдаа мадаггүй боловсруулах" гэсэн удирдамж, чиглэл мөрдөгдөөгүй байна. (Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг хавсаргае)

Дөрөв. Гэрээ Монгол Улсын баримталж буй гуравдагч хөршийн бодлоготой нийцэж байгаа эсэх,

4.1 Хөрөнгө оруулалтын Гэрээний 12.3 (а), (b), 12.4 (а)-д зааснаар ЭР нь худалдааны хамтарсан компани байгуулж, бүтээгдэхүүний 75 хувийг БНХАУ-д, 25 хувийг Худалдааны компаниар дамжуулан гуравдагч зах зээлд зарна. Энэ худалдааны компанийн 30 хувийг консорциумын гишүүн Япон улсын түнш эзэмшинэ гэжээ.

Энэ заалтаас харахад Консорциумын гишүүн болох Японы "Сумитомо" корпораци нь Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах төслийн компани ЭР болон төмөр замын суурь бүтэц өмчлөгч ЭРР-н аль алиных нь хөрөнгө оруулагч биш, зөвхөн худалдааны компанийн түнш байна.

Гадаад хэргийн яамнаас "Гуравдагч хөрш"-ийн бодлогын тухай санамж бичгийг боловсруулан Засгийн газраар хэлэлцүүлэн шийдвэрлэж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг тусган 2014 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Н/89 тоот албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц. Энхтүвшинд хүргүүлсэн байна.

Японы "Сумитомо" корпораци Тавантолгойн ордыг ашиглах Төслийн компани болон Тавантолгойн-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг өмчлөх ашиглах компанид оролцохгүй байгаа нь энэхүү Санамж бичгийн 2.1, 4.6, 4.10, 4.11 дүгээр заалтуудыг хангахгүй байна.

4.2 Хамтын ажиллагааны Гэрээний "Нууцлал" гэсэн 12 дугаар зүйл болон Хөрөнгө оруулалтын Гэрээний "Нууцлал" гэсэн 29.3 дугаар зүйлд яагаад зөвхөн Хонконгийн болон Шанхайн хөрөнгийн биржийг дурьджээ.

Энэ Гэрээний үргэлжлэх хугацаанд Тавантолгойн ордыг ашиглах үйл ажиллагаа болон үнэт цаас гаргахад Лондон, Нью Йорк, Токио, Торонто зэрэг Монгол улсын Гуравдагч хөрш орноор тодорхойлсон улс орнуудын олон улсын нэр хүндтэй биржүүд хамрагдахгүй байх зохицуулалт хийгджээ гэж үзэж байна.

4.3 Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах төсөлд Японы "Сумитомо" компани шууд оролцохгүй байгаа нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.1.5. "Гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр

болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ" гэж заасныг хангахгүй байна.

Тавантолгойн ордыг ашиглах Хамтын ажиллагааны гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээ, төмөр замын концессийн Гэрээ нь Гуравдагч хөршийн бодит оролцоо, хөрөнгө оруулалтыг хангаагүй, Монгол улсын гадаад бодлогод баримтлаж буй Гуравдагч хөршийн бодлоготой нийцэхгүй байна.

Тав. Төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн бизнесийн эрх ашигтай уялдаж байгаа эсэх,

5.1 Эрдэнэс Тавантолгой ХК-ийн бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх тухай

5.1.1 Хамтын ажиллагааны Гэрээний "Угтвар нөхцөл" нөхцлийн D хэсэг, гэрээний 1.1 (а), (b) заалт, 1.2 (а) болон 6.1 (d) заалтуудаар ЭТТ нь Цанхийн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой бүх эрх болон зарим тодорхой үүрэг, хайгуулын болон уул уурхайн бүрэн үйл ажиллагаатай холбоотой бүх эрхээ болон газар эзэмших эрхээ ЭР-д энэ гэрээний нийт хугацаагаар (гэрээний үндсэн хугацаа 30 жил, сунгалт 30 жил) шилжүүлж байна.

Эдгээр заалтаар ЭТТ нь ЭР-т Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой бүх эрх, Тавантолгойн газар эзэмших эрх болон уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой бүх эрхээ шилжүүлснээр шууд бусаар Тавантолгойн ордыг 60 жилээр бүрэн хянах бодит эрх ЭР-д үүсч байна.

5.1.2 Хамтын ажиллагааны Гэрээний Угтвар нөхцлийн (E)-д болон 5.1 (q)-д зааснаар ЭТТ нь өөрийн Цанхийн уурхайд ажиллаж байгаа ажилчид, Цанхийн талбайтай холбоотой нүүрс борлуулах гэрээ, уул уурхайн үйлчилгээ үзүүлэх гэрээ болон бусад гэрээг хамааруулсан ЭТТ-н тодорхой үүрэг, эд хөрөнгийг ЭР-д шилжүүлж, "Эрх үүрэг шилжүүлэх гэрээ"-г тусад нь байгуулахаар тохирчээ.

ЭТТ компанийн эд хөрөнгө, тодорхой үүрэг, ажилчдыг өөр компанид шилжүүлэх тухай асуудлыг ЭТТ нь Компанийн тухай хуулийн "Их хэмжээний хэлцэл" гэсэн 87 дугаар зүйлийн дагуу шийдвэрлэгдэх ёстой. Компанийн хуулийн энэ заалтын дагуу ЭТТ-н шийдвэр гараагүй байна. Энэ шийдвэр гараагүй байхад "Эрх, үүрэг шилжүүлэх гэрээ" байгуулах нь Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийг бүхэлд нь зөрчинө.

5.1.3 Хөрөнгө оруулалтын Гэрээний 1.1 (а) болон 2.3 (с) заалтаар Тавантолгойн ордын нүүрсийг Ухаа худагийн ордтой уялдуулах замаар Цанхийн нүүрсний талбайг хөгжүүлэх, мөн Тавантолгойн бүс нутгийн бусад уурхайгаас олборлосон нүүрсийг хольж хэрэглэх, мөн Гэрээний 5.2 (а)-д зааснаар ЭТТ болон ЭР-н аль аль нь Цанхийн болон Ухаа худагийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилээр эзэмших мөн 20 жилээр 2 удаа сунгах нийтдээ 70 жил хүчинтэй байлгах үүрэг хүлээсэн байна.

Мөн Гэрээний 5.2 (е) заалтаар энэхүү гэрээний нөхцөл нь Гэрээний хугацаанд Ухаа худагийн ордтой холбоотой үйл ажиллагаанд мөн хамаарахаар заажээ.

Тавантолгойн ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын болон бусад дагалдах гэрээний хүрээнд хувийн компанийн эзэмшилд байгаа Ухаа худгийн ордыг ашиглах үйл ажиллагаа хамаарах ёсгүй бөгөөд Засгийн газар, Ухаа худагийн ордтой холбоотой үүрэг хүлээх шаардлагагүй. Ухаа худагийн орд нь энэ гэрээний зүйл биш тул Гэрээнд байгаа Ухаа худагийн ордтой холбоотой бүх заалтыг хасах нь зүйтэй.

ЭТТ нь 10 орчим тэрбумын эд хөрөнгө, 592 ажилчидтай,² ЭТТ нь 2013 онд 5.3 сая тонн, 2014 онд 4.5 сая тонн нүүрс олборлож үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. ЭТТ нь ЭР-ийн хувьд бизнесийн том өрсөлдөгч. Нэг зах зээл дээр нэг төрлийн бүтээгдэхүүн дээр бизнес хийдэг. ЭТТ эзэмшиж буй Тавантолгойн орд нь нөөц 7.4 тэрбум тонн.³ ЭР-ийн "Ухаа худаг" ордын нөөц 400 орчим сая тонн.

ЭТТ нь Тавантолгойн Цанхийн орд дээр уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг төрийн компани бөгөөд үйл ажиллагаа явуулах бүх эрхээ ЭР өгч, орлого олох боломжгүй болж байна. ЭТТ нь баруун, зүүн Цанхи буюу гол цөм болсон уурхайнуудаа болон уул уурхайн бүх үйл ажиллагаагаа ЭР-т шилжүүлэн өгч өөрөө орлого олох боломжоо хааж байна.

Иймд энэ гэрээгээр ЭР нь өөрөөс нь асар том нөөц эзэмшдэг бизнесийн өрсөлдөгчөө чадавхгүй болгож, өөртөө тааламжтай бизнесийн орчин үүсгэж байна.

5.2 БНХАУ-ын "Чалко" компанийн өрийн тухай

5.2.1 Хамтын ажиллагааны Гэрээний 8.3-т "Чалко"-н төлбөрийг төлж барагдуулах ерөнхий зохицуулалт хийсэн байна. Харин Хөрөнгө оруулалтын гэрээний 3.4 (а)-д "Чалко"-н 142 сая долларын өрийг 12 сард бүтээгдэхүүн нийлүүлэх замаар эсвэл бэлэн мөнгөөр төлөхийг ЭР бие даан шийдвэрлэнэ гэж илүү тодорхой заасан байна.

ЭР нь "Чалко" компанийн өрийг нүүрсээр төлж барагдуулна гэвэл зарчгийн ялгаагүй байна. ЭТТ одоо ч энэ өрийг нүүрсээр төлж байгаа бөгөөд цаашдаа ч энэ хэлбэрээр төлж дуусгах боломжтой. 2015 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Ажлын дэд хэсэг Эрдэнэс Тавантолгой ХК-ийн уурхай дээр очиж ажиллах үед тус компанийн агуулахад экспортод гаргахад бэлэн 2.3 сая тонн нүүрс, хөрс хуулалт хийж олборлоход бэлтгэсэн 2 сая тонн нүүрс байна.

Нийт 4.3 сая тонн нүүрсний зах зээлийн одоогийн өртөг болох 35 ам.доллараар тооцоход 150 сая ам.доллар болж байгаа нь ЭТТ өөрийн ердийн хүчин чадлаар ажиллаж, Чалко компанийн өрийг төлж дуусгах бүрэн боломжтойг харуулж байна.

² "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн офист 119, уурхайд 473 ажилчид 5 хэлтэст хуваагдан ажилладаг
³ "Норвест" компанийн Олон улсын Жорк ангилалд шилжүүлж хийсэн нөөцийн урьдчилсан тооцооллоор Тавантолгойн нүүрсний нөөц нь 300 метр гүнд 7.4 тэрбум тонн коксжих болон эрчим хүчний нүүрсний нийт геологийн нөөцтэй байх боломжтой гэж үзсэн.

5.2.2 Хөрөнгө оруулалтын гэрээний 3.4 (b)-д энэхүү гэрээний 3.4 (a) хэсэгт (энэ хэсэгт зөвхөн Чалко-н өрийг зааснаас бусад аливаа өр, төлбөрөө ЭТТ өөрөө дангаараа хариуцна" гэжээ.

Мөн хөрөнгө оруулалтын Гэрээний 3.8 болон Гэрээний хавсралт 3-ын 4 дэх заалтаар Засгийн газар болон ЭТТ аль нь ч ЭР-аас өөр ямар нэгэн зардал төлбөрт төлөхийг шаардах эрхгүй гэжээ. Мөн Хамтын ажиллагааны Гэрээний "Нэмэлт үүрэг хүлээхгүй" тухай 3.3-т зааснаар ЭР нь "Чалко"-н өрөөс өөр ЭТТ-ын төлөх ямар ч өр, төлбөр, татвар, хураамж, цалинг хариуцахгүй гэжээ.

Зөвхөн "Чалко"-н өрийг төлөөд ЭТТ-н бусад өр төлбөр хамаагүй гэж байгаа Консорциумын хандлага шударга бус байна. ЭТТ нь Монгол улсын Хөгжлийн банкинд 250 сая ам.доллар, дотоодын банкуудад 30 орчим сая ам.доллар, бусад төлөх 30-50 тэрбум төгрөгийн өртэй өртэй байна.

Консорциумтай байгуулах Хөрөнгө оруулалтын болон дагалдах бусад гэрээгээр ЭТТ нь өөрийн хэвийн ашиглаж байгаа үндсэн ордуудаа ашиглах боломжгүй болж байгаа бөгөөд "хөрөнгө оруулагч нар"-т үйл ажиллагаа явуулах бүх эрхээ шилжүүлж байх тул өр төлбөрөө хэрхэн төлөх нь ойлгомжгүй.

Иймд ЭТТ компанийн бусад этгэдээд төлөх өр, төлбөрийн асуудлыг хамтад шийдвэрлэх ёстой. Тухайлбал, Цанхийн зүүн уурхай дээр олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа Австралийн "Макмахон" компанийн охин компани болох "ТТJVCо" компанийн үйл ажиллагааны өр, төлбөр үлдэж байна. Эдгээр өр, төлбөрийн асуудлыг шийдвэрлэхгүй бол тус компани олон улсын арбитрын шүүхэд хандаж Засгийн газар төлбөрийн хүү, хохирлын хамт сая долларын өр, төлбөрт унах магадлал өндөр байна.

Мөн Цанхийн баруун уурхай дээр үйл ажиллагаа явуулж байгаа "Монгол Уурхайчид түншлэл"⁴ болон бусад туслан гүйцэтгэгч 13 компанитай байгуулсан гэрээ цуцлагдах тохиолдолд эдгээр компаниуд нөхөн төлбөр шаардах болно.

Зургаа. Тус компанийн хувьцааг олон улсын биржид арилжаалах нөхцлийг хангах шаардлага хэрхэн хангагдах,

Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн "Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай" гэсэн 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын в-д "хувьцааны 20 хүртлэх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр худалдаж шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах"-ыг Засгийн газарт даалгасан байна.

Мөн Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 9-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлийн 1-д "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг гадаад, дотоодын хөрөнгийн бирж дээр арилжаалах хөрөнгийн биржийн сонголт, компанийн бүтцийн талаархи ажлын хэсгийн саналыг хэлэлцээд хувьцааны

⁴ Монгол Уурхайчид түншлэл"-д Монгол улсын үндэсний "Хишиг арвин индустриал" ХХК, (450 ажилчинтай) "МНО" ХХК, (70 ажилчинтай) "Мера" ХХК (78 ажилчинтай) багтаж байна.

тодорхой хэсгийг Монголын хөрөнгийн бирж, Лондонгийн хөрөнгийн бирж болон Хонконгийн хөрөнгийн бирж дээр арилжаалах саналыг дэмжив" гэжээ.

Мөн Улсын Их Хурлын 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 37 дугаар тогтоолд "... Улмаар Таван толгойн орд газрыг түшиглэн дотоод гадаадын хөрөнгийн бирж дээр хувьцааг худалдах ажлыг Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу зохион байгуулна" гэж заажээ.

"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааны 20 хүртэлх хувийг дотоодын болон олон улсын хөрөнгийн бирж дээр арилжаалж шаардлагатай хөрөнгө оруулалт татах үүргийг Засгийн газар биелүүлээгүй байна.

Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолоор зарласан уралдаант шалгаруулалтанд тэнцсэн Консорциумтай байгуулахаар бэлтгэсэн Хамтын ажиллагааны гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд ЭТТ компанийн хувьцааг хөрөнгийн биржид арилжаалах нөхцлийн талаар зохицуулалт тусгаагүй байна.

Хэрэв ЭТТ компанийн хувьцааны 20 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр худалдаж шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах арилжааг хийснээр 3 тэрбум ширхэг хувьцааг (ЭТТ компанийн 15 тэрбум хувьцааны 20 хувь нь 3 тэрбум ширхэг болно) санал болгох бөгөөд зах зээлийн үнийг 1000 төгрөг гэж тооцвол 3 их наяд төгрөгийн хөрөнгийг (ам.долларын ханшийг 2000 төгрөгөөр тооцоход 1.5 тэрбум доллар) бий болгох боломжтой байна.

Орон нутгийн өмчит "Таван толгой" ХК-ийн үйл ажиллагааны жишээ

Орон нутгийн өмчит "Таван толгой" ХК-ийн (жижиг Тавантолгой гэж нэрлэдэг) хувьцааны нэрлэсэн үнэ Монголын Хөрөнгийн Бирж дээр хэрхэн өсч байсан жишээг анхаарах нь зүйтэй байна.

"Таван толгой" ХК нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт, Даланзадгад хотоос зүүн тийш 100 км-т байрладаг бөгөөд нүүрс, кокс олборлох, борлуулах чиглэлээр үндсэн үйл ажиллагаа явуулдаг компани юм.

1994 онд Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 42 дугаар тогтоолоор орон нутгийн давамгайлсан хувьцаат компани болгон зохион байгуулагдан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 526,652 ширхэг энгийн хувьцаа гаргасан бөгөөд тус компанийн нийт гаргасан хувьцааны 49 хувийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-иар дамжуулан анхдагч зах зээл дээр 1995 оны 4 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн арилжаалсан. Тухайн үеийн анхдагч зах зээл дэх хувьцааны ханш 60 төгрөг, 40 төгрөг, 16 төгрөг тус тус байсан.

2013 онд "Таван толгой" ХК 9.3 сая метр куб хөрс хуулалтын ажил хийж, 3.1 сая тонн нүүрс олборлосон нь өмнөх 2012 оны мөн үетэй харьцуулахад 823.0 мянган тонноор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Харин 2014 онд 554.5 мянган тонн нүүрс олборлон зах зээлд борлуулсан үзүүлэлттэй байна. Мөн тухайн онд нийт 4.6 сая метр куб хөрс хуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд дурьджээ.

"Таван толгой" ХК нь 1996-2014 онуудад тухайн жилүүдийнхээ үйл ажиллагааны санхүүгийн үр дүнгээс шалтгаалан нийт 14 удаа ногдол ашиг хуваарилж, нийт дүнгээрээ 237.6 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчиддээ олгосон байна.

Тус хувьцаат компанийн хуваарилсан ногдол ашгийн талаарх мэдээллийг он оноор нь үзүүлэхэд дараах байдалтай байна. (Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 6 дугаар сарын 16-ны өдөр хүргүүлсэн 2/3084 дугаар албан тоотгоор өгсөн мэдээлэл)

№	Ногдол ашиг тараасан онууд	Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ /төгрөгөөр/
1	1996	0.18
2	1997	0.66
3	1998	8.06
4	2002	2.42
5	2004	949.39
6	2005	2,819.71
7	2006	6,467.37
8	2007	18,318
9	2008	18,381
10	2009	55,000
11	2010	130,000
12	2011	1,368
13	2013	766*
14	2014	59
15	Нийт дүн	234,139.79
16	Хувьцааны тоо ширхэг	52,665,200,00
17	Нийт дүн	237,650,024,447.08 төгрөг

www.mse.mn

"Таван толгой" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас 2013 оны ногдол ашгийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргасан байдаг.

Орон нутгийн өмчит "Таван толгой" ХК-ийн зах зээлийн үнэлгээ, хувьцааны ханш.

Монголын хөрөнгийн бирж дээрх "Таван толгой" ХК-ийн хувьцааны зах зээлийн үнэлгээ 2015 оны 6 дугаар сарын 14-ний байдлаар 226,776,351,200 төгрөг байгаа бөгөөд тус хувьцаат компанийн хувьцааны ханшийн талаарх мэдээллийг 2009 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хувьцааны бүрдүүлбэрт өөрчлөлт орох хүртэлх болон орсоны дараах гэсэн хоёр хэсэгт хуваан графикаар үзүүллээ.

График № 1



График № 2



"Таван толгой" ХК-ийн хувьцааны ханшийн судалгаанаас үзэхэд 2011 оны 3 дугаар сарын үед хамгийн дээд түвшинд буюу 1,439,000 төгрөг хүрч байсан ба одоогийн байдлаар нэгж хувьцааны ханш 4,306 төгрөг байгаагаас хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн нэгж хувьцааны ханшийг 430,600 төгрөг байна гэж дүгнэж болох талтай.

Орон нутгийн Тавантолгой ХК-ийн энэ түүх нь ЭТТ-д бодит боломж асар өндөр болохыг харуулж байна. Иймд 300-хан метрийн гүнээс олборлох 7.4 тэрбум тн коксжих болон эрчим хүчний нүүрсний нөөц бүхий Тавантолгойн нүүрсний орд дээр олох ашгийг нь тооцоод үзвэл түүний зах зээлийн үнэлгээ өндөр байх магадлалтай.

Засгийн газрын санал болгож байгаа хэлбэрээр Консорциумтай Хөрөнгө оруулалтын болон бусад дагалдах Гэрээг ЭТТ-д ашиггүй нөхцлөөр 30 жилээр байгуулж, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагаа явуулах бүх эрх ЭР-т шилжиж, "цаасан дээрхи компани" болж

1.

үлдэж байгаа нь тус компанийн үнэ цэнийг бууруулж, хувьцааг дотоод, гадаадын хөрөнгийн биржид арилжаалах боломжийг хааж байна.

Долоо. "Эрдэнэс Тавантолгой" ХК-д 1072 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа иргэд болон үндэсний аж ахуйн нэгжүүдийн эрх ашгийг хангаж байгаа эсэх,

Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 39 дүгээр тогтоол болон 2012 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 18 дугаар тогтоолоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааны 20 хүртлэх хувийг Монгол улсын нийт иргэнд адил хэмжээгээр үнэ төлбөргүй эзэмшүүлэх, 10 хүртлэх хувийг үндэсний аж ахуйн нэгжүүдэд адил тэнцүү хэмжээгээр, нэрлэсэн үнээр худалдахаар шийдвэрлэсэн.

"Эрдэнэс Тавантолгой" ХК нь 15 тэрбум ширхэг хувьцаа гаргасан, нэрлэсэн үнэ нь 933 төгрөг, компанийн нийт үнэлгээ нь 14 их наяд төгрөг байна.

Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 1 дүгээр заалтаар тус компанийн 1072 хувьцааг 1 сая төгрөгтэй дүйцүүлэн тухайн хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тогтоосон байна.

Санхүүгийн зохицуулах хорооны мэдээгээр ЭТТ-н нийт хувьцааны 82.89 % буюу 12, 433, 326, 819 ширхэг хувьцаа төрийн мэдэлд, 17.05% буюу 2,558,175,510 ширхэг хувьцаа 2,475,201 иргэний нэр дээр 0,06% буюу 8,497,671 ширхэг хувьцаа Монгол улсын 553 аж ахуйн нэгжийн нэр дээр тус тус бүртгэлтэй байна.

2015 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн хуралдаанаас гаргасан 04/03 дугаар Зөвлөмжийн 4 дэх заалтаар "Монгол улсын иргэдэд олгосон "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулж, хувьцааны ногдол ашиг хүртэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах" үүргийг Засгийн газарт өгсөн нь хэрэгжээгүй байна.

Мөн Улсын Их Хурлын Өргөдлийн Байнгын хорооны 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдөр хуралдаж, 05 дугаар тогтоол гарган "Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 1072 хувьцааг эзэмшиж буй иргэдийн эрх ашгийг хамгаалах, хувьцааны эдийн засгийн үр өгөөжийг хүртэх боломжийг бүрдүүлсэн зохицуулалтыг Тавантолгойн ордын хөрөнгө оруулагчидтай хийх гэрээ, хэлэлцээрт тусгайлсан бүлэг болгон тусгах" үүргийг Засгийн газарт өгчээ. Өргөдлийн Байнгын хорооноос өгсөн энэ үүргийг Засгийн Газар биелүүлээгүй байна. (Өргөдлийн Байнгын хорооны 2015 оны 05 дугаар тогтоолын хуулбарыг хавсаргаа)

Мөн "Эрдэнэс Тавантолгой" ХК-д иргэдийн эзэмшиж байгаа 1072 ширхэг хувьцаатай холбоотойгоор хувьцаа эзэмшигч иргэдийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой асуудлаар Санхүүгийн зохицуулах хорооны дарга З. Нарантуяа 2015 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 1/1133 дугаар албан тоотой Засгийн газар болон М. Энхсайхан сайдад Санал, зөвлөмж хүргүүлсэн байна. (СЗХ-ны дарга З. Нарантуяа 2015 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 1/1133 дугаар албан тоотыг хавсаргаа)

Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн Зөвлөмж, Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны зөвлөмжийн дагуу Засгийн газар ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна.

"Эрдэнэс Тавантолгой" ХК-д иргэдийн эзэмшиж байгаа 1072 хувьцаа болон үндэсний аж ахуйн нэгжүүдийн эзэмшиж байгаа хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулах, тэдний эрх ашгийг хангасан зохицуулалт Хамтын ажиллагааны болон Хөрөнгө оруулалтын гэрээнд байхгүй байна.

Иймд "Эрдэнэс Тавантолгой" ХК-д иргэдийн эзэмшиж байгаа 1072 хувьцаа болон үндэсний аж ахуйн нэгжүүдийн эзэмшиж байгаа хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулах, тэдний эрх ашгийг хангасан зохицуулалтыг Тавантолгойн ордыг ашиглах Гэрээнд тусгах үүргийг Засгийн газарт өгөх заалтыг Улсын Их Хурлын тогтоолд тусгах нь зүйтэй гэж Ажлын хэсэг үзлээ.

Найм. "Эрдэнэс Тавантолгой" ХК-д 1072 хувьцаа эзэмшиж байгаа иргэдийн саналын эрхийг хассан Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолын хууль зүйн үндэслэлийг хянах,

Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 3 дахь заалтаар "Эрдэнэс Тавантолгой" ХК-1072 ширхэг хувьцаа эзэмшигч Монгол Улсын иргэд болон үндэсний аж ахуйн нэгжүүдийн хувьцааг саналын эрхгүй байхаар шийдвэрлэсэн байна.

Засгийн газрын энэхүү тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2-т "Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална" мөн зүйлийн 3-т "Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно" гэснийг зөрчиж байна.

Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 181 дүгээр 181 дүгээр тогтоол Үндсэн хууль зөрчиж байгаа тухай Улсын Их Хурлын дарга З. Энхболд 2015 оны 5 дугаар сарын 6-ны өдөр 1/4087 дугаар албан тоотоор, Санхүүгийн зохицуулах хорооны дарга З. Нарантуяа 2015 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр 1/2124 албан тоотоор Засгийн газарт анхааруулсан байна. (Албан тоотын хуулбарыг хавсаргае)

Иймд ажлын хэсгийн гишүүдээс Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолын холбогдох заалтыг хүчингүй болгох нь зүйтэй гэж үзэж Улсын Их Хурлын тогтоолын төсөл санаачлан хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлж байна.

Ес. Гэрээ талуудын эрх тэгш харилцан ашигтай байх олон улсын хамтын ажиллагааны зарчмыг хангаж байгаа эсэх,

9.1 Хамтын ажиллагааны Гэрээний 2.3 (а) болон 3.1(а) заалтаар Цанхийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд уул уурхайн үйл ажиллагаа явуулах эрх эдлүүлсний төлөө ЭР нь ЭТТ-д борлуулалтын нийт орлогын тодорхой хувийг тохирсон аргачлалын дагуу (Жишээ нь: нүүрсний үнэ 85 доллараас бага

байхад нөхцөлд 2%-ийн хамтын ажиллагааны төлбөр төлнө. Мөн Гэрээний 3.2 (с)-д зааснаар ЭТТ нь тусгай зөвшөөрлийн, агаарын бохирдлын, нөөц ашигласны төлбөр зэрэг татвар, хураамжийг төлөхөөр заажээ)

Тэгвэл Хөрөнгө оруулалтын гэрээний 3.1 (с)-д зааснаар гэрээний хугацаанд энэ аргачлал, хувь хэмжээ нэмэгдэхгүй тогтмол байна. Өөрөөр хэлбэл гэрээний хугацаа 30 жилд (хугацааны сунгалт 30 жил) тогтмол байна.

Хөрөнгө оруулалтын Гэрээний 2.5 (b)-д зааснаар ЭР нь борлуулах бүтээгдэхүүний тоо хэмжээ, худалдах үнийг өөрөө тогтоож байгаа тул Хамтын ажиллагааны төлбөр жил бүр ямар байхыг тооцоолох боломжгүй байна. Тэгээд ч зөвхөн нэг зах зээлд нийлүүлж байгаа өрсөлдөгч байхгүй тул нүүрсний үнэ өндөр байх бодит боломж байхгүй. ЭР нь нүүрсний үнийг хэзээ ч 85 ам.доллараас дээш гаргахгүй барих бүрэн боломжтой гэж үзэж байна.

9.2 Хамтын ажиллагааны Гэрээний 5.1 (а) болон 6.1 (g) заалтаар ЭР нь Цанхийн талбайд эзэмшилдээ авч, аливаа хязгаарлалтгүйгээр бүрэн ашиглах, хянах эрхтэй байна. Харин Хамтын ажиллагааны гэрээний 6.1 (а)-д зааснаар ЭТТ зөвхөн ЭР-аас зөвшөөрсөн тохиолдолд талбайд нэвтэрч ЭР-ийн гэрээний болзол, нөхцлийг биелүүлж байгааг баталгаажуулах эрхтэй гэжээ.

Энэ заалтын дагуу бол ЭР зөвшөөрөхгүй л бол ЭТТ нь өөрийн эзэмшиж байгаа талбайд чөлөөтэй нэвтрэх эрхгүй бөгөөд ЭТТ-д нэвтрэх зөвшөөрөл өгөх эсэх нь ЭР-н үзэмжийн асуудал болж байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч ЭТТ-н хувьд өөрийн эзэмшлийн талбайд чөлөөтэй нэвтрэх эрхийг хязгаарласан хэт нэг талын ашиг сонирхолд үйлчилсэн заалт байна.

9.3 Хамтын ажиллагааны Гэрээний 8.2 (с) заалтаар хэрэв ЭТТ нь Цанхийн ашиглалтын тусгай зөвшөөрлөө ямар нэг хэлбэрээр Гуравдагч этгээдэд худалдах, шилжүүлэх аливаа байдлаар захирах зарцуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд ЭР нь тухайн тусгай зөвшөөрлийг тэргүүн ээлжинд шилжүүлэн авах санал гаргах давуу эрхтэй гэжээ.

Хамтын ажиллагааны Гэрээний 8.2 (с)-д зааснаар тусгай зөвшөөрөл худалдах үнийг зөвшилцөнө, үнэ тохирохгүй бол олон улсын эрх бүхий хөндлөнгийн, мэргэжлийн байгууллагаар үнэлүүлнэ. Тэгээд тэр үнээр ЭР худалдан авах эрхтэй болно гэжээ. Энэ заалтаас харахад олон улсын хөндлөнгийн, мэргэжлийн байгууллагын үнэлгээ тогтоож байгаа хэлбэр нь зөв боловч далд утгаараа энэ тогтоосон үнээр ЭТТ заавал, зөвхөн ЭР-д тусгай зөвшөөрлөө зарах үүрэг хүлээлгэсэн байна. Энэ нь "Гэрээний 8.2 (b) болон 8.2 (с) хэсэгт заасны дагуу төслийн компанийн тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг хангахгүйгээр аливаа Гуравдагч этгээдэд Цанхийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг худалдах, шилжүүлэх, аливаа байдлаар захиран зарцуулахгүй" гэснээс маш тодорхой харагдаж байна"

Тэгээд ч гэрээний 8.2 (d)-ийн (i) болон (ii) дахь заалтуудын нөхцлөөс харахад ЭТТ нь ашиглалтын тусгай зөвшөөрлөө Гуравдагч этгээдэд зарах, шилжүүлэх боломж гарахгүй байхаар зохицуулжээ. Тухайлбал, уг заалтуудад ЭТТ болон тусгай зөвшөөрөл шилжүүлэн авагч этгээдийн хооронд бичгээр байгуулсан гэрээний хуулбарыг ЭР-д хүргүүлнэ. Эрх шилжүүлэн авагч нь

ЭТТ-ын энэ гэрээ болон Хөрөнгө оруулалтын гэрээгээр хүлээсэн үүргийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсан баримт бичгийг ЭР-н санал болгосон агуулга, хэлбэрээр ЭР-тай байгуулна гэжээ. ЭР нь нөгөө талдаа хүлээн зөвшөөрөх аргагүй нөхцөл, болзол бүхий баримт бичгийг зориуд санал болгоход л энэ хэлцэл биелэгдэхгүй.

Иймэрхүү энэ давуу эрх үүсгэж байгаа заалтыг Засгийн газар хүлээн зөвшөөрөх ёсгүй.

9.4 Хамтын ажиллагааны Гэрээний 5.1 (с) болон Хөрөнгө оруулалтын гэрээний 2.3 (с) заалтаар Цанхийн талбайгаас олборлосон нүүрсийг бусад ордоос олборлосон нүүрсний хамтаар боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх гэжээ. Бусад орд гэдэг нь ЭР-н одоо ашиглаж байгаа Ухаа худаг орд гэж ойлгогдож байна.

Учир нь Хөрөнгө оруулалтын Гэрээний 1.1 (а), 5.2 (а), 5.2 (е) заалтуудаар Тавантолгойн ордын нүүрсийг Ухаа худгийн ордын үйл ажиллагаатай уялдуулах замаар хөгжүүлэх, ЭТТ болон ЭР-н аль аль нь Цанхийн болон Ухаа худагийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилээр эзэмших мөн 20 жилээр 2 удаа сунгах нийтдээ 70 жил хүчинтэй байлгах үүрэг хүлээсэн байна. Хөрөнгө оруулалтын энэхүү гэрээний нөхцөл Ухаа худагийн ордтой холбоотой үйл ажиллагаанд мөн хамаарахаар заажээ.

Тавантолгойн ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын болон дагалдах бусад гэрээний хүрээнд Ухаа худгийн ордыг ашиглах үйл ажиллагаа хамаарах ёсгүй бөгөөд Засгийн газар, ЭТТ үүрэг хүлээх шаардлагагүй.

Ухаа худагийн орд нь энэ гэрээний зүйл биш тул Гэрээнд байгаа Ухаа худагийн ордтой холбоотой бүх заалтыг хасах нь зүйтэй. Тэгээд ч Ухаа худагийн ордтой холбоотойгоор ЭР-тай Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах шийдвэр Засгийн газар гаргаагүй.

9.5 Хамтын ажиллагааны Гэрээний 6.1 (l) заалтаар ЭТТ нь ЭР-ийн төслийн хэрэгжилт болон уул уурхайн болон бусад үйл ажиллагаанд саад учруулах, хойшлуулах эсвэл тасалдуулахгүй үүрэг хүлээсэн байна. Хэрэв ЭР нь хууль болон Гэрээ зөрчсөн үйлдэл хийх тохиолдолд ЭТТ холбогдох хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу өөрийн ашиг сонирхлоо хамгаалах үйл ажиллагаа явуулах эрхтэй байх хэлбэрээр энэ заалтыг өөрчлөх ёстой.

9.6 Хамтын ажиллагааны Гэрээний Эрх, үүрэг шилжүүлэх гэсэн Гэрээний 8 дугаар зүйлийн 8.1 (а)-д "ЭР нь ЭТТ-д бичгээр урьдчилан мэдэгдэхгүйгээр энэ гэрээний дагуу хүлээсэн эрх, үүрэг аливаа гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй" гэжээ.

Гэтэл Гэрээний 8.2 (а) заалтаар "ЭТТ нь ЭР-аас бичгээр урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр аливаа гуравдагч этгээдэд энэ Гэрээний дагуу хүлээсэн эрх, үүрэг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн шилжүүлж аливаа байдлаар захиран зарцуулахгүй" гэжээ.

Гэрээний эдгээр заалтууд Талуудын эрх тэгш байдлыг хангаагүй, хэт талын буюу ЭР-ийн эрх ашгийг хамгаалсан байна. ЭР нь ЭТТ-д бичгээр мэдэгдээд л эрх, үүргээ Гуравдагч талд шилжүүлэх боломжоо энэ заалтаар авч үлдсэн байна. Гэтэл ЭТТ нь эрх үүргээ Гуравдагч талд шилжүүлэхдээ заавал ЭР-ийн бичгээр өгсөн зөвшөөрлийг авах болж байна. ЭР нь бичгээр зөвшөөрөл өгөхгүй байхад л ЭТТ-н энэ эрхийг бүрэн хааж чадаж байна. Зүй нь Гэрээний Талууд яг ижил заалтаар үүрэг хүлээх ёстой. Өөрөөр хэлбэл, ЭР ч гэсэн ЭТТ-ын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ Гуравдагч талд шилжүүлэх эрхгүй байх ёстой.

9.7 Хамтын ажиллагааны Гэрээний 14.8 дахь заалтаар энэ Гэрээ хүчингүй болсон мөн дуусгавар болсныг үл харгалзан энэхүү гэрээний 6 дугаар зүйл (ЭТТ-н хүлээсэн эрх, үүрэг), 12 дугаар зүйл (Гэрээний нууцлал), гэрээний 13 дугаар зүйлийн (Итгэмжлэл) үйлчлэл хүчин төгөлдөр үлдэхээр зохицуулжээ.

Гэрээ хүчингүй болж талуудын эрх зүйн харилцаа дуусгавар болох тул дээрх заалтыг хүлээн зөвшөөрөх боломжгүй. Гэрээг бүрэн хэмжээгээр хүчингүй болгох нь зүйтэй. Харин нууцлалтай холбоотой заалтыг тодорхой хугацаанд мөрдөхөөр хүчинтэй үлдээж боломжтой.

9.8 Хөрөнгө оруулалтын Гэрээний 7.3 (е) заалтаар "ЭТТ нь ЭР-аас бичгээр урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр Цанхийн ашиглалтын тусгай зөвшөөрөл, түүнд хамаарах газартай холбоотой эрхэд барьцаа үүсгэх, баталгаа, батлан даалт, бусдад шилжүүлэх амлалт өгөхийг хориглоно" гэжээ. Мөн Гэрээний 14.2 дахь заалтаар ЭТТ нь ЭР-аас бичгээр урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр аливаа гуравдагч этгээдэд энэ Гэрээний дагуу хүлээсэн эрх, үүрэг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн шилжүүлж аливаа байдлаар захиран зарцуулахгүй" гэжээ.

Мөн Талуудын Хамтын ажиллагааны Гэрээний 8 дугаар зүйлийн 8.1 (а)-д "ЭР нь ЭТТ-д бичгээр урьдчилан мэдэгдэхгүйгээр энэ гэрээний дагуу хүлээсэн эрх, үүрэг аливаа гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй" гэжээ.

Хөрөнгө оруулалтын Гэрээний эдгээр заалтууд Талуудын эрх тэгш байх зарчмыг хангаагүй байна. ЭР нь ЭТТ-д бичгээр мэдэгдээд л эрх, үүргээ Гуравдагч талд шилжүүлэх боломжоо энэ заалтаар авч үлдсэн байна. Гэтэл ЭТТ нь эрх үүргээ Гуравдагч талд шилжүүлэхдээ заавал ЭР-ийн бичгээр өгсөн зөвшөөрлийг авах болж байна. ЭР нь бичгээр зөвшөөрөл өгөхгүй байхад л ЭТТ-н энэ эрхийг бүрэн хааж чадаж байна. Зүй нь Гэрээний Талууд яг ижил заалтаар үүрэг хүлээх ёстой. Өөрөөр хэлбэл, ЭР ч гэсэн ЭТТ-ын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ Гуравдагч талд шилжүүлэх эрхгүй байх ёстой.

9.9 Хөрөнгө оруулалтын Гэрээний 7.3 (f)-д ЭТТ нь гэрээний хугацаанд ЭР-ийн бизнес, үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй, төслийн хэрэгжилт, төслийн уул уурхайн болон бусад үйл ажиллагааг саатуулж, тасалдуулахгүй, хойшлуулахгүй, сөргөөр нөлөөлөх үйл ажиллагааг хязгаарлах шийдвэр гаргахгүй, арга хэмжээ авахгүй гэж зааж Талуудын хамтын ажиллагааг 30 жилийн (сунгалт 30 жил) хугацаанд хаасан байна. (2015 оны 4 дүгээр сарын 6-

ны өдрийн Гэрээний төсөлд байсан "Аливаа хэлбэр" гэдгийг энэ заалтаас хассан байна)

Энэ заалтыг зөвшөөрөх боломжгүй. ЭТТ нь Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд Ашигт малтмалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан "Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг" болон мөн хуулийн 6 дугаар бүлэгт заасан "Тусгай зөвшөөрөл эзэмшигч"-ийн үүргийг хэрэгжүүлэхийн тулд ЭР-н үйл ажиллагаанд хуулийн дагуу зайлшгүй оролцоо үүснэ.

Тэгээд ч Төсөл үргэлжлэх 60 жилийн хугацаанд хамтран ажиллаж байгаа түншүүдийн хооронд бизнесийн шийдэл бүхий олон асуудал гарч болно. Мөн ЭР нь ЭТТ-н эзэмшлийн орд газрыг ашиглаж бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа тул хамтын бизнесийг үр өгөөжтэй байлгах талаар хамтран ажиллах нь зүй ёсны асуудал.

9.10 Хөрөнгө оруулалтын Гэрээний 9.1 (a) болон (b)-д зааснаар "Ухаа худаг" орд дээр ажиллаж байгаа ЭР-н хамааралтай болон нэгдмэл сонирхолтой компаниуд болох "Энержи Ресурс Майнинг" ХХК, "Энержи Ресурс Рэйл" ХХК, "Энростехнологи" ХХК, "Юнайтэд Повер" ХХК, "Ухаа Худаг ус хангамж" ХХК, "Трансговь" ХХК, бүгд татварын тогтворжуулалтанд хамаарч байна.

Тавантолгойн ордыг ашиглах гэрээнд ЭРК-ийн охин компаниуд болон ЭР-н Ухаа худаг ордыг ашиглаж байгаа хамааралтай этгээдүүд болон нэгдмэл сонирхолтой этгээдүүд хамаарах боломжгүй. Ухаа худаг орд нь тусдаа үйл ажиллагаагаа явуулах ёстой. Ухаа худгийн ордыг эзэмшигч ЭР болон түүний охин компаниуд нь тухайн ордыг ашиглах талаар Засгийн газартай Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж татварын тогтворжуулалтанд хамаарах хүсэлтээ тусад нь гаргаж болно.

9.11 Хөрөнгө оруулалтын Гэрээний 22 (b)-д зааснаар **зөвхөн ЭР болон Хөрөнгө оруулагчид л** Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах эрхтэй заалт байна. ЭТТ гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах эрхгүй байхаар зохицуулжээ. Энэ санаа нь Гэрээний 7.2 (e) "Засгийн газар гэрээний хугацаанд ... нэмэлт нөхцөл тулгахгүй" гэж зааснаас тодорхой байна. Гэтэл Гэрээний үндсэн үндсэн хугацаа 30 жил, сунгалт 30 жил байгаа. Энэ хугацаанд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах эрх Монголын талд байхгүй байхаар хэт нэг талын ашиг сонирхлыг хамгаалсан байна. Монголын тал хэрхэвч хүлээн зөвшөөрөх боломжгүй заалт.

9.12 Хөрөнгө оруулалтын Гэрээний 23.2-т зааснаар Талуудын зөрчил арилгах хугацаа Засгийн газрын хувьд 6 сар, ЭР-н хувьд 2 жил хүртэл байгаа нь хэт ялгавартай, эрх тэгш байх зарчмыг алдагдуулж байна. Зөрчил арилгах хугацаа Талуудын хувьд ижил байх ёстой.

9.13 Хөрөнгө оруулалтын Гэрээний 21.1 (f)-д зааснаар ЭТТ болон "МТЗ"-ын үйлдэл болон эс үйлдлийн төлөө Засгийн газар тэдгээртэй хамтран болон дангаараа хариуцлага хүлээнэ гэж заасан байна.

Засгийн газар ийм үүрэг авч болохгүй. ЭТТ болон "МТЗ" нь Монгол Улсын Иргэний хууль болон Компанийн тухай хуулийн дагуу эрх зүйн чадамжтай хуулийн этгээдүүд бөгөөд бие дааж хариуцлага хүлээх ёстой.

Тэгээд ч Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг ЭРР компанид шилжүүлэх нь хууль бус бөгөөд зөвшөөрөхгүй гэдгээ "МТЗ"-ийн Гүйцэтгэх захирал Д. Ганбат урьдчилан албан ёсоор 2015 оны 4 сарын 3-ны өдөр 01/281 албан тоотоор Засгийн газар болон холбогдох төрийн өндөр албан тушаалтануудад мэдэгдсэн тул "МТЗ" компани ирээдүйд ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

9.14 Хөрөнгө оруулалтын гэрээгээр Засгийн газар, ЭТТ болон ЭР нь Төслийн Санхүүжүүлэгчийн өмнө маш олон үүрэг хүлээсэн байна. Тухайлбал, Хөрөнгө оруулалтын Гэрээний 6.1 (n), 7.1 (h), (q), 8.4 (c), (d) заалтууд болон 8.5 дахь хэсэг гэх мэт.

Гэтэл Төслийн Санхүүжүүлэгч нь Хөрөнгө оруулалтын Гэрээ байгуулж байгаа эрх бүхий субъект биш. Төслийн Санхүүжүүлэгчийн өмнө Засгийн газар болон ЭТТ ямар нэгэн үүрэг хүлээх хэлбэрээр эрх зүйн харилцаанд орох шаардлагагүй.


Санхүүжүүлэгч нь Төслийн компани буюу ЭР-тай санхүүжилтийн гэрээг тусдаа байгуулж, тухай компаниудын хооронд байгуулагдаж буй гэрээгээр эрх, үүргийн харилцаа үүсэх ёстой.

Хөрөнгө оруулалтын болон дагалдах бусад гэрээнд байгаа Санхүүжүүлэгчтэй холбоотой харилцаа үүсгэж байгаа бүх заалтыг хүлээн зөвшөөрч болохгүй бөгөөд гэрээнээс хасах нь зүйтэй.

Түүнчлэн Тавантолгойн Ажлын хэсэг нь 2009 онд байгуулсан Оюутолгойн Хөрөнгө оруулалтын гэрээг сайтар судалж, юун дээр алдав гэдэгт шинжилгээ хийж гэрээний төсөл боловсруулахдаа анхаарч ажиллах ёстой байтал эсрэгээр Оюутолгой төслийн явцад маргаан үүсгэж байгаа бүх асуудлыг хөрөнгө оруулагч талд ашигтай байдлаар гэрээний төсөлд суулгасан нь анхаарал татаж байна. Үүнд:

	Оюу Толгойн ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын Гэрээний заалтаас	Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын Гэрээний заалтаас
1	1.11 Хөрөнгө оруулагч нь Оюу толгой ордын 6709А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дахь далд болон ил уурхайн хэсэгт ашигт малтмал олборлох, боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулах эрхтэй. Эдгээр талбай дахь ашигт малтмалын нөөцийг улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн бөгөөд Техник, эдийн засгийн үндэслэлийг	5.1(c) Энэхүү Гэрээнд заасны дагуу Төслийн компанийн гүйцэтгэсэн Цанхийн талбайн нэмэлт хайгуулын ажил болон Төслийн бусад ажлаас хамааран техник, эдийн засгийн үндэслэлд тухай бүр нэмэлт, өөрчлөлт орж болно. Эрх бүхий байгууллагын хүлээн авч бүртгэсэн техник, эдийн засгийн үндэслэлд аливаа чухал нөлөө бүхий өөрчлөлт

	<p>хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, дүрэм журмын дагуу геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хянуулахаар хүргүүлсэн. Техник, эдийн засгийн үндэслэлийг хүргүүлсэн өдрөөс нь хойш 150 /зуун тавь/ хоногийн дотор хянаж дуусгана.</p> <p>16.21“техник, эдийн засгийн үндэслэл” гэж Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, эсхүл түүнтэй тэнцэхүйц олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шаардлагуудын дагуу бэлтгэсэн, ашигт малтмалын нөөцийг Гэрээт талбайгаас олборлох Техник, эдийн засгийн үндэслэлийг тухай бүр шинэчилсэн хувилбарын хамтаар;</p>	<p>эсвэл тохируулга хийх шаардлагатай гэж Төслийн компани үзсэн тохиолдолд тухайн өөрчлөлтийг анх хүлээн авсан Эрх бүхий байгууллагад бүртгүүлэхээрхүргүүлэх бөгөөд Эрх бүхий байгууллагаас хүсэлтийг авснаас хойш дээд тал нь 150 (нэг зуун тавь) хоногийн дотор хүлээн авч, бүртгэх шийдвэр гаргана. Шаардлагатай тохиолдолд Монгол Улсын холбогдох хуультогтоомжийн дагуу шийдвэрлэнэ (цаашид “ТЭЗҮ” гэх).</p> <p>Тайлбар: Англи эхэд “шаардлагатай тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ” гэж заагаагүй, орчуулга буруу хийсэн. Түүнчлэн Монгол Улс одоогоор ТЭЗҮ хүлээн авах журамгүй, Эрдэс баялаг Эрчим хүчний сайдын 2012 оны 74 дүгээр тушаалаар батласан журам нь Хууль зүйн яаманд бүртгэгдээгүй, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ болж чадаагүй байна.</p>
2	<p>15.1 Хөрөнгө оруулагч нь Засгийн газрын зөвшөөрсний дагуу энэхүү Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ бусдад шилжүүлэх эрхтэй.</p>	<p>6.1(n) Төслийн компани энэхүү Гэрээгээр олгогдсон эрх, үр шимийг Санхүүжүүлэгчид барьцаалах эсвэл шилжүүлэх эрхтэй;</p> <p>8.3(b) Хөрөнгө оруулагчид болон Төслийн компани нь Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт авах зорилгоор энэхүү Гэрээний дагуу эдлэх эрх болон үр шим, Цанхийн талбайгаас олборлосон, боловсруулсан бүтээгдэхүүн, нүүрс боловсруулах үйлдвэр, ус, эрчим хүч хангамжийндэд бүтэц, бусад байгууламж, барилгын ажил, Төслийн бусад хөрөнгө, эд хөрөнгийн эрх, ашиг сонирхлын хувьд барьцааны сонирхол үүсгэх эрхтэй;</p> <p>8.4(d) Засгийн газар шаардлагатай бол эрх бүхий байгууллагуудтай хамтран Санхүүжүүлэгчийн хүсэлтээр Төслийн компанийг оролцуулан шууд гэрээ (цаашид “Шууд гэрээ” гэх) байгуулна. Шууд гэрээнд дараах үндсэн</p>

1. 

		<p>нехцлүүдийг тусгана:</p> <p>(i) Төслийн компани энэхүү Гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Санхүүжүүлэгчид боломжит хугацаанд мэдэгдэх ба Санхүүжүүлэгч нь Төслийг өөрөө хэрэгжүүлж, зөрчлийг арилгах арга хэмжээ авах боломжит хугацаа эдлэх эрхтэй;</p> <p>Тайлбар: Төслийн компани эрх, үр шимийг барьцаалж зээл авах нь тодорхой бөгөөд үүнийг Засгийн газар хүлээн зөвшөөрч, санхүүжүүлэгчидтэй “Шууд гэрээ” байгуулахаар заажээ.</p>
3	<p>9.10 Хөрөнгө оруулагч дараахь эрхийг эдэлнэ:</p> <p>9.10.3Бүтээгдэхүүний экспорт, борлуулалт, солилцооноос гадаад улсад олсон бүх орлогоо гадаад улсад хадгалах болон чөлөөтэй зарцуулах;</p> <p>9.10.4Бүтээгдэхүүний экспорт, борлуулалт, солилцооноос Монгол Улсад олсон бүх орлого /үүнд ногдол ашиг болон бусад төрлийн хуваарилалт орно/ болон гадаад улсад хийх аливаа бусад төлбөр /үүний дотор үндсэн зээл болон хүүгийн төлбөр/-ийг гадаад улс руу саадгүй шилжүүлэх болон чөлөөтэй зарцуулах;</p>	<p>3.7(c) Төслийн компани Монгол Улсын болон бусад улсын арилжааны банкинд данс нээж, сонгосон валютаараа, олон улсын гүйлгээг чөлөөтэй саадгүйгээр хийх эрхтэй бөгөөд үүнд дараах үйл ажиллагаа хамаарна:</p> <p>(ii) Мөнгөн хөрөнгөө Монгол Улсад болон Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна эзэмших, татварын үүргээ биелүүлсний дараа чөлөөтэй захиран зарцуулах;</p> <p>(iii) Бүтээгдэхүүний экспорт, борлуулалт, арилжаанаас Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна олсон орлогоо Монгол Улс болон гадаад улсад байршуулах, чөлөөтэй захиран зарцуулах;</p> <p>(iv) Бүтээгдэхүүн борлуулалт, арилжаа, экспортоос Монгол Улсын нутаг дэвсгэрт олсон орлогоо (ногдол ашиг хуваарилах зэрэгхэлбэрээр) Монгол Улс болон гадаад улсад байршуулах, чөлөөтэй захиран зарцуулах (зээлийн үндсэн төлбөр болонхүүгийн төлбөр гэх мэтчилэн), бусад төлбөрийг гадаад улсад хийх;</p> <p>Тайлбар: Бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг Монгол Улсад байрлуулах албагүй байдаг Оюутолгой төслийн заалтыг давтжээ. 2015 оны эхээр Засгийн газар, Төв банкны зүгээс Оюутолгой</p>

		төслийн алтны борлуулалтанд ноогдох гадаад валютыг Монгол Улсад байрлуулж дотоодын валютын ханшийн өсөлтийг тогтоон барих хүсэлт тавьсан боловч үр дүнд хүрээгүйг тэмдэглэе.
4	9.6 Оюу толгой төслийг зах зээлийн болон санхүүжилтийн /үүнд Оюу толгой төслийг санхүүжүүлэх эх үүсвэрийн бүрдүүлэлт болон нөхцөл хамаарна/ нөхцөл байдлыг харгалзан үзэж, Техник, эдийн засгийн үндэслэлд заасны дагуу Хөрөнгө оруулагчийн шийдвэрлэснээр үе шаттайгаар хэрэгжүүлж болно. Хөрөнгө оруулагч нь Оюу толгой төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн дараалалдаа томоохон өөрчлөлт хийх тохиолдолд энэ тухай геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бичгээр мэдэгдэнэ.	4.2(b) Төслийн компани нь зах зээлийн нөхцөл болон санхүүжилтийн асуудлыг(Төслийг санхүүжүүлэх боломж, хугацаа зэргийг) харгалзантаддорхойлсны дагуу Төслийн бүтээн байгуулалтыг үе шаттайгаархэрэгжүүлж болно. Төслийн компани Төсөл хэрэгжүүлэхээр саналболгосон үе шат, дараалалд томоохон өөрчлөлт оруулах бол Засгийнгазарт тухайн өөрчлөлтийн талаар бичгээр мэдэгдэнэ. Тайлбар: Англи эх нь Оюутолгойн гэрээний заалттай адил байна. Оюутолгой төслийг олон үе шатад хуваах, улмаар үе шат бүрт зээл авах, барьцааны сонирхол үүсгэх, ингэснээрээ Монгол Улс хүртэх үр өгөөжид шууд нөлөөлсөн заалтыг хуулбарлан оруулжээ.
5	9.5 Хөрөнгө оруулагч нь Айвенхоу Майнз Лимитед болон Рио Тинтогийн санхүүгийн чадамжаар бүрдсэн Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлээр Оюу толгой төслийн хайгуул болон бүтээн байгуулалтад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн болно. Хөрөнгө оруулагч нь энэхүү Гэрээний 3.6-д заасан Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан ойролцоогоор 4 тэрбум долларын нэмэлт хөрөнгө оруулалтыг Оюу толгой төсөлд хийхээр төлөвлөж байна. Тооцоолсон эхний хөрөнгө оруулалтыг 5 /тав/ жилийн хугацаанд хийх бөгөөд хөрөнгө оруулалтын зардлын энэ хуваарийг Техник, эдийн засгийн үндэслэлд тусгана.	2.8(a) Урьдчилсан тооцоогоор Төслийн компаниас энэхүү Төсөлд оруулах нийтхөрөнгө оруулалт нь ойролцоогоор 4 (дөрөв) тэрбум ам.доллар байна. Тайлбар: Оюутолгой төслийн анхны хөрөнгө оруулалтыг ийнхүү “ойролцоогоор” зааж өгсөн нь зардал хэтрэх, улмаар Монгол Улсад төлөх татвар, үр өгөөжид нөлөөлж, маргаан үүсэх үндсэн шалтгаан болсон.
6	3.13 Хөрөнгө оруулагч нь энэхүү Гэрээ байгуулсан өдөр хүчин төгөлдөр	9.2(r) Энэхүү Гэрээний 9.2(a) хэсэгт заасны дагуу талууд

	мердеж байсан Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.2-т заасны дагуу Гэрээт талбайгаас олборлож худалдсан, худалдахаар ачуулсан, эсхүл өөрөө ашигласан бүх Бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5 /тав/ хувиар тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлөх бөгөөд төлбөрийг тогтворжуулна.	Тогтворжуулаххугацаанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг Гэрээ хүчинтөгөлдөр болох өдөр үйлчилж байсан дараах хувь хэмжээгээртогтворжуулахаар тохиролцсон болно: (ii) Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн 47.3.2-т заасныдагуу олборлон экспортолсон нүүрсний ашигт малтмалын нөөцашигласны төлбөрийн суурь хэмжээ нь тухайн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсвэл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5,0 (тав) хувьтай тэнцүү байхаар; Тайлбар: Гуравдагч зах зээлд борлуулах бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг хэрхэн тооцох, гэрээний үнийн дүнг хэрхэн баталгаажуулахыг тодорхой зааж өгөөгүйгээс ирээдүйд татварын маргаан гарах магадлалтай. Оюутолгой төслийн хүрээнд яг энэ асуудлаар маргаан гарч байсан.
7	2.2 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн үйлчлэлийн дүнд суутгах татварыг уг хууль /энэхүү Гэрээг байгуулсан өдөр хүчин төгөлдөр үйлчилж байсан/-д заасан хувь хэмжээ түүний дотор Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т заасны дагуу хэрэглэх аливаа давхар татварын холбогдох гэрээнд заасан хувь хэмжээний дагуу тооцох бөгөөд энэ хувь хэмжээг тогтворжуулна.	9.2(c) Энэхүү Гэрээ Хүчин төгөлдөр болох өдөр үйлчилж байсан Монгол УлсынАж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу суутгахтатварыг уг хуульд заасан хувь хэмжээ болон Монгол Улсын Татварынерөнхий хуулийн 2.2-т заасны дагуу хэрэглэх давхар татвараасзайлсхийх холбогдох гэрээнд заасан хувь хэмжээний дагуу тооцох бөгөөдтэдгээр хувь хэмжээг тогтворжуулна. Тодруулбал, энэхүү заалт нь зөвхөнТөслийн компаниас зээлдүүлэгч болон хувьцаа эзэмшигчдэд төлөхзээлийн хүүгийн суутган татвар болон хувьцаа эзэмшигчдэд төлөх давууэрхийн болон энгийн хувьцааны ногдол ашгийн төлбөрт хамаарна; Тайлбар: ААНОАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9-д заасан албан татвар суутгах бусад орлогыг яагаад хасч, зөвхөн зээлийн хүү, ноогдол ашгаас татвар суутгахаар

		заасныг тодруулах шаардлагатай.
8	<p>2.12. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу уул уурхай, дэд бүтцийн салбарын алдагдлыг ирээдүйд шилжүүлэх горимыг баталсан Засгийн газрын 2009 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 287 дугаар тогтоол, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2-т заасны дагуу тодорхойлох Хөрөнгө оруулагчийн татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлэн уг алдагдал гарсан татварын жилийн дараахь дараалсан 8 (найм) жилийн албан татвар ногдуулах орлогоос хасч тооцно.</p>	<p>2.2(d) Нэмэлт хайгуулын ажилд зарцуулсан Төслийн компанийн зардлыг энэхүү Гэрээний 9.2(i) хэсэгт заасны дагуу Төслийн компанийн татвар ногдох орлогоос хасч тооцно.</p> <p>9.2(i) Тогтворжуулах хугацаанд Засгийн газрын 2009 оны 287 дугаар тогтоол болон Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.1, 20.2-т заасны дагуу тодорхойлох Татварыг нь тогтворжуулсан этгээдийн татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлж, уг алдагдал гарсан татварын жилийн дараахь дараалсан 8 (найман) жилийн албан татвар ногдуулах орлогоос хасч тооцно;</p> <p>Тайлбар: Зардал их байх тусам Монгол Улсад төлөх татварын хэмжээ багасч, татварын маргаан үүсэх эрсдэлтэй. Оюутолгой төслийн хүрээнд мөн л энэ асуудлаар маргаан үүсч байв.</p>
9	<p>3.10. Талууд Оюу толгой төслийн санхүүжилтийн талаар дараахь байдлаар харилцан тохиролцов:</p> <p>3.10.1. Хөрөнгө оруулагч нь Оюу толгой төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах Санхүүжилтийг бүрдүүлсэн өдөр тохиосон тухай мэдэгдлийг тухайн өдрөөс хойш 7 /долоо/ хоногийн дотор Засгийн газарт хүргүүлнэ.</p> <p>3.10.2. Хөрөнгө оруулагч нь Санхүүжилтийг бүрдүүлсэн өдрөөс хойш 5 /тав/ жилийн дотор үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлнэ.</p> <p>3.10.3. Энэхүү Гэрээний 3.10-т заасан "Санхүүжилтийг бүрдүүлсэн өдөр" гэж дараахь нөхцөлүүдийн аль түрүүлж биелсэн өдрийг хэлнэ:</p> <p>3.10.3.1. Хөрөнгө оруулагч нь энэхүү Гэрээний 1.11-д заасан Техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу Оюу</p>	<p>12.4(a) Төслийн компани нийт Бүтээгдэхүүний 75 хувийг БНХАУ-ын зах зээлд, үлдсэн 25 хувийг Худалдааны хамтарсан компаниар дамжуулан Япон, БНСУ, Энэтхэг болон бусад улс орон, бүс нутгийн зах зээлд нийлүүлэхээр зорьж буй бөгөөд бүтээгдэхүүний борлуулалтын бодит хэмжээ нь төмөр замын дамжуулан тээвэрлэлтийн боломж, зах зээлийн нөхцөл байдал, үнэ зэрэг олон хүчин зүйлээс шалтгаална;</p> <p>Тайлбар: Монгол Улсын хувьд амин чухал асуудлыг Хөрөнгө оруулалтын гэрээнд хэт ерөнхий, ойлгомжгүй, зөрчвөл хүлээх хариуцлага нь тодорхойгүй байдлаар тусгадаг жишиг давтагджээ.</p>

	<p>толгой төслийг бүрэн барьж ашиглалтанд оруулахад шаардагдах санхүүгийн хангалттай эх үүсвэрийг баталгаа, барьцаа, бусад хэлбэрийн дэмжлэгийг Хөрөнгө оруулагч хүлээн авахуйц нөхцөлөөр баталгаажуулж, /эсхүл бэлэн болгож/ энэ тухайгаа Засгийн газарт бичгээр мэдэгдсэн өдөр, эсхүл</p> <p>3.10.3.2. энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2 /хоёр/ жил өнгөрсөн бол;</p>	
10	<p>Энэхүү Гэрээний 14.1-т заасны дагуу маргааныг хэлэлцээний журмаар шийдвэрлэж чадаагүй бол түүнийг уг маргаан гарсан өдөр үйлчилж буй Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын Арбитрын Дүрэм /НҮБОУХЭЗК Дүрэм/-ийн дагуу заавал биелүүлэх арбитрын зарчмаар шийдвэрлэнэ. Арбитрын үйл ажиллагаа дараахь журмаар явагдана.</p> <p>14.2.1. Арбитрчийн тоо 3 /гурав/ байх;</p> <p>14.2.2.3 /гурав/ арбитрчдийг НҮБОУХЭЗК-ийн Дүрмийн 7, 8-д заасан журмын дагуу томилох;</p> <p>14.2.3. Арбитрын ажиллагааг англи хэл дээр явуулах;</p> <p>14.2.4. Арбитрын бүрэлдэхүүн Хөрөнгө оруулалтын гэрээг тайлбарлахдаа Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэглэх;</p> <p>14.2.5. Арбитрын ажиллагааг явуулах газар нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Лондон хот байх;</p> <p>14.2.6. Арбитрын ажиллагааг НҮБОУХЭЗК-ийн дүрмийн дагуу Лондонгийн Олон улсын арбитрын Шүүх удирдан явуулах.</p>	<p>26.1(d) Арбитрын журмаар шийдвэрлэх:</p> <p>(i) Гэрээний 26.1(b) хэсэгт заасны дагуу талуудын удирдах албан тушаалтнуудын хооронд хийсэн уулзалтын үр дүнг харгалзан талууд мэдэгдэл өгсөн өдрөөс хойш 60 (жар) хоногийн дотор Маргааныг шийдвэрлэж чадахгүй бол аль нэг тал нь арбитрын журмаар шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргах эрхтэй. Тодруулбал, Талууд маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлэхээс өмнө Шинжээчид хандахгүй байж болно;</p> <p>(ii) Талууд Улс орнууд ба гадаад улсын иргэд хоорондын хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх конвенци (цаашид "ХОМШКонвенци" гэх)-ийн дагуу Маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлэхээр Хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх олон улсын төв (цаашид "ХОМШОУТ" гэх)-д хандахаар тохиролцсон;</p> <p>(iii) Арбитрчдын тоо 3 (гурав) байх бөгөөд Засгийн газар, Төслийн компани, тухайн Арбитрын дарга тус бүр 1 (нэг) арбитрчиг даргалах нэг (1) арбитрчиг ХОМШОУТ-ийн арбитрын дарга тустус сонгоно;</p> <p>(iv) Арбитрын үйл ажиллагаа англи хэл дээр явагдана;</p> <p>(v) Арбитрын шийдвэр нь талуудын хувьд эцсийн бөгөөд заавал биелэгдэх шинжтэй байх ба түүний шийдвэрийг</p>

	<p>холбогдох, харъяалах аль ч шүүхээр баталгаажуулан хэрэгжүүлж болно;</p> <p>(vi) Арбитрын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг Лондонхотноо явуулна;</p> <p>(vii) Талууд нь арбитрын шийдвэрийг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэхээ үүгээр илэрхийлж байна.</p> <p>(e) Энэхүү зүйлд заасан Маргаан шийдвэрлэх журам нь Гэрээ хүчинтөгөлдөр эсэхээс үл хамааран хүчин төгөлдөр үйлчилнэ;</p> <p>Тайлбар: Төслийн компани Хөрөнгө оруулалтын гэрээг ноцтой зөрчсөн тохиолдолд Монгол Улсын Засгийн газар Лондонгийн арбитра хандах боломж/чадавхибуй юу? Арбитра хандсаны улстөрийн риск, хөршүүдтэйгээ харилцах харилцаанд үзүүлэх нөлөөлөл нь юу байх вэ гэдэгт үнэлгээ өгөх шаардлагатай. Гадаадын хөрөнгө оруулагч болох Чайна Шэнхуа Энержи Компани Лимитед-ийн хувьцааны 73 хувийг БНХАУ-ын Төрийн өмчит Шэнхуа Групп эзэмшдэг гэж Moody's агентлагийн тайланд дурьджээ.</p>
--	--

Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах Консорциумтай байгуулахаар төлөвлөж байгаа Хамтын ажиллагааны гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээ, Төмөр замын концессийн гэрээний төсөл нь гэрээ байгуулж байгаа Талуудын эрх тэгш байдлыг хангаагүй, Хөрөнгө оруулагч талд хэт давуу байдал олгосон, Засгийн газар болон төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой"ХК-ийн эрхийг хязгаарласан шударга бус зохицуулалт бүхий гэрээ болжээ гэж дүгнэж байна.

Арав. Гэрээ байгуулснаас үүсэх эдийн засгийн үр өгөөж, эерэг болон сөрөг талуудыг дүгнэх,

10.1 Консорциумын санал болгож байгаа хэлбэрээр Хөрөнгө оруулалтын болон дагалдах бусад гэрээг байгуулах тохиолдолд Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах төслийн эдийн засгийн үр өгөөжийг тооцоолох боломжгүй байна.

Учир нь Хөрөнгө оруулалтын Гэрээний 2.1 (c) болон (d)-д зааснаар "ЭР нь уулын ажлын нарийвчилсан төлөвлөгөө, барилгын болон уул уурхайн үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалтын нөхцлийг тодорхойлж, уул уурхайн үйл ажиллагааны хүрээг тодорхойлох болон тооцоолол, уурхай хөгжүүлэх, хайгуул хийх төлөвлөгөө гаргах, тайланг бие даан өөрийн үзэмжээр гаргах,

төслийн бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг гаргах, шаардлагатай бүх арга хэмжээг авах бүрэн эрхтэй",

Мөн ЭР нь "Тавантолгойн ордыг ашиглах ТЭЗҮ боловсруулах, түүнд өөрчлөлт, нэмэлт хийх, уурхайн нарийвчилсан төлөвлөгөө, бүтээн байгуулалтын хөтөлбөр, уул уурхайн үйл ажиллагааны болон барилга угсралтын зардлыг тодорхойлох, хөрөнгө оруулалтын болзол нөхцлийг тогтоох, Тавантолгойн ордоос боловсруулсан бүтээгдэхүүн болон олборлосон нүүрсээ экспортлох, худалдах, тээвэрлэх, худалдах, маркетинг хийх бүх ажиллагааг бие даан зохион байгуулах эрхтэй", (Хөрөнгө оруулалтын гэрээний 5.1 (b), Хамтын ажиллагааны гэрээний 5.1 (d, n) заалт)

Мөн ЭР нь "Цанхийн талбайгаас аль ч жилд олборлох, боловсруулах бүтээгдэхүүний тоо хэмжээ болон бүтээгдэхүүн нийлүүлэх зах зээлийг сонгох, нүүрс боловсруулах зардал, үнэлгээг тодорхойлох, борлуулах, бүтээгдэхүүний тоо хэмжээ, худалдах үнийг тогтоох, тээврийн давтамж, тээвэрлэлтийн хэлцэл болон арилжааны бусад нөхцлийг тодорхойлох зэрэг бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой шийдвэрийг дангаараа бие даан тодорхойлох, бие даан ажиллах эрхтэй", (Хөрөнгө оруулалтын гэрээ 2.4 (b) болон 2.5 (b) заалт)

Мөн Хөрөнгө оруулалтын Гэрээний 2.8 (b), 4.3 (a, c) болон 5.1 (b), (c)-д зааснаар "хөрөнгө оруулалтын энэ дүн нь тооцоолсон дүн ба тухай бүр өөрчлөлт оруулсан ТЭЗҮ-ээр нарийвчилж тодорхой болох бөгөөд зах зээлийн нөхцөл хөрөнгө оруулалтын явцаас хамаарч өөрчлөгдөж болно. Санхүүжилтийн гэрээнд болон ТЭЗҮ-д үндэслэн хөрөнгө оруулалт хийх хуваарийг ЭР тодорхойлно, үйл ажиллагааны шаардлага, тухайн зах зээлийн нөхцлийг харгалзан, санхүүжилтийн гэрээгээр зөвшөөрөгдсөн хүрээнд хөрөнгө оруулалтын хуваарьт нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй. Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс 12 сарын хугацаанд ЭТТ-н боловсруулсан одоогийн ТЭЗҮ шинээр хийнэ, нэмэлт хайгуулын ажил болон төслийн бусад ажлаас шалтгаалан ТЭЗҮ-д тухай бүр нэмэлт, өөрчлөлт орж болно" гэж тус тус заажээ.

Иймд Консорциумтай байгуулах Хөрөнгө оруулалтын болон дагалдах бусад гэрээний дээр дурьдсан заалтуудаас дүгнэхэд Гэрээ байгуулснаар төлөхөөр заасан урьдчилгаа төлбөр (200 сая ам.доллар), Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төлбөр (192, 226, 432 ам. доллар), "Чалко" компанийн төлбөр (142 сая ам.доллар) зэргээс бусдаар эдийн засгийн өгөөжийн тооцоог тодорхойлох боломжгүй байна.

ЭР зах зээлийн шалтгаанаар олборлох, боловсруулах нүүрсний хэмжээг бие даан тодорхойлох нь Засгийн газарт төлөх татвар болон ЭТТ-д төлөх хамтын ажиллагааны төлбөрийг багасгах эрсдэлтэй.

10.2 ЭР-ийн явуулж буй эдийн засгийн өр өгөөжийн сурталчилгааны тухай

Хөрөнгө оруулагч Консорциумтай гэрээлснээр Монгол улсад ирэх бодит өгөөж буюу гэрээ зурагдмагц 620 сая долларын мөнгөн урсгал шууд орж ирнэ гэж ЭР явуулж байгаа сурталчилгаа нь Хөрөнгө оруулалтын Гэрээнд заасан заалтуудтай нийцэхгүй байна.

<p>“Энержи Ресурс” компанийн сурталчилгаанд</p>	<p>Хөрөнгө оруулалтын гэрээнд зааснаар</p>
<p>Урьдчилгаа төлбөр 200 сая доллар төлнө. (Гэрээ зурагдмагц)</p>	<p>3.3 Урьдчилгаа төлбөр</p> <p>(a) Төслийн компани нь нийт 200 (хоёр зуун) сая ам.долларын урьдчилгаа төлбөр (цаашид “Урьдчилгаа төлбөр” гэх)-ийг <u>Гэрээний 3.3(d) хэсэгт заасан бүх урьдчилсан нөхцлүүд бүрэн биелэгдсэнээс хойш</u> хуанлийн [10] хоногийн дотор (“Урьдчилгаа төлбөр төлөх өдөр”) Засгийн газар болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-д төлнө;</p> <p>(b) Урьдчилгаа төлбөр нь цаашид Төслийн компанийн (i) Засгийн газарт ирээдүйд төлөх татвар (ii) энэхүү Гэрээний 3.1 хэсэгт заасны дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-д төлөх Хамтын ажиллагааны төлбөрөөс (цаашид (i), (ii)-р дэд хэсэгт заасан төлбөрийг хамтад нь “Суутгах дүн” гэх) суутган хасагдах замаар бүрэн нөхөн төлөгдөнө. Төслийн компани нь Суутгах дүнтэй холбоотой болзол, нөхцлийг нарийвчлан зохицуулах урьдчилгаа төлбөрийн гэрээг “Эрдэнэс Тавантолгой” ХК болон Засгийн газартай тус тусад нь байгуулна;</p> <p>(c) Урьдчилгаа төлбөрийн нийт дүнгээс Суутгах дүнг хассаны дараах урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл дүнд жилийн [4.5%]-ийн хүү (цаашид “Хүү” гэх) тооцохоор талууд тохиролцов;</p>
<p>Чалко-н өрийн төлбөр 140 сая долларыг төлнө (Гэрээ зурагдмагц)</p>	<p>3.4 ЭТТ-н одоогийн хөрөнгө болон төлбөрийн үүрэгтэй холбоотой зохицуулалт</p> <p>(a) “Эрдэнэс Тавантолгой” ХК болон БНХАУ-ын Чалко Трэйдинг (Хонгконг) компани нарын хооронд 2011 онд байгуулагдсан нүүрс нийлүүлж, худалдан авах гэрээ (цаашид “Чалкогийн гэрээ” гэх)-ээс үүдсэн [142 (нэг зуун дөчин хоёр) сая] ам.долларын үлдэгдэл өр төлбөрийг хуримтлагдсан хүү байгаа бол хамтад нь (цаашид “Чалкогийн өр” гэх) “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн өмнөөс Төслийн компани бүтээгдэхүүн нийлүүлэх замаар эсвэл бэлэн мөнгөөр төлөхийг бие даан шийдвэрлэх ба төлөх хэлбэрийг Төлбөр барагдуулах гэрээгээр тодорхойлно. Чалкогийн өрийг Урьдчилгаа</p>

	<p>төлбөр төлөх өдрөөс эхлэн 12 сарын хугацаанд бүрэн төлж барагдуулна.</p> <p>Чалкогийн гэрээ нь Төслийн компанид шилжихгүй бөгөөд Чалко болон “Эрдэнэс Тавантолгой” ХК нь Чалкогийн гэрээний талууд хэвээр үлдэнэ;</p> <p>(b) Эрх, үүрэг шилжүүлэх гэрээг байгуулахаас өмнө үүссэн, энэхүү Гэрээний 3.4(a) хэсэгт зааснаас бусад аливаа өр төлбөрөө “Эрдэнэс Тавантолгой” ХК өөрөө дангаараа хариуцна;</p>
<p>Төмөр замын ажлын нөхөн төлбөр 280 сая долларыг төлнө (Гэрээ зурагдмагц)</p>	<p>Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн ажлын санхүүжилтэд “МТЗ” ХК 196.709.432 сая ам.доллар зарцуулсан байна.</p> <p>Монгол улсад шинээр баригдах төмөр замын зургийн ажилд болон санхүүгийн зөвлөхийн төлбөрт 22.517,00 сая ам.доллар төлсөн байна.</p> <p>Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ажилд Энержи Ресурс компаниас 93.6 тэрбум төгрөг зарцуулсан байна.</p> <p>(Энэ мөнгийг Эдийн Засгийн Хөгжлийн сайд, Сангийн сайд, Зам, Тээврийн сайдын хамтарсан тушаалаар байгуулсан ажлын хэсгийн дүгнэлтээр хүлээн зөвшөөрсөн, төслийн зориулалтын компанийн хувьцаанд хөрвүүлэх буюу буцаан олгох хөрөнгө оруулалтанд тооцно)</p> <p>Нийт дүн: 192. 226. 432 ам. доллар 93.6 тэрбум төгрөг</p> <p>Хөрөнгө оруулалтын Гэрээний 3.5 (a)-д зааснаар “Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлтэй холбоотой Засгийн газраас зарцуулсан бодит зардлыг консорциумын зүгээс хийлгэсэн санхүү, техникийн болон хууль зүйн дүн шинжилгээнд үндэслэн Концесс эзэмшигч нь Төмөр замын концессийн гэрээний дагуу Засгийн газарт буцааж төлнө”</p> <p>Хөрөнгө оруулалтын Гэрээний 3.5 (b)-д заасан 6 урьдчилсан нөхцөл⁵ биелснээр төлбөрийг төлнө.</p>

⁵Хөрөнгө оруулалтын Гэрээний 3.5 (b)-д заасан нөхцлүүд 1.Энэхүү Гэрээ, хамтын ажиллагааны гэрээ болон Төмөр замын концессийн гэрээг талууд зохих ёсоор байгуулж, хүчин төгөлдөр болсон, 2.Концесс эзэмшигч нь төмөр зам барих тусгай зөвшөөрөл авсан, 3.Консорциум нь Ухаа

	Эдгээр заалтаас харахад Гэрээ зурагдмагц төмөр замын төсөлд Засгийн газраас зарцуулсан төлбөр шууд орж ирэхгүй.
--	---

БНХАУ-ын Чалко компанид төлөх өр142 сая ам. долларын өрийг нүүрсээр төлөх боломжийг гэрээнд зааснаар энэ төлбөр гэрээ зурагдмагц мөнгөн хэлбэрээр төлөгдөнө гэдэг нь эргэлзээтэй байна.

Хөрөнгө оруулалтын гэрээний 3.3 (а)-д зааснаар энэхүү Гэрээний 3.3(d) хэсэгт заасан бүх урьдчилсан нөхцлүүд⁶ бүрэн биелэгдсэнээс хойш хуанлийн [10] хоногийн дотор ("Урьдчилгаа төлбөр төлөх өдөр") Засгийн газар болон "Эрдэнэс Тавантолгой" ХК-д төлнө" гэснээс харахад гэрээ зурагдмагц урьдчилгаа 200 сая ам.доллар орж ирэхгүй.

Мөн Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд Засгийн газраас зарцуулсан 192. 226. 432 ам. доллар нь Хөрөнгө оруулалтын гэрээний 3.5 (b)-д заасан урьдчилсан 6 нөхцөл биелтэл орж ирэхгүй.

10.3 ЭР-ийн сурталчилгаанд дурьдсанжил тутамын тогтмол өгөөжийн тухай:

Экспортын орлого 1.2 тэрбум (Валютын урсгалыг тэлж, ханшийг тогтворжуулна)	Хөрөнгө оруулалтын Гэрээний 3.7 (c) (iii) заалт "Бүтээгдэхүүний экспорт, борлуулалт, арилжаанаас Монгол улсын нутаг, дэвсгэрт олсон орлогоо (ногдол ашиг хуваарилах зэрэг хэлбэрээр) Монгол улс болон гадаад улсад байршуулах, чөлөөтэй захиран зарцуулах, бусад төлбөрийг гадаад улсад хийх" Хөрөнгө оруулалтын Гэрээний 3.7 (c) (iv) заалт "Бүтээгдэхүүн борлуулалт, арилжаа,
---	--

худаг- Гашуунсухайт төмөр замын төсөлд дүн шинжилгээ хийж дууссан, 4.Дүн шинжилгээний үр дүнд Концесс эзэмшигч болон МТЗ-ын хооронд Төсөл шилжүүлэх гэрээ байгуулж, тус гэрээнд заасны дагуу хүлээлцэх актад гарын үсэг зурж бүх шилжүүлэх ажиллагааг хийж дууссан, 5.Засгийн газраасТөмөр замын концессийн дагуу баригдах төмөр замын суурь бүтцийн чигийг баталсан, 6. Засгийн газраас Төмөр замын концессийн гэрээнд заасны дагуу зурвас газрын зөвшөөрлийг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу олгосон

⁶Урьдчилгаа төлбөр төлөх урьдчилсан нөхцөл дараах болно. Үүнд: (i) Энэхүү Гэрээ, Хамтын ажиллагааны гэрээ болон Төмөр замын концессийн гэрээ Талуудын хооронд зохих ёсоор байгуулагдаж, хүчин төгөлдөр болсон, (ii) Концесс эзэмшигч нь төмөр зам барих тусгай зөвшөөрөл авсан, (iii) Энэхүү гэрээний3.3 хэсэгт заасан урьдчилгаа төлбөртэйгээр холбоотойгоор Төслийн компани Монгол улсын Сангийн яам болон ЭТТ-тэй урьдчилгаа төлбөрийн гэрээ байгуулсан, (iv) ЭТТ-н Цанхийн талбайн уул уурхай үйлдвэрлэл, үйл ажиллагаа борлуулалт, тээвэрлэлттэй холбоотой одоогийн хөрөнгө болон Цанхийн талбайн нүүрс олборлолт, борлуулалт, ажилчидтай холбоотой гэрээнүүдэд Төслийн компани санхүү, техникийн болон хууль зүйн дүн шинжилгээ хийж дууссан, (v) Дүн шинжилгээний үр дүнд үндэслэн Төслийн компани болон ЭТТ нь Эрх, үүрэг шилжүүлэх гэрээ байгуулсан бөгөөд тус Эрх, үүрэг шилжүүлэх гэрээнд заасны дагуу хүлээлцэх актад гарын үсэг зурж шилжүүлэх ажлыг бүрэн дуусгасан, (vi) Энэхүү Гэрээний 3.4 (а) хэсэгт заасны дагуу Төслийн компани болон ЭТТ нарын хооронд Чалкогийн өртэй холбоотойгоор төлбөр барагдуулах гэрээ байгуулагдсан, (vii) ЭТТ нь ТТ-н газрыг Төслийн компанид бүрэн шилжүүлсэн, (viii) Гэрээний 4.1 (d) хэсэгт заасан бүх нөхцөл бүрэн биелсэн

	экспортоос Монгол улсын нутаг, дэвсгэрээс гадна олсон Монгол улс болон гадаад улсад байршуулах, чөлөөтэй захиран зарцуулах" Дээр дурьсан гэрээний заалтуудаас харахад Бүтээгдэхүүний экспортын орлогыг ямар хувиар Монгол улс болон гадаад улсад байршуулах нь тодорхой биш учир ЭР нь бүх орлогоо гадаадад байршуулах эсвэл маш бага хэсгийг Монгол улсад үлдээгээд ихэнхи орлогыг гадаадад байршуулах боломжтой. Дүгнэлтийн Мөнгөн хөрөнгө, орлогын тухай гэсэн 10.5 дахь хэсгийг харна уу.
Эхний 5 жилд 5 тэрбум долларын хөрөнгө оруулалт шинээр хийгдэнэ	Хөрөнгө оруулалтын Гэрээний 2.8 (b), 4.3 (a, c) болон 5.1 (b), (c)-д зааснаар <u>хөрөнгө оруулалтын энэ дүн нь зах зээлийн нөхцөл хөрөнгө оруулалтын явцаас хамаарч өөрчлөгдөж болно. Санхүүжилтийн гэрээнд болон ТЭЗҮ-д үндэслэн хөрөнгө оруулалт хийх хуваарийг ЭР тодорхойлно.</u> үйл ажиллагааны шаардлага, тухайн зах зээлийн нөхцлийг харгалзан, санхүүжилтийн гэрээгээр зөвшөөрөгдсөн хүрээнд хөрөнгө оруулалтын хуваарьт нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй, Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс 12 сарын хугацаанд ЭТТ-н боловсруулсан одоогийн ТЭЗҮ шинээр хийнэ, нэмэлт хайгуулын ажил болон төслийн бусад ажлаас шалтгаалан ТЭЗҮ-д тухай бүр нэмэлт, өөрчлөлт орж болно гэжээ. Мөн хөрөнгө оруулалтын Гэрээний 2.8 (а)-ийн (iii) заалтаар хөрөнгө оруулалтанд хөрс хуулалтыг оруулсан байна. Хөрс хуулалт нь хөрөнгө оруулалт биш, олборлолтын үйл ажиллагааны зардал юм. Үйл ажиллагааны ийм зардлыг хөрөнгө оруулалтандаа тооцвол ЭР нь маш хурдан хугацаанд хөрөнгө оруулалтаа гүйцэтгэсэн тайлан гаргахаар байна. Өөрөөр хэлбэл, зардалд тооцох үйл ажиллагаагаа хөрөнгө оруулалтанд оруулж бодит хөрөнгө оруулалт хийх үүргээс чөлөөлөгдөж байна. Дүгнэлтийн Хөрөнгө оруулалтын тухай гэсэн 10.6 дахь хэсгийг харна уу

Төслөөс олох ЭТТ-ийн орлого бага байна гэж үзэж байна. Өнөөдөр зах зээл хамгийн муу байгаа үед ч ЭТТ нь түүхий нүүрсний 5.8 сая тонны борлуулалт хийж, 400 тэрбум төгрөгийн орлого олж, 28 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны ашигтай ажиллаж байна. Хамтын ажиллагааны гэрээгээр ЭТТ компанийн олох орлогыг хамгийн дээд хэмжээгээр нь тооцож үзэхэд жилд 30 сая ам.доллар байгаа нь ЭТТ компанийн банк болон бусад олборлогч нарын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүрч байна.

10.4 Тавантолгой төслийн эдийн засгийн үр ашгийг харьцуулалт

Ажлын хэсгээс зарим мэдээллийг ашиглан Тавантолгой төслийн эдийн засгийн үр ашгийн харьцуулалтыг 3 хувилбараар гаргасан болно. Энэ нь таамаглал тооцоо болно.

Энэхүү дүн шинжилгээг боловсруулахдаа суурь өгөгдлүүдийг GLOGEX компанийн бэлтгэн ЭТТ-д хүлээлгэн өгсөн урьдчилсан ТЭЗҮ болон "Mongolian Mining Corporation" ("MMC") компанийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланд үндэслэв.

Суурь өгөгдлүүд:

- GLOGEX-ийн урьдчилсан ТЭЗҮ-ийн дагуу Консорциум нь Баруун Цанхи, Зүүн Цанхи ба Ухаа Худагийн талбайгаас төслийн 30 жилийн хугацаанд нийт 882.8 сая тонн нүүрс олборлож, баяжуулан, 614.2 сая тонн нүүрс борлуулахаар тооцоолжээ.
- Ухаа Худагийн талбайгаас олборлох болон борлуулах нүүрсний тоо хэмжээг MMC-ийн 2014 оны санхүүгийн жилийн гүйцэтгэлтэй тэнцүү байхаар тооцов.
- Хатуу коксжих (HCC), хагас зөөлөн коксжих (SSCC), эрчим хүчний нүүрс (Thermal) болон завсрын бүтээгдэхүүн (Middlings) үнийг GLOGEX-ийн урьдчилсан ТЭЗҮ-д тусгасан үнэд тус тус суурилав.
- Мөн борлуулсан барааны өртөг болон ерөнхий ба удирдлагын зардлыг GLOGEX-ийн тооцооллын дагуу авсан болно.

Төслийн санхүүгийн гол үзүүлэлтүүд:

- Төслийн хөрөнгийн жигнэсэн дундаж өртгийг (WACC) 14.1% байхаар тооцоход төслийн NPV буюу өнөөгийн цэвэр үнэ цэнэ нь 47 сая ам.доллар, IRR буюу хөрөнгө оруулалтын өгөөж нь 14.7% байна.
- Хөрөнгийн жигнэсэн дундаж өртгийг тооцохдоо өөрийн хөрөнгийн өртөг 25%, зээлийн өртөг 6.8%, өөрийн хөрөнгө ба зээлийн харьцаа 40:60 гэж авч үзсэн.
- GLOGEX-ийн урьдчилсан ТЭЗҮ-гээр Консорциум нийт 4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийнэ гэж тооцоноос 1 тэрбум ам.доллар нь MMC-ийн охин компани "Энержи Ресурс" ХХК-ийн Ухаа Худаг ордод оруулсан хөрөнгө оруулалт байна. Үлдсэн 3 тэрбум ам.доллар нь бодит мөнгөн хөрөнгө оруулалт гэж тооцжээ.

Хорогдуулах хувь	Төслийн өнөөгийн цэвэр үнэ (NPV) (сая ам.доллар)
10.0%	467
12.5%	183
15.0%	(22)
17.5%	(170)
20.0%	(278)

Нэг. "MMC болон Шенхуа" хамтарсан Консорциум Тавантолгойн төслийг хамтран 100% эзэмших хувилбар

- Консорциум Тавантолгойн төслийг хэрэгжүүлснээр 30 жилийн хугацаанд нийт 15.6 тэрбум ам.долларын мөнгөн урсгал бий болгоно.
- Үүнээс 5.4 тэрбум ам.долларыг Монгол Улсын Засгийн газарт АМНАТ, ААНОАТ, гаалийн хураамж, ногдол ашгийн татвар зэрэг байдлаар төлнө.
- Консорциумын гишүүд болох MMC болон Шенхуа нь 10.1 тэрбум ам.долларыг ногдол ашиг, хуримтлагдсан мөнгөн хөрөнгө, охин компаниудын туслан гүйцэтгэх ажлын ашиг зэрэг хэлбэрээр хүртэх тооцоотой байна.
- Төслөөс нэг хүнд ногдох мөнгөн дүн 1,817 ам.доллар байна.

Хоёр. Төрийн өмчит Эрдэнэс Тавантолгой ХК нь Тавантолгойн ордыг ашиглах Төслийн компанийн 51% -ийг эзэмших, Гадаад, дотоодын хөрөнгө оруулагч 49%-ыг эзэмших хувилбар

- ЭТТ Төслийн компанийн 51%-ийг, гадаад, дотоодын хөрөнгө оруулагч 49%-ийг эзэмшсэн тохиолдолд төслийн хүрээнд 30 жилийн хугацаанд нийт 13.5 тэрбум ам.долларын мөнгөн урсгал бий болгоно.
- Үүнээс 9.6 тэрбум ам.долларыг Монгол Улсын Засгийн газарт АМНАТ, ААНОАТ, гаалийн хураамж, ногдол ашгийн татвар зэрэг байдлаар төлнө.
- Төслийн компанийн 49 хувийг эзэмшигч хөрөнгө оруулагч 3.9 тэрбум ам.долларыг ногдол ашиг, хуримтлагдсан мөнгөн хөрөнгө зэрэг хэлбэрээр хүртэх тооцоотой байна.
- Төслөөс нэг хүнд ногдох мөнгөн дүн 3,186 ам.доллар байна.

Гурав. Төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" ХК 100% буюу одоо байгаа хэлбэрээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах хувилбар

- ЭТТ төслийг бие даан хэрэгжүүлсэн тохиолдолд төслийн 30 жилийн хугацаанд нийт 13.2 тэрбум ам.долларын мөнгөн урсгал бий болгоно.
- Төслөөс нэг хүнд ногдох мөнгөн дүн 4,396 ам.доллар байна.

Дээрх тооцооллын задаргааг доорхи Хүснэгтээс харна уу. (Нийт санхүүгийн загварчлалыг хавсаргав)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ НОГДОХ АШИГ	Хөрөнгө оруулалтын гэрээний шалт	Татварын хэлбэр	Саяан доллароор		
			Төсөл	ЭЗР	100%
Самтгай ажиллагааны төлбөр ¹⁾	3.1		\$2,457	\$2,457	\$1,728
Цэцгийн талбайг уул уурхайн үйл ажиллагаагаас авуулах төлбөр	3.1.6		731	731	0
ЭЗТ-д нэгдүүлэн татварын төлбөр (Цэцгийн рохиты ба газрын бондрлын төлбөр)	3.1.8		1,728	1,728	1,728
Урьдчилгаа төлбөр	3.2.4		0	0	0
Эсгийг таварт бүцээн тэвч төлбөр	3.5		0	0	0
Уул уурхайн үйл ажиллагаанаас болон түүнтэй холбоотой үүсэх татвар	3.6		2,045	2,045	2,045
Орлогын албан татвар	8.2.1	0.0%	469	469	469
Газрын албан татвар	8.2.3.1	10.0%	0	0	0
Иммульдагчиртгойн албан татвар	8.2.6	0.0%	411	411	411
Ухаа худгийн рохиты (ашиг зөвлөх мөхөн үнэх ашигласны төлбөр)	8.2.8.1	10.0%	0	0	0
Нэгдсэн ашгийн орлогын татвар	8.2.8.2	10.0%	0	0	0
Ухаа худгийн албан бондрлын төлбөр ²⁾	8.2.8.2	10.0%	79	79	79
Нийт мөнгөн урсгал			\$6,462	\$9,349	\$13,187
Нийт мөнгөн урсгалын хувь			25%	77%	100%
Ивч үүнд ногдож мөнгөн дүн (ам доллар)			\$1,817	\$3,185	\$4,396
Нийт мөнгөн урсгалын хувь			12%	24%	33%
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД НОГДОХ АШИГ			\$1,548	\$1,548	\$1
Хөрөнгө оруулагчдад ногдож ашиг			100%	100%	100%
ММС			0%	0%	0%
Ашиггүй			2,828	2,828	0
Туслах үйлдвэртэй ашиг (ММС-ийн хяналтын) - борлуулсан барилгын өртний 10%-иар туслах	8.5.4		498	2,717	2,717
30 жилийн дараа мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн эдийн үүрдэл			2,657	1,230	0
НИЙТ ТАТВАРЫН ДАГААХ МӨНГӨН УРСГАЛ			\$10,188	\$13,948	\$6
Нийт мөнгөн урсгалын хувь			65%	29%	0%
НИЙТ МӨНГӨН УРСГАЛ (ЗАСГИЙН ГАЗАР + ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ)			\$16,657	\$13,606	\$13,187
			100%	100%	100%

1) Төсөлийн үйл ажиллагааг ЭЗР-ийн 8.2.8.2-ийн хяналтын хэсэгт оруулах болно.
 2) Зөвхөн уул уурхайн газрын албан татвар, газрын албан татвар, уул уурхайн үйл ажиллагааны төлбөр - Татаарын төлбөр.
 Уул уурхайн үйл ажиллагааны төлбөр - 8.2.1, ММС.
 Татаарын төлбөр - 8.2.1, 8.2.3, 8.2.6.
 3) Албан бондрлын төлбөрийг тухайн үйл ажиллагааны үйлдвэрлэлтэй холбоотой.

10.5 Мөнгөн хөрөнгө, орлогын тухай

2015 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн Хөрөнгө оруулалтын Гэрээний 3.7 (с)-ийн (ii), (iii), (iv) болон 6.1 (f) заалтуудаар ЭР нь мөнгөн хөрөнгөө Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна эзэмших, бүтээгдэхүүний борлуулалтаас олсон бүх орлогоо гадаад улсад байршуулах, Монгол улсын нутаг дэвсгэрт хүлээн авсан бүх орлогоо гадаадад саадгүй гаргах, бусад төлбөрийг гадаадад хийх эрхтэй гэсэн заалтуудыг 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан Гэрээний шинэчилсэн хувилбарт дараах хэлбэрээр өөрчлөн найруулсан байна.

- Хөрөнгө оруулалтын Гэрээний 3.7 (с)-ийн (ii) заалт "Мөнгөн хөрөнгөө Монгол улсад болон Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна эзэмших, татварын үүргээ биелүүлсний дараа чөлөөтэй захиран зарцуулах"
- Хөрөнгө оруулалтын Гэрээний 3.7 (с)-ийн (iii) заалт "Бүтээгдэхүүний экспорт, борлуулалт, арилжаанаас Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна олсон орлогоо (ногдол ашиг хуваарилах зэрэг хэлбэрээр) Монгол улс болон гадаад улсад байршуулах, чөлөөтэй захиран зарцуулах"
- Хөрөнгө оруулалтын Гэрээний 3.7 (с)-ийн (iv) заалт "Бүтээгдэхүүн борлуулалт, арилжаа, экспортоос Монгол улсын нутаг дэвсгэрт олсон орлогоо Монгол улс болон гадаад улсад байршуулах, чөлөөтэй захиран зарцуулах, бусад төлбөрийг гадаад улсад хийх"

Хэдийгээр гэрээний заалтанд "Монгол Улс" гэж нэмсэн ч ЭР олсон бүх орлогоо гадаад улсад байршуулах эрх нээлттэй хэвээр хадгалагдаж байна. Гол зарчим өөрчлөгдөөгүй. Монгол улс болон гадаад улсад гэж аль ч хувилбарыг ашиглах боломжтой байхаар заажээ. Иймд энэ заалтын дагуу тул ЭР-н Тавантолгойн ордны ашиглалтаас олж байгаа бүх орлогоо эсвэл орлогын 1 хувийг Монгол улсад үлдээж, 99 хувийг нь гадаадад байршуулсан байхад гэрээ зөрчигдөхгүй.

Хөрөнгө оруулалтын гэрээний дээрхи заалтууд нь Монгол улсын валютын нөөцийг нэмэгдүүлэхэд болон төгрөгийн ханшийг тогтворжуулахад нөлөө үзүүлнэ гэдэг нь эргэлзээтэй байна.

10.6 Хөрөнгө оруулалтын тухай

Хөрөнгө оруулалтын Гэрээний 2.8 (а)-д зааснаар Төсөлд оруулах Хөрөнгө оруулалтыг ойролцоогоор 4 тэрбум гэсэн бөгөөд энэ хөрөнгө оруулалтанд одоо ЭР-ийн Ухаа худгийн уурхайд оруулсан байгаа хөрөнгө оруулалтыг багтааж тооцохоор заажээ.

ЭР-ийн Ухаа худаг ордод оруулсан хөрөнгө оруулалтыг 1 тэрбум долларт тооцож байна. Энэ тухай М. Энхсайхан сайдын Ардчилсан намын бүлгийн асуулгад хариу өгсөн 2015 оны 1 сарын 26-ны өдрийн ЗГ-3/ 54 албан тоотод "... консорциумаас тус төсөлд нийт 4 тэрбум ам. долларын хийх саналыг ирүүлсэн бөгөөд 1 тэрбум ам. доллар нь "Энержи Ресурс" ХХК-ийн Ухаа худаг аж үйлдвэрийн цогцолборт оруулсан бодит хөрөнгө оруулалт байх ба нэмж 3 хүртэл тэрбум америк долларын хөрөнгө оруулалт оруулна" гэж тодорхой бичсэн байна.

Хөрөнгө оруулалтын гэрээний 2.8 (а)-д зааснаар хөрөнгө оруулалт нь 8 үндсэн хэсгээс бүрдэж байна. Үүнд,

1. Төмөр замын төсөл
2. Уул уурхайн тоног төхөөрөмж
3. Хөрс хуулалт
4. Нүүрс баяжуулах үйлдвэр
5. Усан хангамжийн байгууламж
6. Эрчим хүчний хангамж
7. Туслах байгууламжууд болон дэд бүтцийн барилга угсралт
8. Бусад

М. Энхсайхан сайдын мэдэгдэж байгаагаас харахад хөрөнгө оруулалтын эдгээр үндсэн хэсгүүдийн уул уурхайн тоног төхөөрөмж, нүүрс баяжуулах үйлдвэр, усан хангамжийн байгууламж, эрчим хүчний байгууламж зэрэг нь ЭР-ийн одоо Ухаа худгийн орд дээр ашиглаж байгаа хөрөнгө болно.

Гэвч ЭР-ийн Ухаа худаг уурхайд оруулсан хөрөнгө оруулалт хэд болох, үнэлгээг хэрхэн тооцох, аргачлал, томъёололтой холбоотой заалт байхгүй байна. ЭР-ийг эзэмшдэг толгой компани ММС нь 2014 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар нийт 1 тэрбум 285 сая ам. долларын богино болон урт

хугацааны өртэй гэдгийг MMC-ийн 2014 оны жилийн эцсийн тайланд (хуудас 14 болон notes 23, 25, 26) тусгасан байна.

Тус компани нийт US\$1,285,987,000 өр нь богино хугацааны US\$413,012,000 өр болон урт хугацааны US\$872,975,000 өр зэргээс бүрдэж байна. (Эх үүсвэр: MMC компанийн 2014 жилийн эцсийн тайлан, хуудас 14)

Урт хугацааны өрийн 1 жилийн дотор төлөгдөх \$114,818,000; 1-2 жилийн дотор \$166,818,000 төлөх ёстой (Эх үүсвэр: MMC компанийн 2014 жилийн эцсийн тайлан, хуудас 169). Богино хугацааны худалдааны өр, төлбөр \$298,118,000 байна. Эдгээр төлбөрийг нэхэмжлэх явуулсан өдөртөө эсвэл 2 сарын дотор төлөх шаардлагатай төлбөрүүд байна. (Эх үүсвэр: MMC компанийн 2014 жилийн эцсийн тайлан, хуудас 170).

Мөн цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болсон тухай "KPMG" аудитын компани "MMC"-ийн 2014 оны хагас жилийн тайланд заасан байна (хуудас 59). "MMC"-ийн өөрийн хөрөнгө 2014 оны жилийн эцсээр 396.5 сая ам.доллар байсан бөгөөд өмнөх жилийн \$560.9 сая ам.доллартай харьцуулахад 29.3% буурсан байна (хуудас 14).

"MMC" нь 2015 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн байдлаар 1 тэрбум 170 сая ам. долларын өртэй байна.

MMC нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт орших Баруун нарангийн нүүрсний уурхайг өндөр үнээр худалдаж авсан нь алдагдал болж өр үүсэхэд нөлөөлжээ. Энэ ордыг "Kerry Mining" (Mongolia) компани 2008 онд 259 сая доллараар худалдаж аваад, 2011 онд MMC компанид 464 сая доллараар худалдсан байна. Гэтэл энэ ордын үнэлгээ 2014 оны байдлаар 190 сая болж буурчээ. (Энэ худалдан авалтын тухай тайлбарыг 10.9-д тодорхой тайлбарласан болно)

Мөн хөрөнгө оруулалт болгож байгаа уул уурхайн тоног төхөөрөмж, нүүрс баяжуулах үйлдвэр, усан хангамжийн байгууламж, эрчим хүчний байгууламж зэрэг нь нэр бүхий олон улсын банкны 570 сая ам.долларын барьцаанд байна. Энэ өр болон барьцаа нь хөрөнгө оруулалтанд яаж нөлөөлөхийг зайлшгүй тооцож гэрээнд тусгах ёстой. (Эх сурвалж http://upload.mmc.mn/financial_report/ KPMG компанийн аудитын дүгнэлт, 59 дүгээр хуудас)

Хөрөнгө оруулагчийн оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ нь Хөрөнгө оруулалтын гэрээний үндсэн шалгуур болох ёстой. Хөрөнгө оруулалтын хэмжээ ойролцоогоор заагдсан, хэзээ, яаж хийгдэх нь дан ганц Хөрөнгө оруулагчийн үзэмжээс хамаарах боломжтой байхаар Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгасан байна.

Хөрөнгө оруулалтын гэрээний 2.8 (а)-д "...ойролцоогоор 4 тэрбум" гэсэн болон М. Энхсайхан сайдын албан тоотод "нэмж 3 хүртэл тэрбум америк долларын хөрөнгө оруулалт оруулна" гэснээс харахад яг 4 тэрбум долларын хөрөнгө оруулалт хийнэ гэсэн үүрэг ЭР хүлээгээгүй байна.

ЭР-ийн хөрөнгө оруулагч болох ЭРК болон Шенхуа нь яг хэдэн тэрбум долларын хөрөнгө оруулалтыг ямар хугацаанд хийх тухай үүрэг хүлээсэн тодорхой тоо, хугацаа заасан тохиролцоо гэрээнд байхгүй байна.

Хөрөнгө оруулалтын Гэрээний 2.8 (b), 4.3 (a), (c) болон 5.1 (b), (c)-д зааснаар хөрөнгө оруулалтын энэ дүн нь тооцоолсон дүн ба тухай бүр өөрчлөлт оруулсан ТЭЗҮ-ээр нарийвчилж тодорхой болох бөгөөд зах зээлийн нөхцөл хөрөнгө оруулалтын явцаас хамаарч өөрчлөгдөж болно, Санхүүжилтийн гэрээнд болон ТЭЗҮ-д үндэслэн хөрөнгө оруулалт хийх хуваарийг ЭР тодорхойлно, үйл ажиллагааны шаардлага, тухайн зах зээлийн нөхцлийг харгалзан, санхүүжилтийн гэрээгээр зөвшөөрөгдсөн хүрээнд хөрөнгө оруулалтын хуваарьт нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй, Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс 12 сарын хугацаанд ЭТТ-н боловсруулсан одоогийн ТЭЗҮ шинээр боловсруулна, Цанхийн талбайн нэмэлт хайгуулын ажил болон төслийн бусад ажлаас шалтгаалан ТЭЗҮ-д тухай бүр нэмэлт, өөрчлөлт орж болно гэжээ.

Хөрөнгө оруулалтын Гэрээний 4.2 (b), 4.3 (a), (c)-д зааснаар төсөл хэрэгжүүлэх үе шат, Хөрөнгө оруулалт хийх хуваарийг ЭР өөрөө тогтоох бөгөөд санхүүжилтийн хуваарьт нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй гэж заажээ. Эдгээр заалтын дагуу гэрээний ЭР хэзээ, ямар хөрөнгө оруулалт хийхээ өөрийн үзэмжээр шийдвэрлэх эрхтэй бөгөөд тухайн өөрчлөлтийн талаар Засгийн газарт зөвхөн бичгээр мэдэгдэх л үүрэгтэй.

Мөн хөрөнгө оруулалтын Гэрээний 2.8 (а)-ийн (iii) заалтаар хөрөнгө оруулалтанд хөрс хуулалтыг оруулсан байна. Хөрс хуулалт нь хөрөнгө оруулалт биш, олборлолтын үйл ажиллагааны зардал юм. Үйл ажиллагааны ийм зардлыг хөрөнгө оруулалтандаа тооцвол ЭР нь маш хурдан хугацаанд хөрөнгө оруулалтаа гүйцэтгэсэн тайлан гаргахаар байна. Өөрөөр хэлбэл, зардалд тооцох үйл ажиллагаагаа хөрөнгө оруулалтанд оруулж бодит хөрөнгө оруулалт хийх үүргээс чөлөөлөгдөж байна.

Эсвэл асар их хэмжээний хайгуулийн ажлын зардал тооцож, түүнийг нөхөх нэрээр Гэрээний хугацааг сунгах эрх үүсгэх болно. Учир нь Хөрөнгө оруулалтын гэрээний 2.2 (а) заалтаар ЭР нь Цанхийн талбайн нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр нэмэлт хайгуулын ажил хийнэ, мөн 4.1 (f)-д зааснаар "ЭР хайгуулийн үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалтаа бүрэн нөхөх хүртэл хугацаагаар энэхүү гэрээний хугацааг сунгах асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ" гэжээ. (2015 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн хувилбарт энэ заалт нь хайгуулийн үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалтаа бүрэн нөхөх хүртэл хугацаагаар энэ гэрээг сунгах эрхийг ЭР эдлэх үндэслэл болно гэж байсныг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ гэж уян хатан болгож өөрчилсөн байна)

Гэрээний энэ заалт нь Хөрөнгө оруулалтын гэрээний 2.2 (d)-д заасан нэмэлт хайгуулийн ажилд зарцуулсан ЭР-н зардлыг энэхүү Гэрээний 9.2 (l)-д заасны дагуу ЭР-н татвар ногдох орлогоос хасч тооцно гэж заасантай зөрчилдөж байна.

Хөрөнгө оруулалтын Гэрээний 2.2 (d) заалтаар ЭР нь хайгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлаа татвар ногдох орлогоос хасч тооцоод алдагдалгүй болж байна. Иймээс хайгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалтыг бүрэн нөхөх хүртэл хугацаагаар Гэрээний хугацааг сунгах тухай асуудал Талуудын хооронд үүсэхгүй.

Хөрөнгө оруулалтын Гэрээний заалтуудаас харахад ЭР нь 4 тэрбум долларын хөрөнгө оруулалтаа яаж ч тооцож болох, ямар хугацаанд энэ хөрөнгө оруулалтыг оруулах нь тодорхойгүй болж байна. Тус компани амалж байгаа 4 орчим ам.тэрбум долларын хөрөнгө оруулалтаа гэрээний гэрээний 30 жил, сунгалтын 30 жилийн хугацаанд нийт 60 жилийн хугацааны турш үргэжлүүлэн цувуулж хийх, эсвэл Тавантолгойн ордыг ашиглаж олсон орлогоосоо хөрөнгө оруулалт болгон буцааж хийх, эсвэл хөрс хуулалт гэх зэрэг өндөр зардалтай үйл ажиллагааны зардлыг өсгөн тооцох зэргээр хөрөнгө оруулалтыг өөрийн үзэмжээрээ хийхээр зохицуулжээ.

Засгийн газар хөрөнгө оруулалттай холбоотой шаардлага гаргах эрх энэ гэрээнд байхгүй.

Хөрөнгө оруулалтын Гэрээний 8.1 (а)-д зааснаар ЭР нь Тавантолгойн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэрийг хувьцаа гаргах, зээлийн санхүүжилт гэсэн хоёр хэлбэрийн аль тохиромжтой хэлбэрийг ашиглана гэжээ.

Санхүүжилт авах зорилгоор ЭР нь энэхүү Гэрээний дагуу эдлэх эрх болон үр шим, Цанхийн талбайгаас олборлосон, боловсруулсан бүтээгдэхүүн, нүүрс боловсруулах үйлдвэр, ус, эрчим хүч хангамжийн дэд бүтэц, бусад байгууламж, барилгын ажил, Төслийн бусад эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, ашиг сонирхлын хувьд барьцааны сонирхол үүсгэх эрхтэй гэсэн байна. (Хөрөнгө оруулалтын гэрээний 8.3 (b) заалт)

Энэ заалтаас харахад ЭР нь Тавантолгойн ордыг ашиглах эрхийн дагуу олж авч байгаа эрх, ашиг сонирхолыг барьцаалж байж л хөрөнгө оруулалт босгох боломжтой болж байна. Энэ нь тус компанийн давуу тал биш бөгөөд Тавантолгойн ордыг ашиглах эрх авснаар үүсч байгаа боломж юм. Хэрэв Засгийн газар энэ боломжийг ЭТТ-д зөвшөөрсөн тохиолдолд ЭТТ өөрөө хөрөнгө оруулалт татах бүрэн боломжтой.

10.7 Урьдчилгаа төлбөрийн тухай

Хөрөнгө оруулалтын Гэрээний 3.3 дахь заалтаар ЭР нь ирээдүйд төлөх татвар болон хамтын ажиллагааны төлбөрөөс суутган тооцох нөхцөлтэй, 200 сая долларын урьдчилгааг жилийн 4,5 хувийн хүүтэйгээр ЭТТ-д өгч байна. Өөрөөр хэлбэл, урьдчилгаа 200 сая доллар нь урьдчилан төлж байгаа төлбөр биш, буцааж төлөх нөхцөлтэй хүүтэй, зээл байна.

Энэ төлбөрийг суутган тооцож дуусах хүртэл тодорхой хугацаанд (нүүрсний олборлолт, борлуулалтаас шалтгаалан 3-4 жил орчим) ЭР нь ЭТТ-д хамтын ажиллагааны төлбөр болон Монгол Улсад татвар төлөхгүй.

10.8 "MMC" (Mongolian Mining Corporation буюу Монголын Уул уурхайн корпораци) компанийн санхүүгийн товч дүн шинжилгээ

Кайман арал улсад бүртгэлтэй MMC нь "Энержи Ресурс" компанийн толгой компани болно. Энэ тухай Монгол улсын сайд М. Энхсайхан Улсын Их Хурлын гишүүдийн асуулгад дараах хариултыг өгсөн байна.

М. Энхсайхан сайд 2015 оны 2 дугаар сарын 24-ны өдрийн ЗГ-3/81 дугаар албан тоотын хавралтын 3.1-д "Энержи Ресурс ХХК нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг ба тус компанийн толгой компани болох Монголын Уул уурхайн корпорацийн хувьцаа Хонконгийн хөрөнгийн биржид 975 дугаараар бүртгэлтэй, нийт хувьцааны 60 орчим хувийг Монгол улсын иргэд, аж ахуйн нэгж өмчилдөг корпораци юм" мөн хавсралтын 4.5-д "Төслийн үйл ажиллагаанд Монголын Уул уурхайн корпораци нь өөрийн охин компани болох Энержи Ресурс ХХК-иар дамжуулан оролцоно" гэжээ.

Иймд охин компаниараа дамжуулан Тавантолгойн уралдаант шалгаруулалтанд оролцож байгаа MMC компанийн санхүүгийн байдлыг олон улсын эх сурвалжаас авч үзлээ.

Энэхүү санхүүгийн шинжилгээг Хонгконгийн бирж дээр 975 кодоор арилждаг "Mongolia Mining Corporation" ("MMC") компанид олон улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээний агентлагууд болох Standard & Poor's ("S&P"), Moody's компаниудын гаргасан дүн шинжилгээнд болон "MMC" компанийн сүүлийн 3 жилийн санхүүгийн байдалд олон улсын аудитын нэр хүнд бүхий "KPMG" компанийн хийсэн аудитласан санхүүгийн тайланд үндэслэв. Үүнд:

10.8.1 "Standard & Poor's": 2014 оны 10 сарын 31-ний дүн шинжилгээ⁷

- "MMC" компани 2014 оны 12 дугаар сард 200 сая ам.долларын нэмэлт хувьцаа арилжаанд гаргаж, уг хувьцааны арилжаа нь 2014 оны 12 сард хийгдсэн байна. Энэ мөнгөний 162 сая ам.доллар нь 2015 оны туршид "MMC" компани зээлийн төлбөр төлөхөд хангалттай гэж S&P үзсэн байна. 2015 оны үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний (Free Operating Cash Flow) хэрэгцээг дээрх хувьцааны арилжааны үлдэгдэл 40 сая орчим ам.доллар болон 2014 оны 9 сарын 30-ны байдлаар дансны үлдэгдэл болох 60-70 сая ам.доллараар нөхөхөөр тооцоолж байна.
- Хэрэв "MMC" компани нь дээрх хувьцааны арилжаанаас болгосон 200 сая ам.долларыг хэрхэн зарцуулж буй нь тодорхойгүй байна. Хэрэв ихээхэн хэсгийг Тавантолгойн тендерт оролцох зэрэгт зарцуулж, зээл төлөлтийг зөвхөн үйл ажиллагааны орлогоос төлөх тохиолдолд "MMC"-ийн зээлжих зэрэглэлийг S&P бууруулах магадлалтай юм.
- Нүүрсний үнэ цаашид унах, цаашид олборлолтын өртөг (Deferred Stripping Cost) өсч байгаа нь "MMC" компанийн санхүүгийн байдалд хүндрэл учруулж байна.

⁷www.standardandpoors.com/ratingsdirect

- S&P нь 2014 оны 10 дугаар дугаар сард "MMC"-ийн санхүүгийн байдлыг CCC+ гэж үнэлсэн байна. (зээлжих зэрэглэлийн тайлбар хүснэгтийг хавсаргав). Учир нь "MMC"-ийн санхүүгийн бүтэц (Capital Structure) нь урт хугацаанд тогтворгүй гэж S&P дүгнэж байна. Хэдий MMC дээрх 200 сая ам.долларыг бүхэлд нь зээл төлөлтөд зарцуулсан ч 2015 онд "MMC"-ийн зээл ба үйл ажиллагааны ашгийн харьцаа (Debt-to-EBITDA Ratio) 5.0-с дээш байх төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл MMC компани үйл ажиллагааны ашгаар зээлээ төлж барагдуулах боломжгүй. Олон улсад уг харьцаа 4.0 эсвэл 5.0-аас дээш байхад зээлээ төлөх чадваргүй, өндөр эрсдэлтэй гэж үздэг.
- Коксжих нүүрсний үнэ унаж, зах зээлийн нийлүүлэлт нь эрэлтээ давсан одоогийн нөхцөл байдал нь ойрын ирээдүйд сайжрах төлөвгүй байна. Иймд "MMC"-ийн санхүүгийн нөхцөл байдал сайжрах магадлал маш бага гэж S&P үзэж байна. Үүний сацуу, "MMC" компани зардал танах замаар ашгаанэмэгдүүлэх боломж багатай.

Эдгээр нөхцөл байдлыг дүгнэж үзээд "MMC" компани төлбөрийн чадавхгүй болох маш өндөр эрсдэлтэй гэж S&P дүгнэсэн байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (Liquidity)

- "MMC" компанийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг S&P "муу" гэж үнэлсэн.
- "MMC" нь өөрийн хувьцаа эзэмшигч Хонг Конгийн "Kerry Group"-ийн 105 сая ам.долларын өрийн бичиг (Promissory Note)-ийн төлбөрийг 2015 онд хийх ёстой. Гэхдээ сүүлийн 12 сарын турш "Kerry Group" нь MMC компанийн өрийн бичгийн төлбөрийн хугацааг хэд хэдэн удаа хойшлуулсан (MMC-ийн 2014 хагас жилийн тайлангийн хуудас 78, 20.(iv) зүйлд заасан). Хувьцаа эзэмшигч, мөн хамтран ажилладаг түнш болох учир "Kerry Group" төлбөрийн хугацааг дахин хойшлуулж "MMC" компанид дэмжлэг үзүүлэх боломжтой гэж S&P үзэж байна. "Kerry Group"-ийн өрийн бичгээс гадна ирэх 12 сард "MMC" компанийн төлбөр ёстой нийт зээлийн төлбөр нь 162 сая ам.доллар байна.
- Үндсэн хөрөнгө авахад зарцуулсан зардал болон хойшлуулсан олборлолтын зардал зэргийг тооцоолоход үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (Free Operating Cash Flow) нь хасах 70-80 сая ам.доллар байна.

10.8.2 Moody's: 2015 оны 3 сарын 25-ны дүн шинжилгээ⁸

Moody's-ийн дүгнэлтээр 2014 онд "MMC"-ийн зээлжих чадвар (Саа2-) болж буурсан нь коксжих нүүрсний үнэ унасан, зээлийн дарамт, үйл ажиллагааны зардал өссөн зэргээс үүдэлтэй бөгөөд энэ нөхцөл байдалнь 2015 онд үргэлжлэх төлөвтэй гэсэн байна.

2014 онд хатуу коксжих нүүрсний борлуулалтын дундаж үнэ унаснаар MMC-ийн үйлдвэрлэлийн хэмжээ багассан тул "MMC"-ийн орлого болон борлуулалт буурахад нөлөөлжээ. "MMC"-ийн зардал дараах шалтгаанаас өссөн байна. Үүнд:

1. Тээврийн зардал нь өссөн

2. Сул зогсолтын зардал өссөн
3. Үйлдвэрлэлийн хэмжээ багассан тул нэгжид ногдох тогтмол зардал өссөн

2014 онд "MMC"-ийн борлуулалтын орлого 25%-иар буурч 328 сая ам.долларт хүрсэн. Мөн хатуу коксжих нүүрсний борлуулалтын дундаж үнэ нь 9%-иар унасан.

"MMC"-ийн үйл ажиллагааны алдагдал (EBITDA Loss) нь 46 сая ам.долларт хүрсэн. 2013 онд татварын өмнөх ашиг (EBIT) 6%-иар өссөн бол 2014 онд 29%-иар огцом буурсан байв. "MMC"-ийн бэлэн мөнгөний үлдэгдэл 2013 онд 77 сая ам.доллар байсан бол 2014 онд 253 сая ам.доллар болж өссөн.

Гэвч ирэх 12 сард бэлэн мөнгөний үлдэгдэл нь дараах шалтгаанаар дуусна гэж Moody's үзэж байна:

1. Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (Free Operating Cash Flow) нь 35-45 сая ам. долларын алдагдалтай гарах төлөвтэй
2. Засвар үйлчилгээний зардал 5-10 сая ам. доллар
3. Богино хугацааны зээлийн төлбөр 115 сая ам.доллар
4. Хүүгийн төлбөр 70-80 сая ам.доллар

2015 онд "MMC" компанид 190-205 сая ам.долларын төлбөрүүд хүлээгдэж байна.

Борлуулалтын орлого бага, бэлэн мөнгөний зарцуулалт өндөр байгаа тул 2015 оны эцэст MMC-ийн бэлэн мөнгө дуусах магадлал өндөр байна.

Олон улсын хөрөнгийн зах зээл дээр арилжаалагдаж буй хувьцаа, бондын үнэ нь аливаа компанийн санхүүгийн нөхцөл байдлыг илтгэдэг. MMC компанийн хувьцааны ханш 2011 оноос хойш тогтмол унасан нь коксжих нүүрсний зах зээлээс шалтгаалсан хэдий ч компанийн дотоод санхүүгийн удирдлага тодорхой хэмжээнд нөлөөлсөн байж болзошгүй байна.

www.moody's.com/research

График 1. "MMC" компанийн хувьцааны арилжаа 2011 оноос хойш⁹



"MMC"-ийн нийт өрийн хэмжээ 2014 оны эцсийн байдлаар 1.02 тэрбум ам.доллар байна. Үүнд:

- 320 сая ам.доллар нь богино хугацааны зээл
- Монголын Худалдаа хөгжлийн банкны 40 сая ам.долларын зээл болон бусад
- 298 сая ам.долларын худалдааны өр, төлбөр
- 700 сая ам.доллар нь урт хугацааны зээл. Үүнд:
 - 600 сая ам.долларын Сингапурын хөрөнгийн бирж дээр арилжаалдаг 2017 онд төлөгдөх 8.875% хүүтэй, хагас жилийн төлбөртэй бонд,
 - EBRD, BNP Paribas банкуудын 103 сая ам.долларын зээл.

Уг бондын барьцаанд "MMC"-гийн охин компаниуд болох "Mongolian Coal Corporation Limited" (HK), "Mongolian Coal Corporation" S.a.r.l (Luxemburg) зэрэг компанийн хувьцааг барьцаалсан байна. Мөн энэ зээлэнд тус компанийн Монгол улс дахь охин компаниуд болох "Energy Resources Corporation" LLC, "Energy Resources" LLC, "Energy Resources Mining" LLC, "Transgobi" LLC зэргийн санхүүгийн баталгаа гаргасан байна.

"MMC"-ийн бонд сүүлийн 1 жилд 55-79 ам.долларын үнэтэй, зах зээлийн хүү нь 20-32% хооронд арилжаалагдаж байна. Өөрөөр хэлбэл, хэрэв MMC одоо хөрөнгийн зах зээлээс санхүүжилт босговол жилийн 20%-оос дээш хувийнхүүтэй босгохоор байна. Энэ нь 2012 онд гаргасан 8.875% хүүгээс харьцангуй дээгүүр байгаа нь компанид үүссэн санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг харуулж байна.

⁹www.google.com

График 2-д харуулснаар "MMC"-ийн бондын үнэ 2013 оноос хойш огцом унасан хэдий ч сүүлийн 1 жилийн хугацаанд Тавантолгой ордын тендертэй холбогдох мэдээ гарах бүрт "MMC"-ийн бондын үнэд эерэгээр нөлөөлсөн байна.

График 2. "MMC" компанийн бондын арилжаа 3 жил ба 1 жилээр¹⁰



"MMC"-ийн өөрийн хөрөнгө 2014 оны жилийн эцсээр 396.8 сая ам.доллар хүрч буурсан бол 2013 оны тайлант үед 560.9 сая ам.доллар байжээ.

Нийт зээл ба өөрийн хөрөнгийн харьцаа 2014 оны жилийн эцсийн байдлаар 223.3% хүрсэн бол 2013 онд 159.9% байна.

Олон улсын санхүүгийн практикаар хэт их зээл авсан (Over-Leveraged) компанийг төлбөрийн чадваргүй болох, улмаар дампуурах магадлалтай гэж үздэг. Иймд S&P, Moody's компаниуд нь "MMC"-д доогуур үнэлгээ өгч, урт хугацаанд санхүүгийн байдал нь тогтворгүй гэж дүгнэсэн нь үүнтэй холбоотой байна.

Санхүүгийн хүнд байдалд орсон "MMC" компанийн хувьд "Тавантолгой" ордыг ашиглах эрхийг олж авах нь өрсөлдөгчгүй болж, нөөцөө нэмэгдүүлэх замаар зах зээлийн үнэлгээгээ өсгөж, санхүүгийн хүндрэлээс гарах боломж болж байна.

10.9 "MMC" Компанийн ¹¹Баруун Наран уурхайн худалдан авалтын тухай (MMC компанийн санхүүгийн тайлангаас орчуулав)

2011 оны 5 дугаар сарын 31-нд Компани (MMC) болон Худалдан авагч буюу Компанийн охин компани нь Хувьцаа худалдан авах гэрээг Худалдагч болон Худалдагчийн толгой компанитай хийсэн болохыг Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс мэдэгдэж байна. Хувьцаа худалдан авах гэрээнд заасан Нөөцийн өөрчлөлт болон Роялтийн нөхцлүүдийг харгалзаж Худалдан авагч нь Хувьцааг нийт 464,465,000 ам.доллараар худалдаж авахаар тохирсон бөгөөд

¹⁰www.boerse-berlin.com

¹¹ Mongolian Mining Corporation, QGX Coal Ltd-ийн нийт гаргасан хувьцааны худалдан авалтын арилжааны мэдээлэл http://www.mmc.mn/upload/2011-05-31_e_00975ann-20110531.pdf

нийт үнийн дүнгийн 379,465,000 ам.долларыг Худалдан авагч нь Худалдагч талд бэлнээр төлөх ба 85,000,000 ам.долларыг Компаниас "QGX Holding"-д гаргах хувьцаанд хөрвөх эрх бүхий бондоор төлөхөөр тохирсон.

ХУДАЛДАН АВАЛТЫН ГОЛ НӨХЦЛҮҮД:

Хувьцаа худалдан авах гэрээ

Огноо:

2011 оны 5 дугаар сарын 31 (Арилжааны цаг дууссаны дараа)

Талууд:

- Худалдан авагч тал болох Mongolian Coal Corporation Limited;
- Худалдагч тал болох Quincunx (BVI) Ltd.;
- Худалдагч талын толгой компани болон батлан даагч болох Kerry Mining (Mongolia)
- Худалдан авагч талын толгой компани болон батлан даагч болох Компани

Худалдагч талын 90%-ийг "Kerry Mining" (Mongolia) нь шууд бусаар эзэмшдэг бөгөөд 10%-ийг нь "MCS Minerals" LLC компани эзэмшдэг. "MCS Minerals" LLC-ийн 51%-ийг ноён Жамбалжамцийн Оджаргал (Гүйцэтгэх захирал болон ТУЗ-ын дарга), 49%-ийг "MCS Holding" LLC(Компанийн хяналтын багцын эзэмшигч) тус тус эзэмшдэг. Шаардлагатай судалгааг хийсний үндсэн дээр Худалдагч тал болон түүний эзэмшигчид нь Компанийн захирал, гүйцэтгэх албан тушаалтан, томоохон хувьцаа эзэмшигчид, эсвэл охин компаниуд болон тэдгээрийн түншүүдтэй харилцан хамааралгүй хараат бус гуравдагч этгээд мөн болно гэж Төлөөлөн удирдах зөвлөл үзэж байна.

Худалдан авалтын мэдээлэл:

Хувьцааны худалдаа нь Худалдагдаж буй компанийн гаргасан нийт хувьцааг бүхэлд нь хамаарна. Худалдагдаж буй компани нь борлуулалт хийж эхлээгүй байгаа тул ашиг бүртгэгдээгүй байна. 2010 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар (Худалдагдаж буй компанийн хамгийн сүүлийн аудитлагдсан санхүүгийн тайлан гарсан өдөр), худалдах хувьцааны хөрөнгийн цэвэр үнэлгээ нь \$29,664,827 ам.доллар байсан.

Худалдан авалтын үнийн дүн:

Худалдан авалтын үнийн дүн болох 464,465,000 ам.доллар нь дараах байдлаар төлөгдөнө:

- Худалдан авагч тал нь Худалдагч талд 379,465,000¹² ам.долларыг бэлнээр төлөх
- "QGX Holdings" компанид зориулан 85,000,000 ам.долларын дүнтэй Хөрвөх бонд гаргана.

Төлөх хугацаа:

¹²Худалдан авагч нь Худалдагчид бэлнээр төлөх үнийн дүнгийн зарим хэсгийг 2 сарын хугацаатай өрийн бичгээр төлнө, Mongolian Mining Corporation, QGX Coal Ltd-ийн нийт гаргасан хувьцааны худалдан авалтын гүйлгээний мэдээлэл, хуудас 3.

Худалдан авалтын төлбөрийг 2011 оны 6-р сарын 1-ний өдөр эсвэл түүнээс өмнө төлж дуусна.

БАРУУН НАРАН УУРХАЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Баруун Наран уурхайг эзэмшдэг компани нь 2007 оны 3-р сарын 28-ны өдөр Гибралтар улсад бүртгэгдсэн хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Баруун Наран уурхай нь Монгол Улсын өмнө хэсэгт Өмнөговь аймагт байрладаг ба нийслэл Улаанбаатар хотоос урагш 500 км, аймгийн төвөөс зүүн тийш 60 км-д байршилтай. Баруун Наран болон Ухаа Худаг ордууд хоорондоо 30 км-н зайтай.

"Minarco MineConsult" компанийн хийсэн 2008 оны 3-р сарын 20-ны урьдчилсан Техник Эдийн Засгийн Үндэслэлэл ("ТЭЗҮ")-д тусгасанаар (Канад улсын) Эрдэст бодисын талаарх мэдээллийн "National Instrument 43-101" стандартын дагуу хийсэн хэмжилтэд Баруун Наран уурхай дахь магадлагдсан болон хэмжигдсэн нөөц 253 сая тонн, боломжит нөөц 193 сая тонн гэж заасан.

БАРУУН НАРАН КОКСЖИХ НҮҮРСНИЙ УУРХАЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ¹³

Компанийн эзэмшлийн Баруун Наран коксжих нүүрсний уурхай нь Монгол Улсын Засгийн газрын агентлагуудын төлөөллөөс бүрдсэн Улсын комиссоос үйл ажиллагаа явуулах эрхээ 2012 оны 2 дугаарын 1-ний өдөр хүлээн авсан болохыг "Mongolian Mining Corporation" ("Компани")-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс мэдэгдэхэд таатай байна. Компанийн шууд бус, бүрэн өмчлөлийн охин компани болох "Khangad Exploration" LLC нь 14493A тоот олборлолтын лицензийн албан ёсны эзэмшигч байх ба тухайн лицензийн хүрээнд Компани нь 2008 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн эхний шатанд 30 жилийн хугацаанд Баруун Наран уурхайн 4,482 га орчим лицензийн газар нутаг дээр уул уурхайн үйл ажиллагаа явуулах онцгой эрхийг эдэлнэ.

Компани 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр гэхэд Баруун Нарангийн уурхайгаас 1.0 сая тонн түүхий нүүрс олборлохоор зорьж байна. Олборлосон түүхий нүүрсийг Баруун Наран уурхайгаас Ухаа худаг уурхай руу тээвэрлэн, Ухаа худаг уурхай дээр байрлах Нүүрс боловсруулах үйлдвэрт боловсруулж, БНХАУ-ын нүүрсний хэрэглэгчидээ угааж, боловсруулсан байдлаар борлуулна.

ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ (IMPAIRMENT LOSS)¹⁴

Группийн хэмжээнд 2014 оны 12 сарын 31-ээр дууссан тайлант жилд санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз ("Хөрөнгийн үнэ цэнийн бууралт") учрах төлөвтэй байгаа талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ("ТУЗ") зүгээс Хувьцаа эзэмшигчид болон боломжит хөрөнгө оруулагчидад 2015 оны 3 сарын 22-нд мэдэгдсэн.

¹³ Mongolian Mining Corporation, Баруун Нарангийн коксжих нүүрсний уурхайн үйл ажиллагааг ашиглалтад оруулах тухай, http://www.mmc.mn/upload/2012-02-02_e_00975ann-20120202.pdf

¹⁴ Монголын уул уурхайн корпораци, Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз, http://www.mmc.mn/upload/2015-03-22_e_00975ann-20150322.pdf

Төлөөлөн удирдах зөвлөл, Аудитын хорооны нарийвчилсан дүн шинжилгээ болон аудиторудтай хийсэн хэлэлцээрийн дүнд, Хөрөнгийн үнэ цэнийн бууралт нь ойролцоогоор 190 сая ам.доллар байхаар тооцсон ба энэ нь уул уурхайн үйл ажиллагаа явуулах эрхийг (Баруун наран) авсантай холбоотой гарсан. Ингэхдээ Группын 2014 оны 12 сарын 31-ээр дууссан санхүүгийн жилийн нэгдсэн тайлангийн талаарх ТУЗ-ын дүгнэлт болон Компанийн аудиторудтай хийсэн ТУЗ-ын зөвлөлгөөн болон бусад мэдээлэлд үндэслэсэн болно.

Компанийн 2014 оны жилийн эцсийн тайлан болон Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын №36 Хөрөнгийн үнэ цэнийн бууралт хэсэгт заасны дагуу, аливаа хуулийн этгээд нь тайлант үеийн эцэст тухайн хөрөнгө нь эргэн худалдагдах үнээсээ ихгүйгээр үнэлэгдэж буй эсэхийг нягтлана гэсэн байдаг. Иймд, Компани нь бие даасан хараат бус үнэлгээний тайлангуудад үндэслэн Группын үндсэн хөрөнгө, баригдаж буй барилга болон биет бус хөрөнгийн үнэлгээг дахин нягталсан болно. Эрэлт нийлүүлэлтийн зөрүүнээс үүдсэн дэлхийн коксжих нүүрсний үнийн уналт нь Баруун наран уурхайн үнэ цэнэ буурахад нөлөөлсөн бөгөөд үнэ бууралтын хэмжээг 190 сая ам.доллар гэж тогтоосон.¹⁵

Энэ дүгнэлтээс харахад "MMC" компанийн 464,465,000 сая ам.доллараар худалдаж авсан Баруун Наран ордын үнэ цэнэ 190 сая доллар болж буурчээ. Энэ хэмжээгээр "MMC" компани алдагдал хүлээж байна. Анх 260 сая ам. доллараар худалдаж аваад 464,465,000 сая ам.доллараар "Kerry Mining" Mongolia компани 204 465 000 сая ам.долларын ашиг олсон байна.¹⁶ Энэ худалдан авалтын асуудлыг тодруулах нь зүйтэй гэж Ажлын хэсэг үзэж байгаа болно.

Арван нэг. Тавантолгойн ордын дэд бүтцийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, Монгол Улсад эдийн засгийн үр өгөөжтэй байх хэлбэрийг тодорхойлох,

Монгол Улсад шинээр барих төмөр замын төсөлд Санхүүгийн зөвлөхөөр ажилласан "BNP Paribas" банкны 2014 онд гаргасан санхүүгийн загвараар Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын 1 тонн/км-ийн тээврийн тарифыг 3.8 центээр тооцоход төслийн IRR /зорилтот өөрийн хөрөнгийн өгөөж/ 14 хувь байгаа ба хөрөнгө оруулалтаа 12 жилд нөхнө, 2013 онд Австралийн "Айком" компанийн гүйцэтгэсэн төмөр замын техник эдийн засгийн үндэслэлд уг төмөр замын эдийн засгийн үр ашгийг жилийн тээвэрлэлт 30 сая тн, төмөр замын 1 тонн км-ийн тээврийн тарифыг 3.3 цент байхад 10 хувийн IRR /зорилтот өөрийн хөрөнгийн өгөөж/ байхаар тус тус тооцоолжээ.

¹⁵ Монголын уул уурхайн корпораци, Жилийн эцсийн тайлан 2014, хуудас 45, 113, 147, http://www.mmc.mn/upload/2015-04-21_EW101.pdf

¹⁶ <http://www.reuters.com/article/2011/05/31/qgx-mmc-idUSL3E7GV2WF20110531>

Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын суурь бүтцийг цаашид төрийн өмчит хуулийн этгээдэд үргэлжлүүлэн эзэмшүүлж, ашиглуулснаар төмөр зам ашиглалтад орсон жилээсээ эхлэн улсын төсөвт орлого төвлөрүүлэх бээдийн засгийн хувьд үр ашигтай давуу байдлыг бий болгох юм. Жишээ нь: Ухаа худаг-Гашуун сухайт чиглэлийн төмөр зам улсад төлөх татвараас гадна 25 жилийн хугацаанд нийт 1.9 тэрбум ам.долларын ногдол ашиг өгөхөөр тооцоологдож байна.

Түүнчлэн "Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого"-д заасан бусад чиглэлийн төмөр замуудын хөрөнгө оруулалтыг үе шаттай татан төвлөрүүлэх томоохон ач холбогдолтой юм.

Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2 дах заалт болон Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 121 дүгээр тогтоолд зааснаар Ухаа худаг-Гашуунсухайтын чиглэлийн төмөр замын суурь бүтэц нь улс орны нийгэм, эдийн засагт онцгой ач холбогдолтой төмөр замын суурь бүтэц юм.

Энэ чиглэлийн төмөр замын суурь бүтэц нь төрийн мэдэлд байснаар төмөр зам ашиглалтад орсон жилээсээ улсын төсөвт хөрөнгө төвлөрүүлэх болно.

Зөвхөн Ухаа худаг-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын хувьд улсад төлөх татвараас гадна 25 жилийн хугацаанд нийт 1,9 тэрбум¹⁷ ам.долларын ногдол ашиг төрд өгөх, "Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого"-д заасан бусад чиглэлийн төмөр замуудын хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар татахад томоохон ач холбогдолтой байна.

Гол үзүүлэлтийг дараахь хүснэгтэд харуулав. ("MTЗ" ХК-ийн эх сурвалжаас)


Үзүүлэлтүүд	Төрийн өмч давамгайлсан төслийн тусгай зориулалтын компани	Засгийн газрын 268 дугаар тогтоолын дагуу
Концессийн үргэлжлэх хугацаа	25-30 жил	30 жил
Төрд эргэн шилжүүлэх хувь	100%	51%
Концессийн хугацаанд төр, хувийн хэвшлийн эзэмших хувь	Төрийн мэдэлд 51 хувь	100% хувийн хэвшил хамтарсан гадаадын хөрөнгө оруулалттай компанийнхохн компанийн мэдэлд
Улсад төвлөрүүлэх татварын хувь	Хуулийн дагуу	Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу тогтворжуулсан татвар.

¹⁷Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын нийт ногдол ашиг ба оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээр хувиарлагдана.

Төрд оногдох ногдол ашиг	Оруулсан хувиар тооцож 25 жилд 1.9 тэрбум ам.доллар	Байхгүй
Эдийн засгийн үр ашиг (IRR)	13%	Тодорхойгүй
Тариф	Бүх тээвэрлэгчид ижил тарифаар	Төмөр замын концессийн Гэрээний 11.3-т зааснаар Суурь бүтэц зээмшигч тарифыг хууль тогтоомжийн хүрээнд, зах зээлийн зарчмаар дангаараа бие даан тогтоох, өөрчлөх эрхтэй.
Төслийн санхүүжилт	Төмөр замын зурвас газрыг үнэлэх, концессийн эрхийг үнэлэх, гэрээ байгуулсан гарын үсгийн эрхийг үнэлэх, өөрийн хөрөнгө, зээлийн санхүүжилт	Хөрөнгө оруулалт болон зээлийн санхүүжилт, (Төмөр замын концесс зээмших гэрээний 5.2 (b) зааснаар төмөр замын суурь бүтэц, тусгай зөвшөөрөл, хөдлөх бүрэлдэхүүнийг барьцаалж хөрөнгө босгоно)
Улсын төсөвт ирэх ачаалал	Төмөр замын зурвас газар болон концессийн эрхийг үнэлсэн тохиолдолд төрөөс нэмэлт хөрөнгө гарахгүй, төсөвт ачаалал өгөхгүй төрийн 51 хувьд оруулсан хөрөнгийг төрд ногдох ногдол ашгаас эргэн төлөх боломжтой	Төсөвт ачаалал өгөхгүй, гэвч үр өгөөж өгөхгүй
Ач холбогдол, Зах зээлийн өрсөлдөөн	Зах заалийн өрсөлдөөн ээлттэй байна. Төрийн мэдэлд анхнаасаа байх нь бусад чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэхэд санхүүгийн хувьд суурь болно	Зах зээлийн өрсөлдөөн хаалттай, Төмөр замын бодлого нэгдсэн байдлаар хэрэгжих боломжгүй

Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын 3.2.2-т заасан эхний үе шатанд барьж эхлэх төмөр замын суурь бүтэц, 3.2.4-т заасан 2 дахь үе шатанд барьж эхлэх төмөр замын суурь бүтцийг улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын суурь бүтэц гэж үзэн, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчтай хамтарсан тусгай зориулалтын компани байгуулах замаар нэгдсэн удирдлага, зохион байгуулалттайгаар цогцоор нь барьж байгуулахаар шийдвэрлэжээ.

Мөн Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 2011 оны 35/32, 2013 оны 07/04 тоот зөвлөмжөөр дээр төмөр замын суурь бүтцийг төрийн өмчит эсхүл



төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдэд шууд концессоор олгох, төмөр замын тээврийн тухай хууль болон төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод зааснаар төрийн өмчлөлд байхаар тус тус заасан.

Шинэ төмөр зам төслийг хэрэгжүүлж буй "Монголын төмөр зам" ТӨХК-ийн одоогийн хэрэгжүүлж төслийн бүтэц нь дээрх тогтоолын нөхцөлүүдийг бүрэн хангаж байгаа юм. Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоолын хавсралтаар Төслийн хөрөнгө оруулалтын бүтэц нь нийт хөрөнгө оруулалтын 40%-г өөрийн хөрөнгө оруулалтаар, үлдсэн 60%-г зээлийн санхүүжилтээр хийгдэхээр төлөвлөгдсөн ба ингэхдээ өөрийн хөрөнгө оруулалтын 51%-ийг Монгол улсын засгийн газраас санхүүжүүлсэнээр холбогдох хууль, тогтоомжийн дагуу тус суурь бүтэц нь төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байх байх боломжтойгоор баталсан байна.

Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих төслийн нийт хөрөнгө оруулалт нь ойролцоогоор 1 тэрбум орчим ам.доллар ба өнөөдрийн байдлаар Монгол Улсын засгийн газраас тус чиглэлд 212 сая ам.долларын буюу төлөвлөгдсөн өөрийн хөрөнгө оруулалтын 51%-ийн санхүүжилтийг хийсэн байна.

Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 121 дүгээр тогтоолд заасан төслийн хөрөнгө оруулалтын бүтцийн дагуу Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн өөрийн хөрөнгө оруулалтын 49%-д гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалт хийж, үлдсэн санхүүжилтийг зээлийн санхүүжилтээр хамтран босгох зэргээр хамтран үйл ажиллагаа явуулах бүрэн боломжтой байна.

Нүүрс олборлогч, тээвэрлэгч, худалдан авагч нь нэг этгээд байх нь өрсөлдөөнийг хязгаарлах томоохон эрсдэлтэй байна.

Монголын тал төмөр замын салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулагч талтай хамтрахдаа төмөр замын зурвас газрыг үнэлэх, концессийн эрхийг үнэлэх, тухайн чиглэлд Хөрөнгө оруулагчтай хамтарсан компани байгуулж, 49 хувийг худалдаж хөрөнгө босгох, гэрээ байгуулах гарын үсгийн урамшуулал авах зэргээр Монгол улсад ашигтай хэлбэрүүдийг сонгох нь зүйтэй байна.

Улсын Их Хурал 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулж Засгийн газрын өрийн хязгаар нь "эрчим хүч, төмөр зам, уул уурхайн салбарын хуулийн этгээдэд Засгийн газрын хувь нийлүүлсэн хөрөнгө оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцлөөр гаргасан Засгийн газрын баталгаанд хамаарахгүй" болсон тул Засгийн газар төмөр замын салбарын санхүүжилтэд баталгаа гаргаж хөрөнгө босгох бүрэн боломжтой болсон. Засгийн газар энэ давуу талаа ашиглаж ажиллах нь зүйтэй болно.

Арван хоёр. БНХАУ-тай байгуулсан Төмөр замын транзит тээврийн гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол Улсад хамгийн үр ашигтай байх нөхцлийг тодорхойлох,

Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай" Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 39 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийн 5/-д "дамжин өнгөрөх тээвэр, угуулан тавих нөхцөлийн талаар хэлэлцээ хийж..." гэж заасан байна. Энэ заалтын дагуу Засгийн газар Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах хөрөнгө оруулагчтай дамжин өнгөрөх тээврийн нөхцлийг тохиролцох ёстой.

Гэтэл Хөрөнгө оруулалтын гэрээний 7.1 (к)-д "Монгол улсын холбогдох хууль тогтоомж болон Монгол улсын олон улсын гэрээнд заасны дагуу Монгол улсаас тээвэрлэсэн нүүрсийг улсын хил болон БНХАУ-ын нутаг дэвсгэрээр шуурхай нэвтрүүлэх, улмаар далайн боомтод гарцтай болгох явдлыг Засгийн газар хангана" гэж Хөрөнгө оруулалтын гэрээгээр Хөрөнгө оруулагч талтай тохиролцох ёстой нөхцлийг Засгийн газарт хариуцуулсан байна.

Хэрэв Хөрөнгө оруулагч тал дамжин өнгөрөх тээврийн асуудлаар ямар нэгэн үүрэг хүлээхгүй бол Засгийн газар энэ боломжоо төрийн өмчит "МТЗ" ХК-д олгож, тээврийн үйл ажиллагааныг орлогыг төрд авах нь зүйтэй байна.

БНХАУ-ын дарга Си Зиньпин 2014 оны 08 сарын 22-ны өдөр Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр хоёр улсын Зам, тээврийн яамд хооронд байгуулсан «Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 3 дугаар зүйлд "...БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэх бараа, бүтээгдэхүүнийн дамжин өнгөрөх тээврийн тарифт Монгол улсад маш ашигтай хэлбэрээр хөнгөлөлт үзүүлэхээр болсон. Энэхүү хэлэлцээр Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүнийг гуравдагч зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

Улсын Их Хурлаар 2014 оны 10 дугаар сард төмөр замын царигийнасуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн тул БНХАУ, Япон зэрэг улсын томоохон компани, түншлэлүүд үе шаттайгаар хөрөнгө оруулах сонирхлоо нэмэгдэж эхэлжээ. Иймд төмөр замын төслийн хөрөнгө оруулалтыг Таван толгой ордоос тусад нь улсын төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй байдлаар татах боломжтой байна.

Засгийн газрын 268 дугаар тогтоолд тусгагдсан Таван толгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг ашиглалтад орсноос хойш 30 жилийн дараа 51 хувийг төрийн мэдэлд шилжүүлэх, шилжүүлэх хүртэлх хугацаанд концессын зүйлийг өмчлөх эрхийг олгох нөхцөлүүд нь Монгол улсын үндэсний ашиг сонирхолд нийцэхгүй байна. Мөн нүүрс олборлогч, тээвэрлэгч, худалдан авагч нь нэг этгээд байх боломжийг бий болгосон нь бусад этгээдийн бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд хүндрэл учрах томоохон эрсдэлтэй.

Монгол улс экспортын гарцууд, улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын суурь бүтцийн барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх

концессын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид удаан хугацаагаар олгох нь төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогыг үндэсний аюулгүй байдал, Монгол Улсын үндэсний ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх боломж хязгаарлагдах нөхцөл байдал үүсэхийг үгүйсгэхгүй.

Мөн Хөрөнгө оруулалтын Гэрээний 11.2 (b) болон (c) заалтаар тээвэрлэлт хийх ажлыг гадаадын туслан гүйцэтгэгч авах, гадаадын ажиллах хүчнийг ажиллуулж болох заалтууд нь төмөр замын тээврийг гадаадын компанид өгөх зорилгоор заасан заалт гэж үзэж байна.

Тэгээд ч энэ төмөр зам нь Хятадын талаас "Шенхуа" компанийн төмөр замд холбогдож байгаа бөгөөд "Шенхуа" компани төмөр замын тээвэрлэлтийг эрхэлнэ гэдгийг М. Энхсайхан сайдын Ардчилсан намын бүлэгт өгсөн асуулгын хариуд өгсөн 2015 оны 1 сарын 26-ны өдрийн ЗГ-3/54 албан тоотод тодорхой бичсэн байна.

Монгол улсын сайд М. Энхсайхан албан тоотдоо "Чайна Шенхуа Энержи компани нь БНХАУ дах нүүрс тээврийн зориулалт бүхий төмөр замын дэд бүтцийн сүлжээ борлуулалтын бүтэц зохион байгуулалтыг ашиглан Тавантолгойн ордоос олборлосон бүтээгдэхүүнийг БНХАУ-ын зах зээлд борлуулахтай холбоотой тээвэр ложистик болон борлуулалт болон далайн боомт хүргэж тээвэр ложистикийн үйл ажиллагааг голлон зохион байгуулна" гэжээ.

Энэ тохиолдолд төмөр замын тээврийн орлого Монголд үлдэхгүй.

Шинэ төмөр зам төслийг хэрэгжүүлж буй "Монголын төмөр зам" ТӨХК-ийн одоогийн хэрэгжүүлж төслийн бүтэц нь дээрх Монгол улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжид заасан нөхцөлүүдийг бүрэн хангаж байгаа юм.

Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоолын хавсралтаар Төслийн хөрөнгө оруулалтын бүтэц нь нийт хөрөнгө оруулалтын 40%-г өөрийн хөрөнгө оруулалтаар, үлдсэн 60%-г зээлийн санхүүжилтээр хийгдэхээр төлөвлөгдсөн ба ингэхдээ өөрийн хөрөнгө оруулалтын 51%-ийг Монгол улсын засгийн газраас санхүүжүүлсэнээр холбогдох хууль, тогтоомжийн дагуу тус суурь бүтэц нь төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байх байх боломжтойгоор баталсан байна.

Иймд Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ын өдрийн 121 дүгээр тогтоолын хавсралтад заасны дагуу шинээр барих төмөр замын суурь бүтэц эзэмших компанийн 51 хувийг МТЗ компани, 49 хувийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарт эзэмшүүлж, хөрөнгө оруулалт татаж, хамтран ажиллах нөхцөл бүхий заалтыг Ажлын хэсгээс санаачилж буй тогтоолын төсөлд тусгасан болно.

Ингэснээр Монгол Улсад шинээр барих төмөр замтай холбоотой гарсан Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн 32 дугаар тогтоолын 2-ын 2 дахь заалт, 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.1.2.5, 3.1.2.7, 3.2.1.4, 3.2.4.1 заалтууд болон Үндэсний аюулгүй байдлын 2011 оны 35/32 дугаар зөвлөмжтэй нийцэж, Засгийн

газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 121, 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 28 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангана.

Арван гурав. Дүгнэлт гаргахад шаардлагатай мэдээллийг гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллага, гадаад, дотоодын хөрөнгийн бирж, холбогдох компани, байгууллага, хувь хүнээс гаргуулах,

Ажлын хэсэг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Гадаад хэргийн яам, Уул уурхайн яам, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Зам, тээврийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, "Монголын төмөр зам" ХК, "Эрдэнэс Тавантолгой" ХК зэрэг төрийн байгууллага, төрийн өмчит компаниудаас албан ёсоор мэдээлэл, лавлагаа авсан болно. Мөн Тавантолгойн ордыг ашиглах асуудлаар "Нээлттэй нийгэм форум" ТББ, "Монгол 999" компаниудын нэгдэл зэрэг байгууллагаас байр сууриа илэрхийлсэн албан тоотыг Ажлын хэсэгт хүргүүлсэн болно. (Эдгээр байгууллагуудаас хүргүүлсэн албан тоотыг дүгнэлтэд хавсаргав)

ЭР болон "Чайна Шенхуа Энержи" компанийн хооронд байгуулж байгаа Хамтарсан компани байгуулах тухай гэрээ, Японы "Сумитомо" компанитай Худалдааны компани байгуулах гэрээ, ЭР болон ЭТТ компанийн хооронд байгуулж байгаа Эрх, үүрэг шилжүүлэх гэрээний төслийг Ажлын хэсэг удаа дараа шаардсан боловч Засгийн газар болон холбогдох компаниас хүргүүлээгүй болно.

Арван дөрөв. Бусад шаардлагатай санал, дүгнэлтийг гаргах,

14.1 "Тавантолгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын тухай

Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоол нь өмнө гарсан УИХ-ын тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж болон Засгийн газрын дараах тогтоолуудтай зөрчилдөж байна. Үүнд:

14.1.13 Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын 1-ийн е) "Эхний ээлжинд Таван толгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг өөрийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулах, ашиглалтад орсноос хойш 30 жилийн дараа 51 хувийг төрийн мэдэлд үнэ төлбөргүй шилжүүлэн өгөх үндсэн нөхцөл бүхий барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх эрхийг Концессын тухай хуульд заасан журмын дагуу хөрөнгө оруулагчид олгох. Таван толгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг ашиглалтад оруулсны дараа коксжих нүүрсний зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан Таван толгой-Сайншанд чиглэлийн төмөр замын төсөлд оролцуулах" гэсэн заалт нь:

- Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2-т "Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтцийг төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байхаар, эсхүл түүний өмчлөлд ашиглалтын тодорхой хугацааны дараа шилжүүлэх нөхцөлөөр шинээр байгуулж болох бөгөөд эдгээр суурь бүтэц, төмөр замын шугамын чигийг Засгийн газар тогтооно" гэсэн заалтыг,

- Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын бичиг баримтыг баталсан УИХ-ын 2010 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн 32 дугаар тогтоолын 2-ын 2/-т "эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой шинээр барих төмөр замын суурь бүтцийг Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2-т заасны дагуу төрийн өмчид байлгах" гэсэн заалтыг,

- Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 2011 онд 35/32 дугаар Зөвлөмжийн 1 дэх заалт "Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д шинээр барихаар заасан төмөр замын суурь бүтцийн концессыг төрийн өмчит, эсхүл төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдэд Концессийн хуулийн 17.1.1-д¹⁸ заасны журмын дагуу олгох" гэснийг,

- Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 2012 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 07/04 дугаартай зөвлөмжийн 2 дахь хэсгийн 1-д "Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 2011 оны 35/32 дугаар зөвлөмжийн 1-ийн 3 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд концессыг шууд гэрээний үндсэн дээр олгох..." гэснийг, (Зөвлөмжийн хуулбарыг хавсаргав)

- Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2 дахь заалт болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Зөвлөмжийг үндэслэн 1 болон 2 дахь үе шатанд баригдах /Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам ороод/ төмөр замын суурь бүтцийг улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтэц гэж тогтоож, төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг 100 хувийн төрийн өмчит "МТЗ" ХК-д олгосон Засгийн газар 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 121 дүгээр тогтоолыг,

- Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод заасан 1,2 дугаар үе шатанд барих (Тавантолгой-Гашуунсухайтын чиглэл ороод) төмөр замын суурь бүтцийг "барих-ашиглах-шилжүүлэх" концессийг "Монголын төмөр зам" ХК-д олгосон Засгийн газрын 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 28 дугаар тогтоолыг тус тус зөрчиж байна.

Иймд Засгийн газар Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих эрх болон концессийн гэрээг төрийн өмчит "МТЗ" ХК-аас шилжүүлэн авч бусад хуулийн этгээдэд шилжүүлсэн шийдвэр гаргах хуулийн үндэслэлгүй байна.

14.1.2 Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын 1-ийн ж) "Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээний хүрээнд ордыг ашиглаж үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагч компанийн 51 хувиас багагүй хувийг Монгол Улсад нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх, экспортлох үйл ажиллагааг 5-аас доошгүй жил эрхэлсэн туршлагатай, хувьцааных нь хяналтын багцаас доошгүй

¹⁸Концессийн тухай хуулийн 17.1 "Дор дурдсан тохиолдолд шууд гэрээ байгуулах аргаар концессыг олгож болно": 17.1.1 "уралдаант шалгаруулалт явуулах нь үндэсний аюулгүй байдалд харшилна гэж үзсэн"

хувь нь Монгол Улсын иргэний өмчлөлд сүүлийн 5 жилийн хугацаанд байгаа хувийн хэвшлийн оператор компани болон компаниудын концерциум өмчилдөг байх" гэсэн заалт нь:

- Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 39 дүгээр тогтоолын 1-ийн 1/ "Тавантолгойн нүүрсний ордод төрийн өмчит компани ашиглалтын үйл ажиллагаа явуулах, Эрдэнэт Тавантолгой охин компанийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг хуваахгүй шилжүүлэх, түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, оператор аж ахуйн нэгжээр олборлолтын үйл ажиллагааг тодорхой хугацаанд гүйцэтгүүлэх",
- Улсын Их Хурлын 2012 оны 9 дүгээр сарын 18 өдрийн 37 дугаар тогтоолоор баталсан Монгол улсын Засгийн газрын 2012-1016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт заасан "Таван толгойн орд газрыг төрийн мэдэлд байлгах. Тус орд газрыг ашиглах зорилгоор олборлох үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, компанийг дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах замаар байгуулан ажиллуулна" гэсэнтэй зөрчилдөж байна.

Олборлох үйл ажиллагаа нь нүүрсийг газрын хэвлийгээс ухаж газрын гадаргуу дээр гаргах үйл ажиллагаа болохоос дээр дурьсан шиг өргөн хүрээтэй үйл ажиллагаа биш. Тийм учраас 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 39 дүгээр тогтоолын 1-ийн 1/-д "...оператор аж ахуйн нэгжээр олборлолтын үйл ажиллагааг тодорхой хугацаанд гүйцэтгүүлэх" гэж тодорхой заасан байна.

14.1.3 Хөрөнгө оруулалтын Гэрээний 3.4 (а)-д зааснаар "Чалко"-н гэрээ ЭР-т шилжихгүй бөгөөд Чалко болон ЭТТ нь Чалко-н гэрээний талууд хэвээр үлдэнэ" гэсэн байна.

Энэ заалт нь "Тавантолгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай" гэсэн Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын 1-ийн г/ "Хөрөнгө оруулагч нь "Эрдэнэт Тавантолгой" ХК-иас БНХАУ-ын "Чалко" компанид төлөх өр төлбөрийн үлдэгдлийг хариуцан барагдуулж, тус компанитай байгуулсан гэрээний үүргийг хариуцах" гэсэн заалтыг зөрчиж байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын 268 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн "Тавантолгойн ордод хөрөнгө оруулж, хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох нээлттэй уралдаант шалгаруулалт"-ын үйл ажиллагааны нөхцөл, шаардлага шууд зөрчигдсөн байна.

"Тавантолгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 268 дугаар тогтоол нь Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн 40 дүгээр тогтоол, Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн 32 дугаар тогтоолын 2.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт заасан "Тавантолгойн орд газарт гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нартай хамтран олборлолт явуулна" гэж заасан заалт, Ухаа худаг - Гашуун сухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн концессийн эрхийг төрийн өмчит "МТЗ" компанид

олгосон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 35/32, 2012 оны 07/04 болон 2015 оны 04/03 дугаар зөвлөмжүүд Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 121 тогтоол, "МТЗ" ХК-д концесс олгосон 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 28 дугаар тогтоолуудыг тус тус зөрчиж байх тул Үндсэн хуулийн 45 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн хүчингүй болгох нь зүйтэй гэж Ажлын хэсэг үзэж санаачилж буй тогтоолын төсөлд тусгалаа. (Энд дурьдагдсан шийдвэрүүдийг хавсаргаа)

Хэрэв Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолыг хүчингүй болгохгүй бол Төрийн эрх бүхий байгууллагын дээр дурьдсан шийдвэрүүд зөрчигдөнө гэдгийг Засгийн газар болон ЭТТ нь мэдсээр байж Хөрөнгө оруулагч нарт худал баталгаа гарган төөрөгдүүлсэн хариуцлагыг хүлээх болно.

Учир нь Хамтын ажиллагааны Гэрээний 10.1 (b) заалтаар ЭТТ, Хөрөнгө оруулалтын гэрээний 21.1 (e) заалтаар Засгийн газар нь Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авсан, Гэрээг хууль тогтоомжид нийцүүлэн байгуулсан ба Монгол улсын хууль тогтоомжийг зөрчөөгүй гэдэг баталгаа гаргажээ.

14.2 Хөрөнгө оруулагчдын бүтцийн тухай

Энэхүү "Хамтын ажиллагааны гэрээ" болон Хөрөнгө оруулалтын гэрээг Монгол Улсын төрийн өмчит "Эрдэнэт Тавантолгой" ХК (цаашид ЭТТ гэнэ) болон Люксембургийн "Монголиан Коал Корпораци"-ийн 100 хувийн охин компани "Энержи Ресурс Корпораци" болон "Энержи Ресурс Корпораци"-ийн 100 хувийн охин компани болох "Энержи Ресурс" ХХК, Хятад улсын төрийн өмчит "Чайна Шенхуа Энержи компани лимитед" (цаашид Шенхуа гэнэ) компаниуд Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах зорилгоор байгуулахаар төсөл бэлтгэсэн байна.

Хамтын ажиллагааны Гэрээний "Талууд" гэсний 2 дахь хэсэгт болон Хөрөнгө оруулалтын гэрээний 5 дахь хэсэгт "Энержи Ресурс" ХХК-ийг цаашид "Теслийн компани" гэж заахаар томьёолжээ. Өөрөөр хэлбэл, "Энержи Ресурс" ХХК (ЭР), "Энержи Ресурс корпораци" (ЭРК), "Чайна Шенхуа Энержи компани" лимитед (Шенхуа) компаниуд хамтран Теслийн компани байгуулж байгаа гэх боловч энэ компани нь одоо Ухаа худаг ордод үйл ажиллагаа явуулж байгаа "Энержи Ресурс" ХХК байна.

Энержи Ресурс компанийг 51%-ийг ("Энержи Ресурс корпораци") 49%-ийг "Чайна Шенхуа Энержи компани" лимитед (Шенхуа) гэсэн харьцаатай эзэмшинэ. Хөрөнгө оруулалтын Гэрээний Үйл явдлын тойм хэсгийг (Н) заалт)

"Энержи Ресурс" ХХК нь "Энержи Ресурс Корпораци"-ийн 100 хувийн охин компани бол "Энержи Ресурс Корпораци" нь Люксембургийн "Монголиан Коал корпораци"-ийн 100 хувийн охин компани, Люксембургийн "Монголиан Коал корпораци" нь Хонконгийн "Монголиан Коал Корпораци Лимитед" компанийн 100 хувийн охин компани болох бөгөөд Хонконгийн "Монголиан Коал Корпораци Лимитед" компани нь Английн эзэмшил болох Кайманы арлын "Монголиан Майнинг Корпораци" (англиар Mongolian Mining Corporation, товчилсон нэр нь

ММС)-н охин компани байна. (Эдгээр компаниудын хамаарлын бүтцийг харуулсан схемийг хавсаргае)

Гэрээнд зааснаар ЭР-н Хөрөнгө оруулагч болох "Энержи Ресурс Корпораци", Хятадын төрийн өмчит "Шенхуа" компаниуд байна. Өөрөөр хэлбэл, эдгээр компаниуд нь Тавантолгойн ордыг ашиглах хөрөнгө оруулагчид нь болж байна.

"Энержи Ресурс Корпораци" нь 100 хувь гадаадын хөрөнгө оруулагчийн мэдэлд байх тул Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.5 дахь заалт "гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуйн нэгжийг хэлнэ гэсний дагуу гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байна.

"Энержи Ресурс Корпораци" нь 100 хувь гадаадын хөрөнгө оруулагчийн мэдэлд, "Шенхуа" нь гадаадын хуулийн этгээд байх тул эдгээрийн хамтран өмчлөх Тавантолгойн ордыг ашиглах Төслийн компани гэх ЭР нь шууд болон шууд бусаар гадаадын хуулийн этгээдүүдийн 100 хувь хяналтанд орж байна.

14.3 Хөрөнгө оруулагчдын эд хөрөнгө, хувьцаа барьцаанд байгаа тухай

Энэхүү дүгнэлтийн Хөрөнгө оруулалтын тухай гэсэн 10.6 дахь хэсэгт дурьдсанаар ЭР компаниас 1 тэрбум ам. долларт Ухаа худгийн уурхайд оруулсан байгаа хөрөнгө оруулалтыг багтааж тооцохоор заажээ.

М. Энхсайхан сайдын мэдэгдэж байгаагаас харахад хөрөнгө оруулалтын эдгээр үндсэн хэсгүүдийн уул уурхайн тоног төхөөрөмж, нүүрс баяжуулах үйлдвэр, усан хангамжийн байгууламж, эрчим хүчний байгууламж зэрэг нь ЭР-ийн одоо Ухаа худгийн орд дээр ашиглаж байгаа хөрөнгө болно.

Гэтэл ЭР-ийн хөрөнгө оруулалтанд тооцож байгаа уул уурхайн тоног төхөөрөмж, нүүрс баяжуулах үйлдвэр, усан хангамжийн байгууламж, эрчим хүчний байгууламж, бэлэн мөнгө, бараа материал зэрэг нь EBRD, FMO (Netherlands), DEG (Germany), BNP Paribas, BNP and ICBC Facility зэрэг олон улсын банкны 570 сая ам.долларын барьцаанд байна. (Эх сурвалж http://upload.mmc.mn/financial_report/ KPMG компанийн аудитын дүгнэлт, ... дүгээр хуудас)

Мөн ЭРК компанийг өмчлөгч болох Mongolian Coal Corp. Ltd (Хонгконг) болон Mongolian Coal Corp. S.a.r.l (Люксембург) зэрэг компанийн хувьцаа нь толгой компани болох Кайманы арал дахь Mongolian Mining Corporation (товчилж ММС) компанийн гаргасан бондын барьцаанд байна. (Эх сурвалж http://upload.mmc.mn/financial_report/ KPMG компанийн аудитын дүгнэлт, ... дүгээр хуудас)

Тавантолгойн ордыг ашиглах Төслийн компанийн 51 хувийг эзэмшихээр шалгараад байгаа "Энержи Ресурс Корпораци"-ийн хувьцаа нь толгой компани болох Кайманы арлын ММС компанийн их хэмжээний өрийн барьцаанд байх тул төслийг хэрэгжүүлэх санхүүгийн чадамжгүй гэж үзэж байна.

14.4 Люксембургийн 100 хувийн хөрөнгө оруулалттай "Энержи Ресурс Корпораци" ХХК, Тавантолгойн ордыг ашиглах уралдаант шалгаруулалтанд ороогүй тухай

Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийн 5/-д "дамжин өнгөрөх тээвэр, үгтүүлэн тавих нөхцөл, урьдчилгаа төлбөр, боомт ашиглалт, хөрөнгө оруулалт, борлуулалтын нөхцлийн талаар хэлэлцээ хийж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоотой нэгдсэн компани (консорциум)-ийг нээлттэй хэлбэрээр сонгон шалгаруулж хөрөнгө оруулалтын гэрээний төслийг УИХ-ын 2010 он намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлж, бусад баримт бичгийн төслийг танилцуулах" гэжээ.

Тэгээд ч "Тавантолгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын 1-д "УИХ-ын 2010 оны 39 дүгээр тогтоолын хүрээнд 2010 оны 12 дугаар сарын 8-нд зарлан явуулсан Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох нээлттэй уралдаант шалгаруулалт"-ын үйл ажиллагааг дор дурдсан нөхцөл, шаардлага, зарчмыг баримтлан үргэжлүүлэн явуулахаар шийдвэрлэсүгэй" гэжээ.

Засгийн газрын тогтоолоос харахад 2010 онд зарласан тендерийг үргэлжлүүлж байна. 2010 онд зарласан уралдаант шалгаруулалтанд оролцож богино жагсаалт буюу тендерийн хоёр дах үе шатанд 1. "Шинхуа Энержи" (БНХАУ) болон "Мицуй" (Япон) компанийн түншлэл, 2. "Пибоди Энержи" (АНУ), 3. "Оросын төмөр зам компани", "СУЭК" (ОХУ), Японы консорциум, Солонгосын консорциум, 4. "Вале" (Бразили), 5. "Экстрата Коал" (Австрали) 6. "Арселормиттал групп" (Люксембург) зэрэг зургаан компани шалгарсан байна.

Уралдаант шалгаруулалт энэ зургаан компанийн дунд үргэлжилсэн бөгөөд анхнаасаа тендерт ороогүй гадаадын хөрөнгө оруулалттай, хувийн ЭРК компани Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах Төслийн компанийн 51 хувийг авахаар гэрээний төсөлд тусгагдсан байна.

Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах уралдаант шалгаруулалтанд оролцохоор 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдөр байгуулагдсан Консорциумын гишүүнээр Энержи Ресурс ХХК, Шенхуа, Сумитомо компаниуд байна. Консорциумын гишүүнд ЭРК байхгүй байна. Гэтэл Хөрөнгө оруулалтын гэрээ болон дагалдах бусад гэрээнд ЭРК нь хөрөнгө оруулагчаар гарын үсэг зурахаар заасан байна.

Улсын Их Хурлын нэр бүхий 16 гишүүний асуулгад хариулсан М. Энхсайхан сайдын хариуд "Төслийн үйл ажиллагаанд Монголын уул уурхайн корпораци (монгол нэрээр) буюу ММС (англи нэр нь Mongolian Mining Corporation) өөрийн охин компани болох Энержи Ресурс ХХК-иар дамжин оролцоно" гэжээ.

М. Энхсайхан сайдын энэ хариулт нь "ММС" компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ж. Оджаргалын 2015 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Хувь нийлүүлэгчдээ хандаж хэлсэн "Хятадын "Шэнхуа энержи девелопмент лимитэд" болон "Сумитомо корпораци"-аас ("Консорциум") бүрдсэн консорциумыг зохион байгуулж, удирдан оролцсондоо баяртай байна" гэсэн үгээр батлагдаж байна. (Эх сурвалж: ММС компанийн 2014 оны жилийн эцсийн тайлангаас)

Каймэний арлын "ММС" компани, түүний охин компани болох Люксембургийн хөрөнгө оруулалттай ЭРК, ЭРК-ийн охин компани болох "Энержи Ресурс" ХХК зэрэг компаниудын аль нь ч 2010 онд зарласан Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах уралдаант шалгаруулалтанд ороогүй байна.

14.5 Сонирхлын зөрчлийн тухай

ЭР болон ЭТТ нь Тавантолгойн нүүрсний ордод ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Нэг төрлийн бүтээгдэхүүн олборлож нэг зах зээлд борлуулалт хийдэг өрсөлдөгч, сонирхлын шууд зөрчилтэй аж ахуйн нэгжүүд болно.

Тийм ч учраас Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах компани (консорциум)-ийг сонгох урьдчилсан шалгаруулалтын баримт бичгийн төслийг хэлэлцэж дэмжсэн Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 59 дүгээр тэмдэглэлийн 1.2-т "Ашиг сонирхлын зөрчилтэй хуулийн этгээдийг сонгон шалгаруулалтад оролцуулахгүй байх талаар анхаарч ажиллах" гэсэн байна.


Засгийн газар, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн бизнесийн өрсөлдөгч, сонирхлын зөрчилтэй хуулийн этгээд "Энержи Ресурс" ХХК-ийг Тавантолгойн нүүрсний ордлыг ашиглах уралдаант шалгаруулалтад шалгаруулсан нь Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 59 дүгээр тэмдэглэлийн 1.2-т заасныг зөрчиж байна.

14.6 Хамтын ажиллагааны болон Хөрөнгө оруулалтын Гэрээний хугацаа

Хамтын ажиллагааны Гэрээний 4.1 (а) болон 4.1 (b) заалтаар Энэхүү Хамтын ажиллагааны гэрээний хугацаа нь Хөрөнгө оруулалтын гэрээний хугацаанд хүчин төгөлдөр байна, гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа нь Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан хугацаатай ямагт нийцэж байх ёстой гэжээ. Энэ хоёр гэрээг хугацааны хувьд хооронд нягт холбож уялдуулсан зохицуулалт хийжээ. Талуудын хооронд байгуулж байгаа Хөрөнгө оруулалтын гэрээ нь 30 жил бөгөөд гэрээнд заасан үндэслэлээр дахин 30 жил сунгагдах нөхцөлтэй байна. (Хөрөнгө оруулалтын гэрээ 4.1 (а), (b) заалт)

Хөрөнгө оруулалтын Гэрээний 4.1 (а) (b) заалтаар гэрээний хугацаа 30, мөн 30 жил сунгагдахаар заасан байна. Мөн гэрээний хугацааг богиносгохгүй байхаар гэрээний 4.1 (h)-д заасан байна. Энэ нь гэрээний хугацааг хамгийн багадаа л 30 жил байхаар баталгаажуулсан заалт юм.

2015 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн Гэрээний 4.1 (e)-д зааснаар "гэрээний хугацааг оруулсан хөрөнгөө бүрэн нөхөх хугацаагаар сунгана"



гэсэн заалтыг Гэрээний 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн шинэчилсэн хувилбарт хассан байна.

Гэхдээ мөн Хөрөнгө оруулалтын гэрээний 2.2 (а) заалтаар ЭР нь нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр нэмэлт хайгуул хийнэ, мөн 4.1 (f)-д зааснаар "ЭР хайгуулийн үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалтаа бүрэн нөхөх хүртэл хугацаагаар энэхүү гэрээний хугацааг сунгах асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ" гэжээ. (2015 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн хувилбарт энэ заалт нь хайгуулийн үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалтаа бүрэн нөхөх хүртэл хугацаагаар энэ гэрээг сунгах эрхийг ЭР эдлэх үндэслэл болно гэж байсныг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ гэж уян хатан болгож өөрчилсөн байна)

Тэгвэл Хөрөнгө оруулалтын Гэрээний 2.1 (d) заалтаар ЭР нь хайгуул хийх төлөвлөгөөг гаргах, тайланг бие даан өөрийн үзэмжээр гаргах бүрэн эрхтэй байна. Хайгуулын ажил нь маш өндөр зардалтай бөгөөд түүнийг ЭР өөрийн үзэмжээр, өөртөө ашигтай хэлбэрээр гэрээнд ашиглах бүрэн боломжтой байна.

Эдгээр заалтуудаас харахад ЭР нь хайгуулийн үйл ажиллагааны зардлаа нэмж тооцож хөрөнгө оруулалтаа өсгөх, хайгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалтаа үндсэн 30 жил, сунгасан 30 жил нийт 60 жилд нөхөхгүй бол түүний нөхөх хүртэл тодорхойгүй хугацаагаар гэрээний хугацааг сунгах боломжийг авч үлдэхээр оролдож байна.

Гэвч Гэрээний энэ заалт нь Хөрөнгө оруулалтын гэрээний 2.2 (d)-д заасан нэмэлт хайгуулийн ажилд зарцуулсан ЭР-н зардлыг энэхүү Гэрээний 9.2 (l)-д заасны дагуу ЭР-н татвар ногдох орлогоос хасч тооцно гэж заасантай зөрчилдөж байна.

Гэрээний 2.2 (d) заалтаар ЭР нь хайгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлаа татвар ногдох орлогоос хасч тооцоод алдагдалгүй болж байна. Иймээс хайгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалтыг нөхөх тухай асуудал Талуудын хооронд байхгүй.

14.7 Барьцаалах эрхийн тухай

Хөрөнгө оруулалтын Гэрээний 6.1 (n) заалтаар ЭР нь "энэхүү Гэрээгээр олгогдсон эрх, үр шимийг Санхүүжүүлэгчид барьцаалах эсвэл шилжүүлэх эрхтэй" гэжээ. (2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн гэрээгээр энэ заалтанд найруулыг өөрчлөлт орж, Гэрээний өмнөх хувилбарт байсан ашиг, сонирхол болон Хөрөнгө оруулагч гэдгийг хассан байна)

Гэсэн хэдий ч Хамтран ажиллах Гэрээний 8.1 (b)-д "ЭР болон Хөрөнгө оруулагчид нь хөрөнгө босгох зорилгоор энэ гэрээний дагуу олгогдсон эрх, ашиг, сонирхол, үр ашгаа Хөрөнгө оруулагчид эсхүл Санхүүжүүлэгчид барьцаалах замаар шилжүүлэх эрхтэй" гэсэн байна.

Мөн энэхүү Хөрөнгө оруулалтын Гэрээний 8.3 (b)-д "Хөрөнгө оруулагчид болон ЭР нь энэхүү Гэрээний дагуу эдлэх эрх болон үр шим,

Цанхийн талбайгаас олборлосон боловсруулсан бүтээгдэхүүн, нүүрс боловсруулах үйлдвэр, үс, эрчим хүч хангах дэд бүтэц, бусад барилга байгууламж, барилгын ажил, төслийн бусад эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, ашиг сонирхлын хувьд барьцааны сонирхол үүсгэх эрхтэй" гэжээ.

Хөрөнгө оруулалтын Гэрээний 8.4 (с)-ийн (i), (ii) болон (d)-н (i), (iv), (vi), 8.5 (a), 14.1 (a) заалтуудаар дээрхи заалтуудыг баталгаажуулсан байна.

Эдгээр нь Хөрөнгө оруулалтын Гэрээний хамгийн ноцтой заалтууд болно. Ялангуяа Гэрээний 8.4 (с)-ийн (ii) d)-н (vi) заалтуудаар ЭР нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол санхүүжүүлэгчид нь төсөл болон ЭР-г, гэрээний удирдлагыг нэн даруй өөртөө эсвэл Гэрээний зүйлийг бусдад шилжүүлэх, ЭР-г өөр Гуравдагч этгээдээр сольж, эрх, үүргийг нь тухайн этгээдэд шилжүүлэн хэрэгжүүлэх эрхтэй" гэжээ. Мөн 8.4 (d) заалтаар Санхүүжүүлэгчийн хүсэлтээр Засгийн газар шууд гэрээ байгуулна гэжээ.

Монголын тал үүнд хяналт тавих ямар ч боломжгүй. Учир нь:

- Гэрээний Угтвар нөхцлийн D хэсэг, гэрээний 1.1 (a), (b), 1.2 (a) заалт болон 6.1 (d) заалтуудаар ЭТТ нь Цанхийн ашиглалтын тусгай зөвшөөрөлөөр олгогдсон үйл уурхайн үйл ажиллагаатай холбоотой бүх эрх болон зарим тодорхой үүрэг, уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой бүх эрхээ болон газар эзэмших эрхээ ЭР-д энэ гэрээний нийт хугацаагаар (Хамтын ажиллагааны гэрээний болон Хөрөнгө оруулалтын гэрээний үндсэн хугацаа 30 жил, сунгалт 30 жил) шилжүүлж байна.
- ЭР нь Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах ТЭЗҮ-д нэмэлт, өөрчлөлт хийх, уурхайн нарийвчилсан төлөвлөгөө, бүтээн байгуулалтын хөтөлбөр, уул уурхайн үйл ажиллагааны болон барилга угсралтын зардлыг тодорхойлох, хөрөнгө оруулалтын болзол нөхцлийг тогтоох (Хамтын ажиллагааны гэрээний 5.1 (n) заалт) болон Тавантолгойн ордоос боловсруулсан бүтээгдэхүүн болон олборлосон нүүрсээ экспортлох, худалдах, тээвэрлэх, худалдах, маркетинг хийх бүх ажиллагааг бие даан зохион байгуулах эрхтэй гэжээ. (Хамтын ажиллагааны Гэрээний 5.1 (d) заалт)
- Мөн Хөрөнгө оруулалтын гэрээгээр төслийн бүтээн байгуулалтын төлөвлөгөө болон барилгын ажлын хөтөлбөр (Гэрээний 4.2 (a) заалт), Хөрөнгө оруулалт хийх хуваарь тогтоох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах эрх ЭР-т байна. (Гэрээний 4.3 (a) болон 4.3 (c) заалтууд)
- Мөн ЭР нь Цанхийн талбайгаас аль ч жилд олборлох, боловсруулах бүтээгдэхүүний тоо хэмжээ болон бүтээгдэхүүн нийлүүлэх зах зээлийг сонгох, нүүрс боловсруулах зардал, үнэлгээг тодорхойлох, борлуулах, бүтээгдэхүүний тоо хэмжээ, худалдах үнийг тогтоох, тээврийн давтамж, тээвэрлэлтийн хэлцэл болон арилжааны бусад нөхцлийг тодорхойлох зэрэг бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой шийдвэрийг дангаараа бие даан тодорхойлж, бие даан

ажиллах эрхтэй гэжээ. (Хөрөнгө оруулалтын гэрээ 2.4 (b) болон 2.5 (b) заалт)

- Мөн ЭР нь Тавантолгойн ордод нүүрс олборлох, боловсруулах, түүнийг захиран зарцуулах, тээвэрлэх, экспортод гаргах, нүүрс худалдах, борлуулах, маркетинг хийх, санхүүжилт босгох, хөрөнгө оруулалт хийх, барьцааны сонирхол үүсгэх, төмөр зам барих, төмөр замын тээвэр хийх, нэмэлт хайгуул хийх, тогтоосон нөөцийг ашиглах, олборлох болон дагалдах дэд бүтэц барих үйл ажиллагаа явуулахаар заажээ. (Хөрөнгө оруулалтын Гэрээний 2.1 (b), 2.2 (a), (c) заалт)
- Хөрөнгө оруулалтын Гэрээнд зааснаар ЭР нь нарийвчилсан уулын ажлын төлөвлөгөө, уул уурхайн үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалт нөхцлийг тодорхойлж байна. (Хөрөнгө оруулалтын Гэрээний 2.1 (c) заалт). Мөн уул уурхайн үйл ажиллагааны хүрээг тодорхойлох, тооцоолол, уурхай хөгжүүлэх, хайгуул хийх төлөвлөгөө гаргах, тайланг бие даан өөрийн үзэмжээр гаргах, төслийн бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бүрэн эрхтэй байхаар заажээ. (Хөрөнгө оруулалтын Гэрээний 2.1 (d) заалт)

Иймд Тавантолгойн орд дээр нийтдээ 30 жил (сунгалт 30 жил) үргэлжлэх бодит боломж бүхий гэрээгээр авсан дээр дурьдсан бүх эрх, ашиг сонирхлоо ЭР нь Нэгд, Хөрөнгө оруулагч нарт, Хоёрт, Санхүүжүүлэгч нарт барьцаалан шилжүүлэх эрхтэй болж байна.

Хөрөнгө оруулалтын Гэрээнд зааснаар Хөрөнгө оруулагч нь Люксембургийн "Монголиан Коал корпораци"-ийн 100 хувийн охин компани болох "Энержи Ресурс Корпораци" болон Хятадын төрийн өмчит "Шенхуа" юм.

Хөрөнгө оруулалтын Гэрээний 30.1 (g)-д зааснаар Санхүүжүүлэгч гэдэг нь ЭР-т зээл олгож байгаа БНХАУ болон Япон улсын экспортын зээлийн агентлагууд, хөгжлийн банкууд, арилжааны банкууд болон олон талт санхүүгийн байгууллага зэрэг олон улсын хөрөнгө оруулагч эсвэл банк, санхүүгийн байгууллагыг ойлгоно гэж тодорхойлсон байна.

Хөрөнгө оруулалтын Гэрээний 8.4 (с)-ийн (ii) болон (d)-ийн (vi)-д зааснаар Санхүүжүүлэгч нь Гэрээний зүйлийг бусад этгээдэд шилжүүлэх, ЭР-ийг Гуравдагч этгээдээр сольж, эрх үүргийг нь тухайн этгээдэд шилжүүлэх эрхтэй байна. Үүнээс харахад эхнээсээ Гэрээнд ингэж бусад этгээдэд барьцаалах, шилжүүлэх эрх олгосон зохицуулалт тусгаж байгаа нь ЭР нь цаашдаа ийм үйл ажиллагаа хийх зорилготой бэлтгэсэн байна. Эдгээр заалтын дагуу ЭР нь Хөрөнгө оруулалтын болон дагалдах бусад гэрээнээс гарахаар төлөвлөжээ гэж үзэж байна.

Учир нь Хөрөнгө оруулалтын гэрээний 8.4 (с)-ийн (ii)-т зааснаар Хөрөнгө оруулагч, Санхүүжүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ ЭР нь санаатай буюу санаандгүйгээр зохих ёсоор биелүүлэхгүй байхад л энэ гэрээгээр олж авсан ЭР-н бүх эрх, ашиг сонирхол, эд хөрөнгө Санхүүжүүлэгчид шилжих нөхцөл бүрдэж байна.

Гэтэл Тавантолгойн орддыг хууль ёсны эзэмшигч болох төрийн өмчит ЭТТ компанид аливаа барьцааны эрх байхыг Хамтын ажиллагааны Гэрээний 8.2 (b) болон Хөрөнгө оруулалтын гэрээний 5.3 (a) заалтаар хориглосон байна. Товчхондоо Гэрээгээр Тавантолгойн ордтой холбоотой бүх эрх, ашиг сонирхол, эд хөрөнгийг ЭР барьцаалан бусдад шилжүүлж болно, төрийн өмчит ЭТТ-д тийм эрх байхгүй байхаар зохицуулалт хийжээ.

2015 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн 14.1-д "гадаадын хөрөнгө оруулагч нь Гэрээний эрх үүргээ "Шенхуа Групп Корпораци Лимитед" компанид (Шенхуа компанийн өөр нэг бүтэц) шилжүүлэх эсвэл бусад байдлаар захиран зарцуулах эрхтэй гэж заасныг 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан Хөрөнгө оруулалтын Гэрээний шинэчилсэн төслийн 6.1-ийн (n)-д дараахь хэлбэрээр өөрчлөн найруулсан байна. Үүнд, "Төслийн компани нь (ЭР) энэхүү гэрээгээр хүлээсэн олгогдсон эрх, үр шимийг Санхүүжүүлэгчид барьцаалах эсвэл шилжүүлэх эрхтэй" гэжээ.

Мөн Хөрөнгө оруулалтын гэрээний 14.1 дэх заалтын (a)-ийн (i)-д Төслийн компани нь өөрийн хамааралтай этгээдэд Гэрээний дагуух эрх, үүрэг, тусгай зөвшөөрлөө бүхэлд нь болон хэсэгчлэн шилжүүлэх, захиран зарцуулах, эсвэл (ii) энэхүү гэрээний 6.1 (n) эсвэл 8.5 хэсэгт заасан журмаар өөрийн эрх, ашиг сонирхлоо Санхүүжүүлэгчид барьцаалуулах, шилжүүлэхээс бусад тохиолдолд Энэхүү гэрээгээр хүлээсэн эрх үүргээ Засгийн газрын урьдчилан олгосон зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлж, захиран зарцуулахыг хориглоно" гэжээ.

Өмнөх гэрээ болон шинэчилсэн Гэрээний заалтын хувьд "Шенхуа Групп Корпораци Лимитед" компанийн нэрийг хассанаас өөр зарчмын өөрчлөлтгүй. Харин ч ЭР нь Засгийн газарт мэдэгдэж зөвшөөрөл авахгүйгээр эрх, ашиг сонирхлоо хамааралтай этгээд болон Санхүүжүүлэгчид шилжүүлэх эрхээ баталгаажуулсан заалт болжээ.

Үүнээс харахад Хөрөнгө оруулалтын Гэрээний "Эрх, үүрэг шилжих" гэсэн 14.1 дэх заалт нь энэ боломжийг урьдчилан нээж бэлтгэсэн зорилго бүхий заалт гэж дүгнэж байна. Эдгээр заалтын Засгийн газар, ЭТТ хэрхвэч хүлээн зөвшөөрч болохгүй гэж үзэж байна.

14.8 Ус ашиглах тухай

Хөрөнгө оруулалтын Гэрээний 2.7 (b),(c) болон 5.5 (c) заалтуудаар ЭР төслийн хүрээнд Балгасын улаан нуурыг үйлдвэрлэлийн зориулалтаар ус хангамжийн дэд бүтэц, байгууламжийг барьж, өмчилөх, тэргүүн зэлжинд ашиглах эрхтэй, түүнийг Засгийн газар зөвшөөрсөн бөгөөд хэрэв Засгийн Газар усаар хангах тохиолдолд шаардлагад нийцсэн, хангалттай хэмжээний ус найдвартай, тасралтгүй, тогтмол нийлүүлэх үүрэг хүлээсэн байна.

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутаг дахь Балгасын улаан нуурын газрын доорхи усны орд нь Даланзадгад хотоос зүүн урагш 45-60 км зайд оршдог. Говийн бүсийн цэнгэг усны томоохон орд юм. Ордын урт нь 20 км, өргөн нь 5-8.61 км талбайг хамарч байна.

Газрын гүнийн усаар ЭР-г найдвартай, тогтмол, тасралтгүй хангах үүргийг Засгийн газар хүлээх боломжгүй. Учир нь Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт орших Балгасын голын улаан нуурын газрын доорхи цэнгэг усны нөөц 102 226 га газрыг ундны усны нөөцөөр аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны 2010 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 7/8 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан байна. (2010 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 7/8 дугаар тогтоолын хуулбарыг хавсаргав)

Мөн Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 2010 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн "Усны нөөцийг хамгаалах арга хэмжээний тухай" гэсэн 34/28 дугаар зөвлөмжийн 2-т "Балгасын голын улаан нуур...-ыг газрын доорхи цэнгэг усны томоохон орд гэж үзэж тусгай хамгаалалтад авах талаархи саналыг ойрын үед боловсруулж УИХ-д өргөн мэдүүлж шийдвэрлүүлэхийг ЗГ-т даалгажээ. (Зөвлөмжийн хуулбарыг хавсаргав)

Улсын Их Хурлын дарга З. Энхболдод хандаж 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдөр Өмнөговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Л. Батчулуун 91 дүгээр албан тоот ирүүлсэн байна. Уг албан тоотод "Говь нутагт ундны усны хомдолтой, усны хэрэглээ өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа зэргийг харгалзан орон нутгийн зүгээс аймгийн төвийн 20 гаруй мянган иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах зорилгоор цаашид орон нутгийн тусгай хамгаалалтад хэвээр байлгах саналтай байгаа болно" гэжээ. (Албан тоотын хуулбарыг хавсаргав)

Ажлын хэсэг Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас лавлагаа авсан бөгөөд тус яамнаас 2015 оны 5 дугаар сарын 20-ны өдөр хүргүүлсэн 08/3026 дугаар албан тоотод "...2020 он хүртэл газрын доорхи усны батлагдсан 404,19 л/с нөөцөөс ашиглалтын 151 л/с-ийн хэмжээнд экологид сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр усыг ашиглах боломжтой. Цаашид нүүрс угаах үйлдвэрлэлийн техникийн усны эх үүсвэрийг говийн бүсийн цэнгэг усны нөөц бүхий ордыг ашиглахгүйгээр эрдэсжилт ихтэй газрын доорхи усны ордоос авах саналыг хүргүүлж байна" гэжээ.

Мөн Балгасын улаан нуур орших Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Жаргалант багийн иргэдийн нийтийн хурал 2013 оны 10 дугаар сарын 5-ны өдөр хуралдаж уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорхи гүнийн ус ашиглахыг хориглох тухай 11 дүгээр тогтоол баталсан байна. (Тогтоолын хуулбарыг хавсаргав)

2012 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Ханхонгор сумын ИТХ-ын тэргүүлэгчид хуралдаж 47 дугаар тогтоол гаргаж Ханхонгор сумын Жаргалант багийн иргэдийн нийтийн хурал 2013 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн "Уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорхи гүнийн ус ашиглахыг хориглох тухай" 11 дүгээр тогтоолыг дэмжсэн байна. (Тогтоолын хуулбарыг хавсаргав)

2015 оны 5 дугаар сарын 12-ны өдөр Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Жаргалант багийн иргэдийн нийтийн хурлын ээлжит бус хуралдаан болж цэнгэг усны ундарга болсон Балгасын улаан нуурыг уул уурхайн үйлдвэрлэлд ашиглуулахгүй хуурай технологиор угаахыг дэмжсэн шийдвэр гаргажээ.

ЭТТ нь тавантолгойн ордод хуурай аргаар нүүрс баяжуулах шинэ технологийг нэвтрүүлэхээр Японы "Нагата Инженеринг" компанитай Санамж бичиг байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд нүүрсний 0 болон 4 дүгээр давхаргаас дээж явуулан баяжигдах туршилтыг хийлгэжээ. Мөн жилд 5 сая тонн нүүрс баяжуулах үйлдвэрийн урьдчилсан эдийн засгийн судалгааг хийлгэж, туршилтын бага оврын үйлдвэрийг Тавантолгойн ордод барих бэлтгэл ажлыг хийж байна.¹⁹

Иймд Тавантолгойн ордыг ашиглах компани цэнгэг усны нөөцийг ашиглах асуудлыг цаашид нягтлан үзэх шаардлагатай.

14.9 Цанхийн болон Бортээгийн тусгай зөвшөөрөл бүхий талбайн давхцлын тухай

"Эрдэнэс Таван толгой" ХК нь MV-011943 (2,046.4 га), MV-016883 (700.39 га), MV-016881 (556.72 га), MV-016882 (2,447.13 га), MV-011953 (12,864.47 га), MV-011954 (22,901.37 га), MV-011955 (23,813.1 га), MV-011956 (3,151.92 га) тоот нийт 68481.5 га талбай бүхий 8 ширхэг ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг.

Тавантолгойн ордод Цанхи, Ухаахудаг, Бортээг, Ончхараат, Оорцог, Бортолгой гэсэн нүүрсний нөөцийн талбайнууд хамрагддаг. Эдгээрээс нарийвчилсан судалгааны ажил бүрэн хийгдэж, ашиглалтанд бэлтгэгдсэн нүүрсний нөөцийн талбай нь Цанхийн хэсэг юм.

Хамтын ажиллагааны тухай гэрээний Угтвар нөхцлийн В-д болон Хөрөнгө оруулалтын гэрээний Угтвар нөхцлийн В-д ЭТТ компанийн эзэмшилд байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг нэрлэсэн байна.

Өмнөговь аймгийн нутагт орших нийт 5740.57 га талбайг хамарсан MV-011943, MV-016881, MV-016882, MV-016883 дугаартай 4 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг Цанхийн ашиглалтын тусгай зөвшөөрөл гэж заажээ.

Гэтэл Гэрээнд заасан 4 тусгай зөвшөөрлийн энэ талбай нь Цанхийн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай гэх боловч тус Тавантолгойн нүүрсний ордын Бортээгийн тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас зарим хэсгүүд хамаарагдан орж байна. Бортээгийн талбайгаас нийт 1786.98 га талбай хамрагдаж байгаа бөгөөд энэ нь А+В+С зэрэглэлээр 525.6 сая тонн, А+В+С+Р1 зэрэглэлээр 203 сая тонн, нийт 728.7 сая тонн коксжих боон эрчим хүчний нүүрсний нөөц байна. Цаашид тухайн талбайн нөөц нарийвчилсан болон ашиглалтын хайгуулын ажлаар нэмэгдэнэ. ("Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 01/788 дугаар албан тоотоор ирүүлсэн мэдээлэл)

¹⁹ЭТТ нь цаашдаа говийн уул уурхайг гадаргын усаар хангах Орхон говь төсөлтэй үйл ажиллагаагаа уялдуулах бодлого баримталж байна. Орхон говь төсөл нь 2015 онд ТЭЗҮ-ээ дуусгаж, төслийг концессийн жагсаалтанд оруулах, хөрөнгө оруулалтын хэлбэрийг тодорхойлж, 2020 онд төслийг хэрэгжүүлж говьд ус очихоор төлөвлөжээ.

Энэ давхцалыг арилгах зорилгоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас Цанхи, Бортээгийн талбайн тусгай зөвшөөрлийг салгах талаар хүсэлтээ Ашигт малтмалын газарт 2015 оны 3 дугаар сарын 9-нд асуудлыг ЭТТ шийдвэрлэх хүсэлтээ гаргасан хэдий ч одоо болтол шийдэгдээгүй байна.

Иймд энэ асуудлыг шийдвэрлэж талбайн давхцлыг яаралтай арилгах үүргийг төрийн холбогдох байгууллагад өгөх шаардлагатай болно.

14.10 Цанхийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн нөөцийн тухай

Олон Улсын Жорк стандартын нөөцийн тооцоогоор Тавантолгойн нүүрсний ордын нөөц 7.38 тэрбум тонн ба үүнээс ашиглалтын батлагдсан, бодитой нөөц 3.9 тэрбум тонн байна.

Баруун болон зүүн Цанхийн тусгай зөвшөөрөлтэй талбайн ашиглах боломжтой батлагдсан бодит нөөц 2.4 тэрбум тонн байна. Энэ нь нийт ордын ашиглах нөөцийн 60.8 хувийг эзэлж байна. (Эх сурвалж: "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2015 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Ажлын хэсэгт хүргүүлсэн 01/712 дугаар албан тоот)

14.11 Ажиллах хүчний тухай

2015 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн Хөрөнгө оруулалтын Гэрээний 5.9 (a), (b), (c), (d) –д ЭР нь өөрийн ажилтнуудыг бие даан чөлөөтэй сонгох бөгөөд төсөлд ажиллах монгол иргэдийн тоог өрсөлдөөний зарчим дээр тулгуурлан аль болох их байлгахыг эрмэлзэнэ, гадаадын иргэдийг ажиллуулах зөвшөөрлийг Засгийн газар хамгийн таатай нөхцлөөр, шаардагдах хэмжээгээр ажиллах хүчний квот тогтоож өгнө зэрэг заалтуудыг 2015 оны 4 дүгээр сарын 23-нд Засгийн газраас УИХ-д өргөн барьсан Гэрээний шинэчилсэн хувилбарт хассан байна

Засгийн газраас 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан Гэрээний шинэчилсэн хувилбарын 5.9 (c), (d)-д "... ажлын байранд тавигдах зохих шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг ажлын байраар хангана. Шаардлагатай тохиолдолд Засгийн газар ЭР, Концесс эзэмшигч болон тэдгээрийн гэрээлэгчид, эсвэл туслан гүйцэтгэгчийн барилга угсралтын ажилд шаардагдах хэмжээгээр гадаад ажиллах хүчний квот тогтоож дэмжлэг үзүүлж болно" гэж өөрчлөн заасан байна.

Гэрээний 5.9 (d) заалтын "шаардагдах хэмжээгээр" гэдэг нөхцөл нь Ашигт малтмалын тухай хуулийн 43.1 дэх заалт "Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон түүний туслан гүйцэтгэгч нь Монгол улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно" гэсэн заалт болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27.4-д "Монгол улсын нутаг дэвсгэрт хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэдийн тоо нь Монгол улсын харьяат хүн амын 3 хувь, үүний дотор нэг улсын иргэн 1 хувь хүртэл байж болно" гэж заасныг зөрчинө.

Засгийн газар энэ хуулийн хүрээнд Монгол улсад ажиллах гадаадын ажилчдын квотыг тогтоох үүрэг хүлээх нь зүйтэй.

14.12 Гэрээний хэл, маргаан шийдвэрлэх тухай

14.12.1 Хамтын ажиллагааны Гэрээний 14.5-д "Гэрээг англи, монгол хэл дээр байгуулж байгаа бөгөөд зөрүү гарвал англи эхийг баримтлана" гэжээ.

Улсын Их Хуралд өргөн барьсан гэрээнүүдийн монгол хэл дээрхи хувилбарыг уншиж үзэхэд албан ёсны оруулга биш, гэрээний төслийг анх англи хэлээр бэлтгэж хувийн аль нэг хуулийн фирм, эсвэл орчуулгын товчоо монгол хэл рүү орчуулсан нь илт байна. Тухайлбал Хөрөнгө оруулалтын гэрээний 7.1(m)-д "Засгийн газраас зааварчилгаа эсвэл шаардлага хүлээн авдаг Эрх бүхий байгууллага" гэсэн нэр томъёог хэрэглэсэн нь төрийн албан ёсны хэлэнд хэрэглэгддэггүй, орчуулгын хэллэг болохыг батлана.

Ажлын төвшинд хийгдэж байгаа гэрээний монгол хэл дээрхи орчуулгыг албан ёсны гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй. Төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал нь Гадаад хэргийн яамаар хянагдаагүй, гэрээний төслийг хэлэлцэх нь боломжгүй гэж үзэж байна. Оюутолгойн гэрээг байгуулахад Гадаад хэргийн яам албан ёсоор орчуулгыг нь хянаж баталгаажуулан Улсын Их Хуралд өргөн барьсныг тэмдэглэх нь зүйтэй.

Иймд гэрээний монгол хувийг Гадаад хэргийн яамны эрх бүхий төрийн албан хаагчид монгол хэл дээр боловсруулах ёстой.

Тэгээд ч 2010 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн Үндэсний аюулгүй байдлын хуралдааны 24/11 дүгээр тэмдэглэлд Тавантолгойн стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах баримт бичиг, гэрээний төсөл болон холбогдох бусад баримт бичгийг монгол, англи хоёр хэлээр алдаа мадаггүй боловсруулах" гэснийг Монголын тал мөрдөх ёстой.

Хөрөнгө оруулалтын гэрээ болон бусад дагалдах гэрээний англи хэл дээрхи хувийг харьцуулан хянаж үзлээ. Англи болон монгол хэл дээрх Гэрээний хооронд орчуулгын алдаа маш олон байна. Орчуулгын алдааг дотор нь 2 хувааж үзэж болохоор байна. Үүнд, 1. Орчуулгын алдаанаас болж тухайн заалтын үндсэн утга алдагдсан, 2. Техникийн шинжтэй, үг үсэг алдаж орчуулсан.

Англи хэл дээрх гэрээний орчуулгыг албан ёсоор орчуулга хийлгэх нь зүйтэй гэж үзэж Хөрөнгө оруулалтын гэрээ болон дагалдах бусад гэрээний англи хэл дээрхи хувийг Гадаад хэргийг яаманд хүргүүлсэн болно.

14.12.2 Хөрөнгө оруулалтын Гэрээний 26.1 (d)-н (vi) болон (g)-н (ii) заалтаар "маргаан гарвал Арбитрийн журмаар Лондонд шийдэгдэнэ. Арбитрт хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой Засгийн газар өөртөө буюу түүний хөрөнгийн хувьд аль нэг харьяалалын дагуу одоо байгаа эсвэл ирээдүйд үүсч болох халдашгүй дархан эрхээсээ татгалзаж байна" гэжээ.

"Улс болон гадаад улсын иргэний хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай" 1965 оны олон улсын конвенц /цаашид "Конвенц" гэх/-д Монгол Улс 1996 онд нэгдэн орсон байна.

Гэтэл дээр дурьдсанчлан "Засгийн газар буюу түүний нэрийн өмнөөс өөрийн бүрэн эрх, халдашгүй байдлаа ашиглан өөрийгөө болон хөрөнгөө тухайн Маргаан шийдвэрлэх ажиллагаанаас чөлөөлүүлэх хүсэлт, шаардлага гаргахгүй байх, маргаантай холбоотойгоор одоо байгаа эсвэл ирээдүйд үүсч болох халдашгүй дархан эрхээсээ татгалзах" зэрэг шаардлагыг Конвенцид тусгагдаагүй, өөрөөр хэлбэл уг Конвенцид нэгдэн орсон улсууд тийнхүү өөрийн дархан эрхээсээ татгалзах үүрэг хүлээгээгүй байна.

Эдгээрээс үзвэл Монгол Улсын Засгийн газар Гэрээ болон гэрээтэй холбогдолтой хэлцэл, тохиролцооноос үүдэн гарах Монгол Улсын Засгийн газар болон түүний хөрөнгийн эсрэг аливаа маргаан үүсэхэд Засгийн газар одоогийн болон ирээдүйд үүсэх халдашгүй дархан эрхээсээ татгалзах нь Конвенцийн дагуу заавал хүлээх үүрэг биш байна.

Нөгөөтэйгүүр Засгийн газар, Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын болон дагалдах бусад гэрээг дан ганц "Энержи Ресурс Корпораци" ХХК-тай бус, БНХАУ-ын Төрийн өмчит "Шенхуа" компанитай хийж буй тул ирээдүйд хатуу зохицуулалттай гэрээний асуудлаар маргаан гарахад үүсэх улстөрийн эрсдэл, хоёр улсын харилцаанд хэрхэн нөлөөлөх гэдэг талаас нь маш анхаарал, болгоомжтой хандах шаардлагатай гэж үзэж байна.

Иймд Гэрээний албаны ёсны орчуулгыг Гадаад хэргийн яамаар хянуулж албажуулах шаардлагатай.

15. Хөрөнгө оруулалтын Гэрээний "Хавсралт"-5 болох Засгийн газрын төлөх нөхөн олговрын тооцооллын тайлбар

1. Банкны зээлийн нөхөн олговор нь жил бүрийн дундаж хөрөнгө оруулалтыг банкны зээлийн хүү 12% болон 10% дискаунттай анх хөрөнгө оруулалт хийснээс хойш гэрээ цуцлах хүртэлх хугацааны нийт жилийн тоо (x)-ны нийлмэл хэмжээний үржигдэхүүний нийлбэр байна.

$$\sum_{t=1}^x AWAt * 12\% * (1 + 10\%)^x$$

2. Хөрөнгө оруулагчдын олон байсан орлогын алдагдалын нөхөн олговор нь жил бүрийн дундаж хөрөнгө оруулалтыг 15% ашигтайгаар тооцож 10% дискаунттай анх хөрөнгө оруулалт хийснээс хойш гэрээ цуцлах хүртэлх хугацааны нийт жилийн тоо (x)-ны нийлмэл хэмжээний үржигдэхүүний нийлбэр байна.

$$\sum_{t=1}^x AWAt * 15\% * (1 + 10\%)^x$$

3. Барилга бүтээн байгуулалтын гэрээг цуцлах тохиолдолд Засгийн газраас төлөх нөхөн олговрын хэмжээ нь гэрээ цуцлах үед баланс дээр тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн хэмжээг хөрөнгө оруулагчдын ашгийг 15%-иар тооцоолж 10% дискаунттай анх хөрөнгө оруулалт хийснээс хойш гэрээ

цуцлах хүртэлх хугацааны нийт жилийн тоо (n)-ны нийлмэл хэмжээнийнийлбэр байна.

$$\sum_{t=1}^n \frac{\text{The Initial value of T\&I assets} * 1\%}{(1 + 10\%)^t} * n$$

Жишээлбэл, хэрэв Засгийн газар хөрөнгө оруулалт болон концессын гэрээнүүд зурагдсанаас хойш 1 жилийн дараа уг гэрээнүүдийг цуцалсан тохиолдолд, Засгийн газар нь MMC болон Шинхуа нарын хөрөнгө оруулагчдийн консорциумд нийт 51.1 сая ам.доллар төлөх тоцоо дээр томьёонуудын үндсэн дээр гарч байна. Хэрэв Засгийн газар гэрээнүүдийг 3 дахь жилд нь цуцалсан тохиолдолд, нийт 409.4 сая ам.доллар төлнө, 5 жилд – 966.8 сая ам.доллар, 7 жилд – 1.467 сая ам.доллар, 10 жилд – 2,041.3 сая ам.доллар зэргийг төлөхөөр байна.

Доорх хүснэгтээс эдгээр нийлбэрийн задаргааг үзнэ үү.

ЗАСГИЙН ГАЗРЫН ГЭРЭЭ ЦУЦАЛСАН ТОХИОЛДОЛД НӨХӨН ОЛГОВОРЫН ХЭМЖЭЭ
Гэрээ цуцлах жил:
Баяны эзэлгэн нөхөн олговор (1)
Хөрөнгө оруулагчдын өлнө байсан орлогын алдагдалын нөхөн олговор (2)
Барилга, бүтээн байгуулалтын гэрээг цуцлах тохиолдолд төлөх нөхөн олговор (3)
Засгийн газрын нийт олговорын хэмжээ

1 жил	3 жил	5 жил	7 жил	10 жил
\$3.9	\$23.3	\$46.7	\$47.5	\$47.5
4.9	27.6	46.7	61.2	61.2
42.3	358.5	873.4	1,358.4	1,932.6
\$51.1	\$409.4	\$966.8	\$1,467.0	\$2,041.3

16. Дүгнэлт

Улсын Их Хурлын даргын 2015 оны 101 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг удирдамжийн дагуу ажиллаад дараах дүгнэлт, шийдвэрийн төслийг бэлтгэн танилцуулж байна.

16.1 Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах Консорциумтай хийхээр бэлтгэсэн Хөрөнгө оруулалтын Гэрээ болон дагалдах бусад гэрээ нь Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Иргэний хууль, Газрын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж байна.

16.2 Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах талаар зарласан Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоол нь Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн 40 дүгээр тогтоол, Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн 32 дугаар тогтоолын 2.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт заасан "Тавантолгойн орд газарт гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нартай хамтран олборлолт явуулна" гэж заасан заалт, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 2011 оны 35/32, 2012 оны 07/04 болон 2015 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 04/03 дугаар зөвлөмжүүд, Ухаа худаг - Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих эрхийг төрийн өмчит "МТЗ" компанид олгох Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 121 тогтоол, "МТЗ" ХК-д төмөр замын суурь бүтцийн концесс олгосон 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 28 дугаар тогтоолуудыг тус тус зөрчиж байна.

16.3 Тавантолгойн нүүрсний ордыг ашиглахаар уралдаант шалгаруулалтанд ялсан Консорциумтай байгуулахаар төлөвлөсөн Хамтын ажиллагааны гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээ, Төмөр замын концессийн гэрээнүүд нь Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжид нийцээгүй, үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд харш, гэрээний талуудын эрх тэгш байдлыг хангаагүй байна.

16.4 "Эрдэнэс Тавантолгой" ХК-д 2,558,175,510 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа Монгол улсын 2,475,201 иргэн болон 8,497,671 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа Монгол улсын 553 аж ахуйн нэгжийн хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулах, тэдний ашиг сонирхол, эрх ашгийг хангасан арга хэмжээ аваагүй. Энэ талаархи зохицуулалтыг Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээ болон дагалдах бусад гэрээнд тусгаагүй байна.

Улсын Их Хурлын Өргөдлийн Байнгын хороо 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдөр хуралдаж, 05 дугаар тогтоол гарган "Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 1072 хувьцааг эзэмшиж буй иргэдийн эрх ашгийг хамгаалах, хувьцааны эдийн засгийн үр өгөөжийг хүртэх боломжийг бүрдүүлсэн зохицуулалтыг Тавантолгойн ордон хөрөнгө оруулагчидтай хийх гэрээ, хэлэлцээрт тусгайлсан бүлэг болгон тусгах" үүргийг Засгийн Газар өгсөнийг биелүүлээгүй байна.

Мөн 2015 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн хуралдаанаас гаргасан 04/03 дугаар Зөвлөмжийн 4 дэх заалтаар "Монгол улсын иргэдэд олгосон "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг эдийн засгийн эргэлтэд оруулж, хувьцааны ногдол ашиг хүртэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах" үүргийг Засгийн газарт өгсөн нь хэрэгжээгүй байна.

16.5 Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 39 дүгээр тогтоолд заасан "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 20 хүртлэх хувийг дотоодын болон гадаадын хөрөнгийн биржээр худалдаж шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах арга хэмжээг Хөрөнгө оруулалтын гэрээ болон дагалдах бусад Гэрээнд тусгаагүй. Консорциумтай байгуулах Хамтын ажиллагааны гэрээ болон Хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөл Монгол улсад ашиггүй байгаа нь "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн үнэ цэнийг бууруулж, үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлаж, тус компанийн үнэ цэнийг бууруулж, хувьцааг дотоод, гадаадын хөрөнгийн биржид арилжаалах боломжийг хааж байна.

16.6 Засгийн газрын Ажлын хэсэг Тавантолгойн нүүрсний ордыг ашиглахаар шалгарсан Консорциумтай хэлэлцээр хийж Хөрөнгө оруулалтын гэрээ болон дагалдах гэрээний төслийг бэлтгэхдээ Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн 40 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Тавантолгойн нүүрсний ордыг хамтарч ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үндсэн зарчим, удирдамжийг мөрдөөгүй, түүнийг хэрэгжүүлээгүй байна.

16.7 Тавантолгойн ордыг ашиглах Хамтын ажиллагааны гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээ, төмөр замын концессийн Гэрээ нь Гуравдагч хөршийн бодит оролцоо, хөрөнгө оруулалтыг хангаагүй, Монгол улсын гадаад бодлогод баримтлаж буй Гуравдагч хөршийн бодлоготой нийцэхгүй байна.

16.8 Тавантолгойн нүүрсний ордын дэд бүтцийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын хэлбэр нь Монгол улсад эдийн засгийн үр өгөөж багатай, Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг Тавантолгойн уралдаант шалгаруулалтын нэг хэсэг болгон хувийн, гадаадын хөрөнгө оруулалттай компанийн охин компанид шилжүүлэх нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 35/32, 2012 оны 07/04 болон 2015 оны 04/03 дугаар зөвлөмжүүд, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогыг баталсан Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн 32 дугаар тогтоолын 2-ын 2 дахь заалт, Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 121, 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 28 дугаар тогтоолыг тус тус зөрчиж байна.

16.9 Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 2010 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд заасан "үлстөрийн албан тушаалтаныг хэлэлцээрийн аль нэг талд оролцуулахгүй байх" заалтыг Засгийн газар зөрчиж үлстөрийн албан тушаалтан Монгол улсын сайд М. Энхсайханаар хэлэлцээ хийх ажлын хэсгийг ахлуулсан байна. Улмаар тухайн үлстөрийн албан тушаалтан нь үндсэндээ дангаараа шийдвэр гарган УИХ-ын 2008 оны 40 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан удирдамжид заасан "гэрээний төсөл боловсруулахдаа олон улсад нэр хүнд бүхий зөвлөгөө үзүүлэгч байгууллагын туслалцааг авах" гэснийг зөрчсөн байна.

Ингэснээр олон улсын нэр хүнд бүхий хууль, санхүүгийн зөвлөхүүд хөлсөлж авсан хөрөнгө оруулагч Консорциумын талтай адил түвшинд ажиллаж чадаагүй байна. Ажлын хэсэг төрийн ашиг сонирхлын үүднээс харах ёстой олон асуудлууд, тухайлбал хөрөнгө оруулагч талын санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийх, олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулагчийн дотоод бүтэц, үйл ажиллагааны дүрэм журмыг судлах, гэрээнд буй нарийн тодруулах, тухайн гадаадын хөрөнгө оруулагчийн харьяалдаг улстай Монгол Улс байгуулсан олон улсын гэрээнүүд төсөлд хэрхэн нөлөөлөхөд дүгнэлт хийх гэх мэт дан ганц төрийн албан хаагчдын хийх боломжгүй олон асуудлыг орхигдуулжээ.

16.10 Улсын Их Хурлын 2014 оны 34 дүгээр тогтоолын хавсралтын 1.4-т "... орд газрыг иж бүрэн хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн асуудлыг эдийн засгийн үр ашигтай, улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй байх хувилбараар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог хангах зарчмаар цогцоор нь шийдвэрлэх" гэж заасан атал Засгийн газар зөвхөн Цанхийн хэсгийг хөгжүүлэх, Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг барих асуудлыг шийдвэрлэж Тавантолгой-Сайншанд-Хөөт-Чойбалсан-Эрэнцав зэрэг бусад чиглэлд шинээр төмөр замын суурь бүтэц барих асуудлыг шийдвэрлээгүй байна. Мөн "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн тусгай зөвшөөрөл бүхий Бортолгой, Бортээг, Оорцог, Онч-Хараат зэрэг талбайг ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг орхигдуулсан байна.

16.11 Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 59 дүгээр тэмдэглэлийн 1.2-т заасан чиглэл зөрчигдөж сонирхлын зөрчилтэй компани уралдаант шалгаруулалтанд шалгаруулсан байна. Засгийн газар нь 2010 онд зарласан Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах уралдаант шалгаруулалтын богино жагсаалтанд үлдсэн 6 компанийн дунд уралдаант шалгаруулалтыг үргэжлүүлэн явуулсан атал уралдаант шалгаруулалтад оролцоогүй, "Энержи

Ресурс Корпораци" ХХК, түүний охин компани болох "Энержи Ресурс" ХХК-ийг шалгаруулсан байна.

16.12 Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах Төслийн компанийн 51 хувийг эзэмших "Энержи Ресурс Корпораци" нь 100 хувь гадаадын хөрөнгө оруулагчийн мэдэлд, 49 хувийг эзэмших "Чайна Шенхуа Энержи" компани нь гадаадын хуулийн этгээд байх тул Тавантолгойн нүүрсний орд шууд болон шууд бусаар гадаадын хуулийн этгээдүүдийн 100 хувь хяналтанд орж байна.

16.13 Тавантолгойн ордыг ашиглах Төслийн компанийн 51 хувийг эзэмшихээр шалгараад байгаа "Энержи Ресурс Корпораци"-ийн хувьцаа нь толгой компани болох Кайманы арлын "ММС" компанийн их хэмжээний ерийн барьцаанд байх тул төслийг хэрэгжүүлэх санхүүгийн чадамжгүй гэж үзэж байна. Санхүүгийн хүнд байдалд орсон "ММС" компанийн хувьд "Тавантолгой" ордыг ашиглах эрхийг олж авах нь бизнесийн өрсөлдөгчгүй болж, нөөцөө нэмэгдүүлэх замаар зах зээлийн үнэлгээг өсгөж, санхүүгийн хүндрэлээс гарах боломж болж байна.

16.14 Төсөлд оруулах Хөрөнгө оруулалтыг ойролцоогоор 4 тэрбум гэсэн бөгөөд энэ хөрөнгө оруулалтанд одоо ЭР-ийн Ухаа худгийн уурхайд оруулсан ЭР-ийн Ухаа худаг ордод оруулсан хөрөнгө оруулалтыг 1 тэрбум доллар тооцож байна. Гэвч ЭР-ийн Ухаа худаг уурхайд оруулсан бодит хөрөнгө оруулалт хэд болох, үнэлгээг хэрхэн тооцох, аргачлал, томьёоллолтой холбоотой заалт байхгүй байна. Гэтэл ЭР-ийг эзэмшдэг толгой компани "ММС" нь 2014 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар нийт 1 тэрбум 285 сая ам. долларын богино болон урт хугацааны өртэй гэдгийг "ММС"-ийн 2014 оны жилийн эцсийн тайланд (хуудас 14 болон notes 23, 25, 26) тусгасан байна.

16.15 Хөрөнгө оруулалтын Гэрээний заалтуудаас харахад ЭР нь 4 тэрбум долларын хөрөнгө оруулалтаа яаж ч тооцож болох, ямар хугацаанд энэ хөрөнгө оруулалтыг оруулах нь тодорхойгүй болж байна. Тус компани амалж байгаа 4 орчим ам.тэрбум долларын хөрөнгө оруулалтаа гэрээний гэрээний 30 жил, сунгалтын 30 жилийн хугацаанд нийт 60 жилийн хугацааны турш үргэжлүүлэн цувуулж хийх, эсвэл Тавантолгойн ордыг ашиглаж олсон орлогоосоо хөрөнгө оруулалт болгон буцааж хийх, эсвэл хөрс хуулалт гэх зэрэг өндөр зардалтай үйл ажиллагааны зардлыг өсгөн тооцох зэргээр хөрөнгө оруулалтыг өөрийн үзэмжээрээ хийхээр зохицуулжээ.

16.16 ЭР нь Тавантолгойн ордыг ашиглах эрхийн дагуу олж авч байгаа эрх, ашиг сонирхолыг барьцаалж хөрөнгө оруулалт босгож байна. Энэ нь тус компанийн давуу тал биш бөгөөд Тавантолгойн ордыг ашиглах эрх авснаар үүсч байгаа боломж юм. Хэрэв Засгийн газар энэ боломжийг ЭТТ-д зөвшөөрсөн тохиолдолд ЭТТ өөрөө хөрөнгө оруулалт татах бүрэн боломжтой юм.

16.17 Хөрөнгө оруулалтын Гэрээний 8.4 (с)-ийн (ii) болон (d)-ийн (vi)-д зааснаар Санхүүжүүлэгч нь Гэрээний зүйлийг бусад этгээдэд шилжүүлэх, ЭР-ийг Гуравдагч этгээдээр сольж, эрх үүргийг нь тухайн этгээдэд шилжүүлэх эрхтэй байна. Үүнээс харахад эхнээсээ Гэрээнд ингэж бусад этгээдэд барьцаалах, шилжүүлэх эрх олгосон зохицуулалт тусгаж байгаа нь ЭР нь цаашдаа ийм үйл ажиллагаа хийх зорилготой бэлтгэж, эдгээр заалтын дагуу ирээдүйд ЭР нь

Хөрөнгө оруулалтын болон дагалдах бусад гэрээнээс гарахаар төлөвлөжээ гэж үзэж байна.

16.18 Төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал нь Гадаад хэргийн яамаар хянагдаагүй, албан ёсны орчуулга хийгдээгүй гэрээний төслийг хэлэлцэх боломжгүй гэж үзэж байна. Оюутолгойн гэрээг байгуулахад Гадаад хэргийн яам албан ёсоор орчуулгыг нь хянаж, Улсын Их Хуралд өргөн барьсныг тэмдэглэх нь зүйтэй.

16.19 Уул уурхайн томоохон төслийн асуудлаар Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулагчидтай байгуулсан гэрээ бүр ямар нэг хэмжээгээр маргаан дагуулдаг, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж чадаагүй нь цагийн шалгуураар тодорхой болдог, улмаар тухайн үед ажил хариуцаж гэрээ байгуулсан албан тушаалтнуудад хариуцлага тооцох боломжгүй болдог буруу жишиг Тавантолгойн гэрээний төсөл боловсруулах явцад ч давтагджээ.

Олон арван тэрбум доллараар үнэлэгдэх Тавантолгой нүүрсний ордыг ашиглах асуудлаар хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж, гэрээний төсөл боловсруулах Засгийн газрын ажлын хэсэг анхнаасаа Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомж, Улсын Их Хурлын тогтоол, Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалын холбогдох заалт, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийг зөрчин Хөрөнгө оруулагч нартай хэлэлцээр хийж, Монгол улсад ашиггүй нөхцөл бүхий гэрээний төслийг бэлтгэсэн байна.

Иймд Засгийн газрын ажлын хэсгийн холбогдох улс төрийн албан тушаалтан болон төрийн албан хаагчдад хуулийн дагуу хариуцлага тооцох шаардлагатай.

16.20 Засгийн газар Хөрөнгө оруулалтын гэрээ болон дагалдах бусад гэрээг байгуулахдаа Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хуулийн хүрээнд үүрэг хүлээх нь зүйтэй байна.

16.21 Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомжийг зөрчиж байгаа Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдөрийн 181 дүгээр тогтоол болон 2014 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 268 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгох нь зүйтэй гэж Ажлын хэсгээс дүгнэж байна.

Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоол хүчингүй болсноор "Эрдэнэс Тавантолгой" ХК-д 1072 хувьцаа эзэмшиж байгаа иргэдийн хууль ёсны эрх ашиг хангагдах болно. Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоол хүчингүй болсноор 2010 онд зарласан Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах уралдаант шалгаруулалтын богино жагсаалтанд багтсан 6 компанийг дахин хууль, тогтоомжид нийцүүлэн сонгох боломж нээлттэй хэвээр үлдэх бөгөөд Улсын Их Хурлаас шинээр батлах тогтоолд нийцүүлэн Засгийн газар уралдаант шалгаруулалтыг үргэжлүүлэн явуулж богино хугацаанд дуусгах боломжтой.

16.22 Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн 40 дүгээр тогтоолын 3-ын 1 дэх заалт болон 2010 оны 39 дүгээр тогтоолын 1-ийн 5


дахь заалтын дагуу Засгийн газар нь Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, чуулганаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх ёстой.

Иймд Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах асуудлаар өмнө гарсан Улсын Их Хурлын тогтоолуудыг нэгтгэн Улсын Их Хурлаас Засгийн газарт баримтлах тодорхой зарчим, удирдамж бүхий тогтоол баталж, Улсын Их Хурлын зүгээс хяналт тавьж ажиллах нь зүйтэй гэж Ажлын хэсгийн гишүүд үзэж "Тавантолгойн ордыг ашиглах тухай" тогтоолын төслийг санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Ажлын хэсгээс дүгнэлт гаргахад судалсан материал болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байгаа тогтоолын төслийг хавсаргав.

Ажлын хэсгийн дарга

Гишүүд:



Л. ЭРДЭНЭЧИМЭГ

А. БАКЕЙ

Су. БАТБОЛД

О. БААСАНХҮҮ

Д. ГАНХУЯГ

С. ГАНБААТАР

Б. НАРАНХҮҮ

Д. СУМЬЯАБАЗАР

М. СОНОМПИЛ

Б. ЧОЙЖИЛСҮРЭН

